80.Прокурорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:08/

81.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:08/

82.Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:09/

83.Соёлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:09/

84.Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./19:09/

85.Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:09/

86.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:09/

87.Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:10/

88.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:10/



89.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:10/

90.Төрийн бус байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:10/

91.Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:10/

92.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:10/

93.Усан замын тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:10/

94.Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:11/

95.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:11/

96.Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:11/

97.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:11/

98.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:12/

99.Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:12/

100.Хог хаягдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:12/

101.Хувийн хамгаалалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:12/

102.Хоршооны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:12/

103.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:13/

104.Хувиргасан амьд организмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:13/

105.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:14/

*Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 18 цаг 14 минутаас хуралдааныг даргалав.*

*Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дараах хууль, тогтоолын эцсийн найруулгыг үргэлжлүүлэн танилцуулав. Үүнд:*

106.Хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:14/

107.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:14/

108.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:14/

109.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:14/

110.Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:14/

111.Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:15/

112.Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:15/

113.Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:15/

114.Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./17:55/

115.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:15/

116.Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:15/

117.Цахим гарын үсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:15/

118.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:15/

119.Шилэн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./17:55/

120.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:15/

121.Шүүхийн шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:16/

122.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:16/

123.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:16/

124.Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:16/

125.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:16/

126.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:16/

127. “Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:17/

128.“Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:17/

129.“Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-ийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспорт, бусад бараа, ажил, үйлчилгээний худалдан авах үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан

асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:17/

130.““Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:17/

131.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:17/

132.“Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:17/

133. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:18/

134.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:18/

135.Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:18/

136.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:18/

137.“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:18/

138.Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:19/

139.Төмөр замын тээврийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:19/

140.Иргэний нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:19/

141.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:19/

142.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:19/

143.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:19/

144. “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:19/

145.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:19/

146.“Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:20/

*Уг асуудлыг 18 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.*

### **Өргөн мэдүүлсэн хуулийн төслийг танилцуулах**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгээс 2024.01.12-ны өдөр өргөн мэдүүлсэн Цусны донорын тухай анхдагч хуулийн төслийг Нийгмийн бодлогын байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан нарын 4 гишүүнээс 2024.01.16-ны өдөр мэдүүлсэн Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Нийгмийн бодлогын, Хууль зүйн, Инновац, цахим бодлогын байнгын хороодод тус тус хуваарилсныг танилцуулав./18:20/

***Арван нэг.Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хаалт***

Танхимын зүүн талд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Энхбат, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын дэд дарга Ц.Батбаатар, Дотоод аудитын албаны дарга бөгөөд дотоод аудитор Я.Баттогтох, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд, Цахим парламент, инновацын газрын дарга С.Тамир, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн Ажлын албаны дарга Б.Энхмөнх;

Танхимын баруун талд Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгийн захирал Ц.Цогзолмаа, Хяналт шалгалтын хэлтсийн дарга С.Янжинхорлоо, Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн дарга Б.Батманлай, Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга Б.Лхагвасүрэн, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, Гадаад харилцааны хэлтсийн дарга С.Даваадаш, Мэдээллийн технологийн дарга хэлтсийн Г.Лхагвадорж, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам нар суудлаа эзэлсэн байв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганыг хааж үг хэлэв.

Үг хэлж дууссаны дараа танхимд Төрийн дуулал эгшиглэхэд Улсын Их Хурлын гишүүд болон хаалтын ажиллагаанд оролцогчид босож, хүндэтгэл үзүүлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хаасныг мэдэгдэв./18:36/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 11 асуудал хэлэлцэв.

**Бусад.** Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Ц.Сандаг-Очир нарын урилгаар Нийслэлийн Багануур дүүргийн иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн урилгаар “Иргэн та баялаг” сангийн гишүүдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Э.Батшугар, Н.Учрал нарын урилгаар Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн иргэдийн төлөөлөл, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн магистрын хөтөлбөрийг 2017 онд төгссөн төгсөгчдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн урилгаар Архангай аймгийн Тариат сумын Мөрөн багийн Бага сургуулийн багш, ажилтнууд Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 4 цаг 28 минут үргэлжилж, 72 гишүүнээс 57 гишүүн хүрэлцэн ирж, 79.2 хувийн ирцтэйгээр 18 цаг 38 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
14 цаг 10 минут.

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Занданшатар:** Өдрийн амгаланг айлтгая. Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, эцсийн хэлэлцүүлэг. 2.Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, эцсийн хэлэлцүүлэг. “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэг. 4-д Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл. 5-д Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл. 6-д Хяналт шалгалтын түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл. 7-д Олон нийтийн, радио телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал. Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнийг томилох, гишүүнээс чөлөөлөх тухай асуудал. 9-д Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батална. Нийт 33 төсөл байгаа. Эцэст нь Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хаалт болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д заасны дагуу гишүүн энэ

хуулийн 9.5-д заасан чуулганы нэгдсэн хуралдаанаар тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах болбол Улсын Их Хурлын даргад чуулганы хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьяаа, Бөхчулууны Пүрэвдорж, Одонгийн Цогтгэрэл, Чимэдийн Хүрэлбаатар, Амгалангийн Адьяасүрэн нараас тус тус албан бичгүүд ирүүлсэн байна. Ингээд Ширнэнбаньдын Адьяаа гишүүн үг хэлнэ.

**Ш.Адьяаа:** Эрхэм гишүүдийнхээ өнөөдрийн амгаланг айлтгая. Өнөөдөр Улсын Их Хурлын чуулган өндөрлөх болж хэлэлцэх асуудлын тухай бас санал бодлоо солилцох ийм боломж олгосонд баярлалаа. Өчигдөр нүүрсний асуудлыг шалгасан түр хороо Улсын Их Хуралд бас тайлангаа тавьж, Улсын Их Хурлаас гаргах шийдвэрийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл оруулсан байгаа. Энэ тогтоолын төсөл дээр тэр Өмнөговь аймгийн жижиг Таван толгойн хувьчлагдсан Өмнөговь аймгийн ард иргэдийн өмч хөрөнгийг бас төрд буцааж авах тухай ийм заалт орж ирсэн. Энийг болбол би бас эсэргүүцэж байгаа юм. Өнөөдөр нэгэнт өмч хувьчлалаар болсон тэр Өмнөговь аймгийн ард иргэдийн өмч хөрөнгө болсон энэ асуудлыг өнөөдөр Улсын Их Хурал ингээд нэг шалгалаа гээд буцааж авлаа гэж байгаа нь бол энэ хувийн өмчийн үзэл баримтлал, Үндсэн хуулийн үндсэн зарчимд нийцэхгүй байгаа ийм Үндсэн хууль зөрчсөн асуудал гэж үзэж байгаа юм.

Нөгөө талаараа энэ Түр хорооны сонсгол болбол ард түмэн өчигдөр харсан байх. Энд болбол би бас ингээд Түр хорооны тогтоолыг анх санаачилж, 26 гишүүнээр гарын үсэг зуруулж ингээж жил гаруй хугацаанд бид тодорхой хөдөлмөр хийсэн. Энэ зорилгоосоо хазайсан. Тэгээд сүүлд энэ Энхбаяр гишүүн чинь юу болчихоод байгаа юм бэ?

Би их харамсаж байна. Тэгэхдээ би энийг зүгээр байхгүй, энийг би ҮХЦ-д өгнө, шүүхэд өгнө. Тэр Эрдэнэс таван толгойн асуудлаар шалгагдаж байсан Дэнзэн, Батсуурь гээд хүмүүсийг бараг намайг шоронд явуулсан юм ярьж байна шүү дээ. Ийм юм ярьж болдог юм уу ер нь. Элбэгдоржид бараг үүрэг өгөөд явуулчихсан ийм юм ярьж байна шүү дээ. Энэ чинь. Нүүрсний сонсгол ярих болохоос хов жив, хэн нэгнийгээ ийм байдлаар харлуулах юмыг зохион байгуулж болдог юм уу. Энд үнэхээр харамсаж байна.

**Г.Занданшатар:** Хэлэлцэх асуудалтай холбоотой үг болохоос биш хэрэг маргаан энд ярихгүй. Ингээд Бөхчулууны Пүрэвдорж гишүүн. Бөхчулууны Пүрэвдорж алга байна. Одонгийн Цогтгэрэл гишүүн микрофонд хэл.

**О.Цогтгэрэл:** Чуулганы хуралдаан дээр үг хэлэх хүсэлт өгсөн боловч үгээ татаж байна өнөөдрийн.

**Г.Занданшатар:** Чимэдийн Хүрэлбаатар гишүүн.

**Ч.Хүрэлбаатар:** Би энэ Хөрөнгө оруулалтын хуулийн тухай ярих гэсэн юм. Энэ Хөрөнгө оруулалтын хуулийн явагдаж байгаа зүйл бол 2 хүний хоорондын толхилцоо маргаан мэтгэлцээн биш юм. Энэ бол Монгол Улсын хөгжлийн асуудал, энэ бол Монгол Улсын хөгжлийн хөдөлгүүр болсон хөрөнгө оруулалтын тухай асуудал юм. Тэгээд энэ асуудлыг улс төржүүлээд 2 хүний хоорондын асуудал юм шиг болгоод, үүнийг тойрсон их олон гүтгэлэг, хий хоосноор зохиосон үлгэрүүд явж байгаа. Тэгэхээр энэ дээр би нэг зүйлийг ярьж гэсэн. Арваад жилийн өмнө, арваад жилийн өмнө манайх экспортын зах зээл рүүгээ дэлхийн ихэнх орнуудад хэрэглэгддэг олон улсын царигаар төмөр зам барих гээд ингэхэд танкны тухай, танкаар танк дүүрэн Хятадууд ороод ирнэ гэдэг ийм үлгэрийг Монгол Улсад явж олон, олон улс төрчдийг тухайн

үеийн Их Хурлын гишүүдийг айлгасан юм. Ард иргэд ч гэсэн их нэлээдгүй нь тэр үлгэрт итгэсэн. Эцэст нь ямар үр дүн хүрсэн бэ гэхээр Монгол Улсын хөгжил 10 жилээр хойшилсон, олон тэрбум долларын хохирол Монгол Улсын эдийн засагт учирсан. Нүүрс бол өрсөлдөх чадваргүй болсон. Ийм нөхцөл байдлыг тухайн үедээ бол бий болгож байсан юм. Тэгээд одоо яг энэ хуулийн асуудлыг бол тэр танкны үлгэрийн хэлбэр лүү оруулах гэж байна.

Хэрвээ энэ хуулийг баталчих юм болбол яг тэр танк дүүрэн Хятад орж ирнэ гэдэг шигээ тийм суртал хуульгуудыг явуулж байгаа нь энэ бол туйлын хариуцлагагүй зүйл болсон. Тэгээд надад бол нэг харамсаж явдаг нэг зүйл байдаг. Тэр нь юу вэ гэхээр үгүй ээ тухайн үед би жоохон олигтойхон дуугараад өгөхгүй яав гэж боддог, бодож байсан. Хэрвээ би тухайн үедээ нэлээд энэ чинь худлаа буруу үлгэр гэдгийг нь би арваад жилийн өмнө чанга дуугарч байсан бол бол бас Монголын нийгэмд нэлээд бас эерэг зүйлүүдийг аваад ирчих байсан болов уу гэж одоо их харамсаж явдаг. Тэгээд тухайн үедээ бол яах вэ миний хариуцсан ажил биш юм байна даа гэж бодоод сулхан дуугараад явчихсан. Эцэст нь Монгол Улсын эдийн засгийг, хөгжлийг 10 жилээр хойшоо татсан ийм зүйлийг тухайн үед тэр танкны үлгэрийг зохион байгуулж байсан хүмүүс байсан юм. Өнөөдөр тэр хүмүүс яг л ард нь дахиад л гараад ирж байгаа.

Одоо бид нар энэ асуудлыг бид нар шийдэж, хэлэлцэж явахгүй болбол Монгол Улсын хөгжлийг дахиад л хойшоо татах асуудал гарч ирнэ. Монгол Улс бол аль нэг улсын колони улс бол биш. Монгол Улс бол ардчилсан улс. Хувийн хэвшилийг дэмждэг, хөрөнгө оруулалтыг дэмждэг, ард иргэдийнхээ эрх чөлөөг дэмждэг, хүний эрхийг дээдэлдэг, хувийн санал санаачилгыг нь дэмждэг, ард иргэддээ бүхэлд нь боломжийг нь бий болгохыг дэмждэг ийм тогтолцоотой улс, ийм Үндсэн хуультай улс. Тэгэхээр энэ

чиглэлээр бид нар арга хэмжээнүүдийг авч, улс орноо хөгжүүлэх чиглэлээр улс төрчид минь, Их Хурлын гишүүд минь, Монголчууд минь яг энэ чиглэлийн төлөө бид нар хичээл зүтгэл гаргаж ажиллах ёстой. Буруу юм явж байхад тэрийг хараад бид нар чимээгүй намайг муу хэлчихгүй л бол бусад нь хамаагүй гэсэн тийм бэртэгчин үзлээр бид нар хандмааргүй байна.

Улс төрийн намууд энэ дээр манлайлал гаргаж, улс орноо хөгжүүлэх чиглэлээр тууштай ажилламаар байна. Муудуулж болно. Монголчууд бас сайхан үгтэй шүү дээ. Идсэн эрүү хувхайрдаг, идүүлсэн бут ургадаг гэж. Дээд талд нь айлгах тактик, жонхууруулах тактик энэ бүгдийг гардуулан хийж, гардан хийж байгаа энэ нөхцөлд минь би улс төрчдөөсөө та бүгд маань улс төрийн эр зориг гаргаач, иргэний эр зориг гаргаач. Энэ балиар юм хийгээд жонхууруулсан ажиллагаа явуулж байхад нь энэ дээр бид нар таслан зогсоох ёстой шүү гэдгийг би энэ танхимд сууж байгаа Их Хурлын гишүүддээ хандаж хэлмээр байна. Тэгээд гишүүд минь хөрөнгө оруулалт бол Монгол Улсын эдийн засгийн хөгжлийнх нь хөдөлгүүр, суурь нь юм шүү. Энэ дээр бид нар ямар нэгэн танкны үлгэрт итгэх, 2 дахь танкны үлгэрийг бид нар энэ дээр давтах ёсгүй юм шүү гэдгийг би энд Улсын Их Хурлынхаа гишүүдэд хандаж хэлж байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Одонгийн Цогтгэрэл гишүүн нэрээ татсан. Амгалангийн Адъяасүрэн гишүүн.

**А.Адъяасүрэн:** Хүрэлбаатар сайд бас үнэн хэллээ. Энэ бол 2 хүний хоорондын хэрүүлийн асуудал биш. Энэ бол бас Монгол Улсын хөгжлийн асуудал. Хөрөнгө оруулалт бол Монгол Улсад хэрэгтэй юу хэрэгтэй, зайлигүй хэрэгтэй. Гэхдээ бид нар энд энэ танхимаас бас бид нар энэ хуулиа бас дээдлэх шаардлагатай. Хуулийг дээдлэх, хуулийг ягштал мөрдөх зарчим бол манай энэ Улсын Их Хурлын өдөр тутмын үйл

ажиллагаанд мөрдөгдөх, тавигдах шаардлага гэж би бас үздэг. Ийм ч утгаараа энэ гадаадын хөрөнгө оруулалттай энэ юу, энэ Хөрөнгө оруулалтын тухай хууль маань Үндсэн хууль, Хууль тогтоомжийн хууль, мөн Улсын Их Хурлын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын энэ конвенц зэрэг энэ бичиг баримтуудыг бол бас зөрчиж байна. Ийм учраас ингээд л нэг танкны үлгэр гээд л ярьдаг. Зарим нь 100 жилээр газар түрээслүүлэх гэлээ гээд л. Тэгээд үнэхээр бид нар энэ хөрөнгө оруулалтынхаа хуулийг шинэчлэх гэж байгаа юм бол энэ хуулиа бас бодитойгоор өөрчилье л дөө. 2013 онд гаргаж байсан алдаануудаа бас засъя л даа. Яагаад энэ хууль чинь тэгвэл Хөрөнгө оруулалтын тухай хууль юм бол хөрөнгө оруулалтынхаа босгыг аваад хаячихсан, хөрөнгөгүй гадаад хүмүүст газрыг ингээд эзэмшүүлэх тухай ийм, ашиглуулах тухай хууль ингээд ороод ирж байгаа юм.

Гадаадын төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалт гэдэг энэ б дугаар бүлгийг яагаад аваад хаячхав. Гадаадын ТӨК-үд Монгол Улсад орж ирээд гадаадын төрийн бодлогыг явуулах юм уу. Мааш олон энэ зөрчилтэй, мааш булхайтай энэ хуулийн хулгай явагдах гэж байна шүү дээ. Энэ дээр манай Улсын Их Хурлын гишүүд бүгдээрээ анхаарал хандуулж, энэ хуулийг хойшлуулж, мөн энэ хуулийг бас ингээд дахин боловсруулах ийм саналыг бол гаргаж байна.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүд хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг хэллээ. Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, бид Үндсэн хуулиа дээдэлж, төр, ард түмний язгуур эрх ашгийг эрхэмлэн дээдэлж ажиллахаар төрийн сүлд, төрийн тугийнхаа өмнө тангараг өргөсөн. Улсын Их Хурал бол ард түмний төлөөлөгчдийн байгууллага. Тийм учраас Улсын Их Хуралд 156 албан бичгээр Хөрөнгө оруулалтын хуулийг хойшлуулах санал ирсэн. Олон мянган иргэдийн гарын үсэгтэй бичиг ирсэн.

Тэгээд ард түмэн эсэргүүцэж байгаа учраас Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийг хэлэлцэх асуудлыг хойшлуулж байна.

Тэгэхдээ анхааруулж хэлэхэд энийг улс төрийн парламент суудалтай бүх улс төрийн намын удирдлагууд зөвшилцөөд, Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Бүсийн хөгжлийн тухай хууль, Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хууль гэдэг бусад хуулиудтай уялдуулж хэлэлцэх нь зүйтэй гэсэн ийм зарчмын саналыг ирүүлсэн.

3 дугаарт Адъяасүрэн нарын гишүүд намайг энэ хуулийг хэлэлцүүлсэн гэж Цэцэд өгсөн байна лээ. Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулиар зааснаар Улсын Их Хурлын дарга бол гишүүдийн хууль санаачлах Засгийн газар санаачлах эрхтэй субъектүүдийг буцаадаг эрх бүхий субъект биш. Зөвхөн олонхын саналаар Улсын Их Хурал буцаадаг. 2 дугаарт Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт зааснаар шаардлагатай гэж үзвэл нам, эвслийн бүлгүүд хуулийн төслийг урьдчилан хэлэлцэж, чуулганаар хэлэлцэх эсэх тухай санал, дүгнэлтээ гаргана гэж заасан. Улсын Их Хурал дахь АН-ын бүлэг энэ талаар хэлэлцээд санал, дүгнэлтээ гаргах эрх байгаа. Улс төр хийгээд байгаа болохоос биш энэ хуулийн төсөл нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримттай нийцээгүй байна гэж Улсын Их Хурлын гишүүд үзсэн бол үндэслэл тайлбар гаргаж өөрийн харьяалах намын бүлэг, Байнгын хороодоороо дамжуулж асуудлыг хөндөх эрхтэй.

Гэвч нам АН-ын бүлэг эвсэл Улсын Их Хурлын гишүүдээс ийм санал, дүгнэлт ирүүлээгүй. Хуулиа уншиж, хуулиа сахиж ажиллацгаа. Ийм учраас Улсын Их Хурлын гишүүдийг хуулиа дээдлэх зарчмаа сахиж ажиллахыг уриалж байна. Үндэсний язгуур эрх ашиг, Үндсэн хуульд өргөсөн тангаргаа дээдэлж

ажиллахыг сануулж байна. ингээд хэлэлцэх асуудалдаа орно.

**Нэг.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Индэрт урьж байна. Байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа явуулж, төслийг эцсийн хэлэлцүүлэгт хэлэлцүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ. Төсвийн байнгын хороо 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно. Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн төсөлд бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны

танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хувилбарын төсөл, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгийг танилцуулъя. Сангийн яамны ТНБД Жигжидийн Ганбат, ЗГХЭГ-ын дэд дарга бөгөөд ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Барсүрэнгийн Баасандорж, ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын дарга Чулуунбаатарын Дондогмаа, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж, ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газрын Хуулийн багийн ахлагч Чойжилсүрэнгийн Ариунхур.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна. Энэ Төрийн хэмнэлтийн тухай хууль бол энэ цас зудтай байгаа хөдөө орон нутагт ажиллаж байхад энэ төрийн үйлчилгээг ард иргэдэд, хөдөөгийн малчдад хүргэх талаар доголдож байгааг засаж залруулах зорилготой сайн өөрчлөлт болсон. Ингээд маргааш, өнөөдөр эцэслэн батална. Гишүүд ажлын хэсэгт баярлалаа.

14.29 цаг

**Хоёр.Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн**

газар 2024.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалд орёе. Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Өнөрболор танилцуулна. Индэрт урьж байна.

**Д.Өнөрболор:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хуралд 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа явуулж, төслийг эцэслэн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан болно. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно. Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган, төслийн агуулга, зарчим алдагдуулахгүйгээр үг хэллэг, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд  
ээ,

Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хувилбарын төсөл, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Наянтайн Ганибал гишүүнээр тасаллаа. Тогмидын Доржханд гишүүн.

**Т.Доржханд:** Баярлалаа. Тэгэхээр надад бол асуулт бол байхгүй. Тэгэхдээ анхааруулж хэлэх зайлшгүй зүйл байна. Тэгээд яагаад вэ гэхээр энийг бас Монгол Улсын Сангийн яаманд Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын дарга байхдаа 2012 онд бас сануулж хэлж байсан. Тухайн үед Монгол Улс 1,5 тэрбум долларын анхны бондыг босгож байсан юм. Тэгээд тэр үед бол мэргэжилтэн хүний хувиар хэлж байсан, даанч үг аваагүй. Үр дүнд нь өнөөдрийн нөхцөл байдал үүссэн. Одоо би өнөөдөр Улсын Их Хурлын гишүүн гэхээсээ илүү бас яг энэ чиглэлээр бас сүүлийн 20, 25 жил ажилласан мэргэжилтэн хүний хувиар үгээ хэлмээр байгаа юм. Анхааруулж байгаа юм. Юу вэ гээд тэгэхээр энэ бол маш их бэлтгэл хангаж байж хийдэг зүйл юм. Өнөөдөр Монгол Улсын ЗГ-ын бондын үнэлгээ сайн биш байгаа, 7,2 хувьтай байгаа. Өнөөдөр Монгол Улсад хөрөнгө оруулалт байхгүй байгаа. Өнөөдөр хойд хөрш маань дайнтай байгаа. Урд хөрш маань бас ковидын нөхцөл байдлаас бүрэн ангижраагүй байгаа. Үр дүнд нь манай бүс нутагт хөрөнгө оруулалт байхгүй байгаа. Ийм нөхцөлд бид нар гадаад бондыг манай Улаанбаатар хот гаргана гэдэг энэ эрхийг нээх гэж байгаа нь бол өөрөө эрсдэл юм.

Үе үеийн хотын дарга нар бол энийг нээе, бид нарт мөнгө хэрэгтэй байна, ажил хиймээр байна гэдэг саналуудыг тавьдаг байсан. Гэхдээ бэлэн биш байна л гэдэг байсан. Ядаж та нар дотоодынхоо бондын зах зээлийг нээчих л гэж ярьдаг байсан шүү дээ. Дотоодын зах зээлийг нээгээд, өгөөжийн муруй үүсгээд тэнд зах зээлийн бенчмаркет тогтоож байж энэ чинь харилцаа үүсдэг байхгүй юу. Сахилга бат явдаг, тэнд кредит рейтинг буюу тэр зээлжих зэрэглэлийг нь ингээд тогтоодог. Манай хотод тийм зүйл байхгүй. Юун гадаад битгий хэл дотоодын бондын түүх байхгүй. Одоо шууд гадаад бонд гаргана гэсэн байдлаар орж ирж байна. Тийм болохоор би нэг зүйлийг дахиж хэлмээр байгаа юм. Энэ бол хэрвээ Улаанбаатар хотод бонд гаргаад, түүнийгээ төлж чадахгүй бол энэ бол шууд Монгол Улсын ЗГ-ын үнэт цааснууд эргэж дуудагдах нөхцөл байдал үүсдэг юм шүү. Энэ бол бүх ЗГ-ын өнөөдрийн гаргах гэж байгаа бондуудад нөлөөтэй. Дефолт болох юм бол нийтээрээ дефолт болдог ийм л санхүүгийн систем байдаг нэг.

2 дугаарт энийг юунд зарцуулах юм, ямар өгөөжтэй зарцуулах юм, ямар нөхцөлөөр авах юм бэ гэдэг бол маш чухал. 2012 онд бид нар мөнгөө босгочихсон. Гоё төмөр зам барина, дэд бүтцийн санхүүжилт барина гэж баахан юм ярьж байгаад мөнгө босгочихсон. Орж ирсэн чинь төсөл нь байхгүй, ТЭЗҮ нь байхгүй. Тэгээд бараг бүтэн жил энэ дээрээ ингээд барьсан шүү дээ. Тэгээд бүр арга ядаад энийг чинь төгрөг рүү илжүүлээд нөгөө нэг арилжааны банкнууд руу ингээд байршуулж байсан шүү дээ. Тэгээд сүүлдээ ингээд зураг төсөл байхгүй болохоор баахан ингээд замын төслийг санхүүжүүлж эхэлсэн. Бодит үнэн шүү. Улаанбаатар хотод энэ гудамж гэдэг төслийг санхүүжүүлж эхэлсэн. Зураг байхгүй байхад шууд сору past хийгээд л явж байсан байхгүй юу. Тухайн үеийн Зам тээврийн яамны замын экспертүүд бүгдээрээ халаглаад ирж байсан шүү. Тэгээд өөр яах юм гээд. Тэгээд сүүлдээ

бүүр ингээд зарим хэсэг нь бол нөгөө нэг гоё үйлдвэрүүд байхгүй, зүгээр сонгуулийн санхүүжилт болоод явсан шүү дээ. Бүүр аймаг, сумын төвүүдийг сайхан ингээд тохижуулдаг, бүүр сүүлдээ нөгөө нэг наадмын талбайг хүртэл ингээд санхүүжүүлдэг ийм байдал руу орчихсон байсан шүү.

Одоо хэлэх гэж байгаа зүйл нь өнөөдөр бид нар богино хугацаатай энэ бондыг л босгох боломжтой юм. Дээд тал нь 5 жил, 3 жил гээд босголоо гэхэд энэ хугацаанд бид нар байшингаа бариад буцаагаад зарж чадах уу, чадахгүй шүү дээ. Тэгээд энэ хугацаанд чинь баахан нөгөө газрын чөлөөлөлтийн асуудлууд, дэд бүтцийн асуудлууд, төслийг удирдах асуудал энэ бүгд маань энэ чадвар маань манай Улаанбаатар хотод байгаа юу? Төсөл удирдах чадвар байгаа юу? Тэгээд энэ бүгдийгээ харгалзаж үзэж байгаад шийдвэрээ гаргах ёстой шүү. Өнөөдөр хууль өөрчиллөө гэхэд маргааш ямар хэмжээнд бонд авах нөхцөлөө энд.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ? Үг байна. Одонгийн Цогтгэрэл гишүүн.

**О.Цогтгэрэл:** Улаанбаатар хот бонд гаргах нь. Бонд гэдэг чинь тэгээд нөгөө Монгол үгээр болбол тэгээд өр л гэсэн үг тийм ээ. Энд ЗГ баталгаа гаргаж байгаа, ЗГ баталгаа гаргаж байгаа учраас Монгол Улсын болоод Монгол Улсын ЗГ-ын өрөнд тооцогдож явна. Ийм болохоор бид нар өнгөрсөн түүхээсээ сургамж авч, маш их хариуцлагатай энэ бүгд дээр бид бүгд хандах ёстой. Ер нь Монголчууд олон удаа том, том, гоё, гоё нэртэй бонд гаргаж өр тавьсан. Яг бодит байдал дээр мөнгө ороод ирдэг, бид нарын төсөл бэлэн байдаг билүү? Энэ дээр бид нар үнэхээр том алдаанууд өнгөрсөн хугацаанд гаргаж байсан.

Дахиад дээрээс нь энэ тавьж байгаа өрүүд чинь өөрөө ажил хийхийн төлөө, сая үндсэндээ сайн, муутай ч

гэсэн өнгөрсөн хугацааны бонд, өр зээлүүдээс Чингис бондын хувьд сайн, муутай ч гэсэн ямар ч байсан ажил хийх гэж, аймгуудыг авто замаар холбох гэж, эрчим хүчний системийн хүчин чадлыг өргөтгөх гэж, гудамж төслийг хэрэгжүүлэх гэж, экспортын төслүүдийг дэмжих яг ийм тодорхой ажлын зорилгуудтай байсан. Үр дүнгийн тухайд бас сайнтай муутай янз бүрийн зүйл ярьж болох байх. Тэрнээс хойших бүх бондууд, бүх өрүүд ямарваа нэгэн ажлын зорилгогүй, тодорхой зорилгогүй, өрийг өрөөр санхүүжүүлэх, өрийг хойшлуулах, нэрийг нь өөрчлөх энэ түвшнийг нь л дандаа ийм бондын харилцаа өнгөрсөн хугацаанд явж ирсэн. Тэгэхээр нийслэлээс гаргах гэж байгаа энэ бондын яг хэмжээ нь яг хэд юм бэ, энэ чинь эрх авах гэдэг нь хэмжээг нь хаанаа тогтох юм бэ? Дахиж орж ирэх юм уу Улсын Их Хурлаар.

Тэгээд 2 дугаарт нь яг ямар ажлуудад тодорхой яг ямар төслүүдэд орох гэж байна вэ? Энэ дээр ярьж байгаагаар ингээд орон сууцын төслүүдийг санхүүжүүлнэ гэхихсэн л байх шиг байна л даа. Дэд бүтцүүд, дэд төвүүд. Үгүй ээ энэ чинь тэгээд яг бонд гаргаад улсын өмнөөс ЗГ-ын нэрийн өмнөөс нийслэлээс гаргаад орон сууц бариад зарах чинь яг төрийн ажил мөн юм уу? Бид нарт Тоск гээд, Носк гээд нэг баахан жишээнүүд өмнө нь байгаа шүү дээ. Баахан жишээнүүд энэ, тэр болбол яг бизнесийн салбарын хийчихдэг нэг ажил руу ороод, тэгээд сүүлд нь нэг үр дүнгүй нэг баахан Тоск, Носкын барьсан байрууд гээд Яармагаар сүүлд нь түрээсийн үнээр нь өгч байна ч билүү, түрээслүүлнэ, өмчлүүлнэ ч билүү нэг баахан завхарсан баларсан юм болоод, одоо нөгөөдөх нь үргэлжилсэн асуудал нь шийдэгдээгүй нэг ийм л юм байгаа шүү дээ. Тэгэхээр яг ямар тодорхой төслүүд байгаа вэ? Тодорхой төсөлгүйгээр зээл аваад энэ нь ингээд үр дүнгүй Монгол Улсын өрөнд бичигддэг, энэ 33 тэрбумын өр 9 тэрбумын ЗГ-ын өр олон зүйл чинь яг энэ тооцоо судалгаа дутуу олон

хөтөлбөрүүдийн гоё, гоё нэртэй хөтөлбөрүүдийн л үр дүн шүү дээ.

Энэ дээр нэмээд өнгөрсөнд нэг ЗГ-аас 500 тэрбум Улаанбаатар хотоос 500 тэрбумын бонд гаргаж байлаа гэсэн тэр мөнгө болоод тэрний санхүүжилт, тэрний үр дүн өнөөдөр яг ямар явцтай явж байгаа юм бэ? Өнгөрсөн оны төгсгөлөөр ч билүү, намрын чуулганаар л санагдаж байна, 500 тэрбумын бонд гээд. Тэгээд энэ бүгдэд нэг хариулт өгөөч.

**Г.Занданиатар:** 83. Номинчимэг.

**О.Номинчимэг:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Ер нь болбол бид нар энэ Өрийн удирдлагын тухай хуультай дагалдуулаад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах тухай хуульд холбогдох өөрчлөлт мөн энэ өрийн зөвшөөрөл авч байгаа Улсын Их Хурлын тогтоолыг оруулсан байгаа. Энэ Улсын Их Хурлын тогтоол дээр яг энэ гадаад үнэт цаас гаргасан нийслэл тохиолдолд юунд зарцуулах вэ гэдгийг нь маш тодорхой болбол тусгаад өгсөн байгаа. Энэ маань өөрөө нөгөө Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцжуулах, түгжрэлийг бууруулах хуулийн дагуу Сэлбэ дэд төв дээрээ түшиглэсэн орон сууцжуулах төсөл, арга хэмжээ гэж байгаа. Тэгэхээр Сэлбэ дэд төвийн хувьд болбол өчигдөр бас энэ хуультай холбоотой асуулт, хариултад тодорхой хариултад өгсөн. Нийтдээ 160-аад га газрыг чөлөөлөлт хийгээд, түүн дээрээ түшиглэсэн 12 мянган айлын орон сууцыг барих ийм төсөл хийгдэж байгаа. ТЭЗҮ-ийнх нь үйл явц явж байгаа. Тэгэхээр энэ зөвхөн энэ төсөлд зориулсан, тодорхой төсөлд зориулсан бас үнэт цаас гаргаж болно гэсэн зөвшөөрлийг авч байгаа юм.

Тэгээд өмнө нь болбол энэ гэр хорооллыг орон сууцжуулах төслүүд дахин төлөвлөлтийн төслүүд бол зөндөө явж байсан. Алдаа мадагтай явсан зүйл байгаа. Гол нэг алдаа нь болохоор бид нар дахин төлөвлөлт болон газар чөлөөлөлтийг хувийн компанид даатгаад

өгөхөөр хэдхэн айлын газрыг чөлөөлөөд, түүн дээрээ ямар нэгэн нийгмийн суурь үйлчилгээ байхгүй 2 өндөр бид нарын ярьдгаар бетонон ширэнгэ болсон ийм л байшин бариад орхичихдог, тэгээд цэцэрлэг, сургуулийн хүртээмж, хүүхдийн тоглоомын талбай байхгүй, ногоон байгууламж байхгүй, орох гарц орцыг нь шийдээгүй ийм байдлаар төлөвлөлтгүй явж ирсэн. Тэгэхээр бидний хувьд болбол хотоос энд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөндөө тусгасан яг жишиг болохуйц ийм орон сууцын бусад нийгмийн суурь үйлчилгээтэй, худалдаа үйлчилгээтэй, төрийн байгууллагатайгаа, үйлчилгээ нь ойрхон байхаар ийм төлөвлөлтийг хийж хэрэгжүүлбэ гэсэн л зорилготойгоор болбол энэ төслийг бол хэрэгжүүлж байгаа юм.

Өмнөх нөгөө түрүү жил 2023 онд болбол дотоодын 500 тэрбум хүртэлх үнэт цаас гаргаж болно гэсэн шийдвэрийн дагуу хот маань энэ бэлтгэл ажлыг хийж байсан. Бидний хувьд болбол 11 сард очоод энэ бондын асуудлыг бас судлаад, түүнд зориулах гэж байгаа зориулалтууд нь болбол нөгөө эргэн төлөлтөд, эргэн төлөлтөө харах юм болбол use of process гэж ярьдаг энэ маань бас хангалтгүй юм байна. Дээр нь бас дотоодын үнэт цаас гарахад маш өндөр үнэтэй зардалтай байна. 17,5 хувь гэдэг болбол бас бодлогын хүү дээр дахиад 4,5 хувь нэмж байгаа ихэнх хөрөнгө оруулж оруулах сонирхолтой байгаа нь Монголын арилжааны банкнууд байгаа. Тэгэхээр бас зардал өндөртэй 2 жилийн хугацаатай ийм бонд байсан. Ийм болохоор эргэн төлөлтийн хувьд бас ийм байна гэдэг байдлаар одоогоор энэ бондын ажил болбол дотоод бондын ажил болбол түр зогссон байдалтай байгаа.

**Г.Занданиатар:** Наянтайн Ганибал гишүүн.

**Н.Ганибал:** Яг 3 сарын өмнө улсын төсөв баталж байх үед бол Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт орж



ирээд, энэ асуудлаар бас тодорхой асуултуудыг тавьж байсан л даа. Тэгээд харамсалтай нь өнөөдөр ингээд гуравхан сарын дараа ингээд Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулна гээд ингээд орж ирчхээд. Ер нь энэ Монгол Улсад энэ төсвийн сахилга бат, хийх ажлын энэ төлөвлөлт ийм юмнууд ер нь байна уу Ганбат даргаа? Тэгээд та хэд одоо ингээд хүний хэлсэн болгоныг дагаад ингээд явж байдаг ийм Сангийн яам гэж бас байх юм уу? Та нар өөрсдийнхөө энэ болох болохгүйг нь энэ нийслэлийнхэндээ энэ тэр хэлж өгдөггүй юм уу? Тэгэхээр энэ ЗГ ийм асуудал оруулж ирж байгаа нь ч гэсэн утгагүй байна л даа. Ер нь Монгол Улсад энэ төлөвлөлтийн асуудлууд, тэгээд бодсон санаснаа яг ингээд яг хатуу хийдэг ийм сахилга бат ийм асуудал ер нь алга. Өнөөдөр энэ нийслэлийн өр тавьж байгаад юу хэрэгжүүлэх гэж байгаа энэ төслөө хар л даа. Яагаад та нар түгжрэлийг бууруулна гэххээд орон сууц, олон давхар орон сууц барина гээд оруулж ирээд байгаа юм бэ? Энэ чинь  $1\text{м}^2$ -д,  $1\text{га}$ -д хэдэн хүн ноогдох вэ, энэ нягтаршилтын асуудлаа та нар буцаагаад сөргөөр нь тавиад орж ирж байна шүү дээ.

Түгжрэлийг бууруулна гэххээд олон давхар байшин барина гээд, тэгээд төрийн мөнгөөрөө орон сууц барьж зарна гээд ингээд явж байгаа чинь ямар ч нийслэл өөрсдийнхөө энэ түгжрэл, утааг бууруулах, алсын хараагаа хараагүй байна гэсэн үг. Ерөнхий төлөвлөлт, стратегиа олоогүй байна гэсэн үг. Эд нарыгаа олоогүй байж өнөөдөр тааралдсан болгондоо мөнгө босгоно гээд явдгаа боль. Тэр Эрдэнэс Баянбогд гээд Дорноговьд нэг нүүрсний уурхайтай. Олон улсын ж...-оор стандарт нь батлагдсан энэ уурхайг бариад, танай хуучин хотын дарга чинь дэлхийгээр нэг тэнээд явж байсан, энд хөрөнгө оруулаач гээд явж байсан. Тэгээд одоо тэр чинь ер нь юу болж байгаа юм бэ? Тэгээд дээрээс нь эргээд бонд босгоод, гадаадаас өр авна гээд. Засгийн газраас том эрх мэдэлтэй ийм

хот суурин болох гээд байгаа юм биш биз дээ. Эхлээд юмаа олж хар, метроныхоо асуудлыг өнөөдөр ярьж л байна. Тэгээд ТЭЗҮ боловсруулна гээд. Ер нь 13 онд тэр Жайкагийн гаргасан зөвлөмж чинь болохоороо баруун 4 замаас зүүн 4 зам руу далд метротой, түүнээс бусад үед нь бол илээр явна гэсэн ийм зураглал юу зөвлөмж өгсөн юм байна лээ шүү дээ. Өнөөдөр тэр үед 13 он, 23 он, 10 жилийн дараа ер нь Улаанбаатар хот хэдий хэмжээний хүн амтай болчихсон юм, өмнөхөөсөө ямар өөрчлөлтүүд орсон юм, энэ, энэ төлөвлөлтүүдээ ер нь та бүхэн ер нь олж харж байгаа юу? Юмнуудаа энэ асуудлуудаа яг бодитоор нь олж харахгүй зүгээр л нэг юм үсчүүлээд байна.

Тойрог замын асуудлуудаа ярьдаггүй, цогцоор нь эхлээд бүх юмнуудаа олж хараач, зураглалаа гаргаач. Тэгээд тэрнийхээ дараа санхүүжилтээ ярь л даа. Энэ нэг жижигхэн юм асуудал олж авахаараа тэндээ санхүүжилт хайгаад явчихна. Эргээд нэг өөр, газар өөр асуудал яригдангуут тэнд бас ингээд Монгол Улсын энэ төсвийн сахилга бат, энэ Их Хурлын бүрэн эрх рүү ингээд дайрч ороод ингээд хотын асуудлууд ингээж орж ирж болохгүй л дээ. Тэгэхээр энэ дээр шууд утгаар нь хэлье. Асуудлаа эхлээд зураглалаа гаргаад, төлөвлөлтөө гаргаад, ТЭЗҮ-ээ боловсруулаад ингэх юм бол Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот утаагүй болно гэдэг асуудлаа эхлээд Их Хурлаар оруулж ирж ярь. Ингээж асуудлыг шийдэх юм бол бид нар түгжрэлийг бууруулна гэдэг асуудлаа эхэлж оруулж ирж ярь. Тэгэхгүй түгжрэлийг бууруулна гээд орон сууц барьж байгаа чинь түгжрэл бий болгоно гэсэн үгтэй шууд адилхан.

**Г.Занданиатар:** Борхүүгийн Дэлгэрсайхан сайд хариулна.

**Б.Дэлгэрсайхан:** Ганибал гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт энэ түгжрэлийг бууруулахад бол энэ орон сууцын хороолол бол чухал ач

холбогдолтой. 1 дүгээрт энэ юу орон сууцын хороололд гэр хорооллыг дахин төлөвлөлт гэж урьд нь Бат-Үүл даргын үед ярьдаг байсан бол одоо бол энийг ингээд бүүр хорооллоор нь цогц төлөвлөгөө гаргаад ингээд Сэлбэ дэд хорооллоос эхлээд ингэж барихаар оруулж ирж байгаа 1 дүгээрт.

2 дугаарт бол таны саяын ярьдаг метроны асуудлыг 13 онд НЗД Бат-Үүл дарга ярьж байхад танайхан өөрсдөө дэмжээгүй. Одоо бид наад метрог чинь амилуулах гээд ингээд явж байгаа. Тэгэхдээ нийслэл бол энэ метрог бол өөрсдийнх өөрийнхөө төсвөөр санхүүжүүлээд ингээд явна гэдэг шийдвэр гаргасан. Тэгэхээр нийслэл энэ бүгдийг хийх өнөөдөртөө боломж бололцоо байхгүй учраас зарим том төсөв, орох энэ төлөвлөгөө энэ орон сууцжуулах юмаа бас энэ чинь Монгол Улсын ЗГ-аасаа бас дэмжлэг авч байж энэ чинь явна шүү дээ. Тийм учраас ингээд худлаа попроод байж болохгүй шүү дээ юм болгон дээр. Үгүй ээ тэр, тэгэхдээ Пүрэвдоржоо би байгаа бодит байдлыг ярьж байгаа болохоос биш юу яасан юм байхгүй. Бид бол хоосон ярьсан юм байхгүй. Өнөөдөр тэр 13 оны Жайкагийн тэр юу чинь өөрийн чинь хэлж байгаагаар тийм юу зүгээр нэг ийм зураглал биш бодитой ТЭЗҮ байгаа. Энийг энэ дээр түшиглэж энийг улам сайжруулаад, тэгээд энэ дээрээ гүйцэтгэгч зарлахаар ингээд шийдсэн юм. Тэгэхээр энэ метроны асуудал бол бас л түгжрэлийг бууруулах асуудалтай бас хамт ингээд явж байгаа.

Дараагийн дугаарт бол та өөрөө мэдэж байгаа. Бас энэ тойрог замын асуудал байгаа юм. Энэ тойрог замын асуудлыг бид бас Хятадын компанитай яриад ингээд энэ жилээс эхлээд тойрог зам болон давхар замынхаа асуудлыг шийдээд явна. Баярлалаа ийм л хариулт өгье танд.

**Г.Занданшатар:** Наянтайн Ганибал гишүүн тодруулж асууя.

**Н.Ганибал:** Энэ асуудлаа та хэд ойлгоогүй байна. Орон сууц барина гэдэг чинь, гэр хорооллын дахин төлөвлөлтийг хийнэ гэдэг чинь түгжрэлийг нэмэгдүүлнэ гэсэн үг шүү. Харин утааг бууруулна гэсэн үг байхгүй юу. Энэ 2 чинь өөрөө урвуу хамааралтай юм. Утааг бууруулангуут түгжрэл нэмэгдээд байгаа юм. Та Яармагийг мэдэж байгаа биз дээ. Тэнд нуль түгжрэл. Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг дээр 3 сургууль дагаад дүүрэн түгжрэл. Энэ хэд чинь хоорондоо урвуу хамааралтай. Эхлээд энэ логик дарааллуудаа энэ өгүүлбэрээ ч гэсэн зас. Энэ өгүүлбэр чинь буруу байна шүү дээ. Утааг бууруулахын тулд Сэлбэ дээр тэнд хороолол барих гээд байгаа байхгүй юу, тэнд байгаа яндангуудыг цөөлөх гээд байна шүү дээ. Тэгсэн чинь энэ дээр түгжрэлийг бууруулах гээд хороолол барина гээд биччихсэн л байна шүү дээ. Тэгэхээр ийм энгийн ойлголтоо ойлгохгүйгээр мөнгө босгож яах юм бэ? Хайран Монголын ард түмэн өрөнд оруулж яах гээд байгаа юм бэ? Үгүй ээ наад хүмүүсийг чинь сонсьё, сонсьё.

**Г.Занданшатар:** Борхүүгийн Дэлгэрсайхан сайд хариулъя. Дэлгэрсайхан сайд хариулъя. Сайдаас өөрөөс нь сонсьё гэж байна. Дэгийн тухай хуулиар сайд хариулах ёстой.

**Б.Дэлгэрсайхан:** Үгүй ээ үгүй энэ Ганибал гишүүн зориуд мушгиж ингээд. Бид нар энэ түгжрэлийг бууруулах гэж энэ орон сууцыг чинь цогц хөдөлгөөд дэд бүтэцтэй нь хийж байгаа юм. Тэрнээс биш урд өмнөх шиг ингээд гэр хорооллыг аваачаад ингээд ийм юу өндөр барилга бариулахгүй. Та нар анх, одоо энэ та төлөвлөгөөг нь үзэж болно. Бүр байшинг нь хүртэл бид нар 6 давхраас илүү гаргахгүй гэж хүртэл төлөвлөсөн байгаа. Та зурагтай нь танилц л даа. Тэгж байж төвлөрөл, энэ төвлөрөл бий болоод байгаа чинь хэтэрхий жижиж газар дээр өндөр байшин барьсны чинь л алдаа шүү дээ. Энэ өмнө нь ч хийгдэж ирсэн асуудал шүү дээ. Тэгэхээр энэ одоо хийж байгаа энэ Сэлбэ дэд төв бол өөрөө

дэд бүтэцтэй юм. Тийм учраас энэ дээр энэ чинь түгжрэлийг бууруулахад бас чухал ач холбогдолтой юм. Та бас энэ зураг төсөлтэй нь танилцаж болно шүү. Зөв ойлгоорой.

**Г.Занданшатар:** Энэ ер нь ЗГ-ын оруулж ирсэн бүх хууль, тогтоолыг бид нар дэмжиж баталж байгаа. Гаднаа дайн байлдаантай, дотроо цар тахалтай хүндрэлтэй үед гэж бодоод бүгдийг нь дэмжиж ирсэн. Үнэ бууруулна гээд л Үнэ тогтворжуулах хууль баталсан. Үнэ буурсан нь хаана байна, түгжрэл бууруулна гээд л өчнөөн төчнөөн тэрбум төгрөгөөр нь төсөв батлуулсан, тэр хаана байна тэгээд? Яагаад одоо энэ ЗГ-ын гишүүд орж ирээд л Улсын Их Хурлын гишүүдийг загнадаг болчихсон юм. Бүгдийг нь баталж өгөөд байхад чинь. Ер нь бас арай дэндэж байгаа юм биш үү. Хууль хэлэлцсэнгүй, хэлэлцүүлсэнгүй энэ тэр гээд. Ер нь эцсийн эцэст энэ Улаанбаатарт чинь орон сууц барьснаараа төвлөрөл, түгжрэл буурахгүй шүү дээ. Одоо та нарт хэлээд байгаа шүү дээ. Энэ Багануур, энэ Багануур, Налайх дүүргийн иргэд ороод ирчихсэн байна. Багануур, Налайх дүүргүүдийг хот байгуулах хууль яасан бэ? Тийм Сэлэнгээ хот болгохоо бод Эрдэнэбат гишүүнээ. Одоо энэ Сандаг-Очир гишүүнээр Багануур, Налайхыг хот болгоё гэсэн санаачилга гаргаад Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль ЗГ өргөн барьчих. Тэгээд Налайхтай, Баганууртай хот болгоод орон сууц барь. Ингэж байж төвлөрөл түгжрэл саарна уу гэхээс биш Улаанбаатарт метро бариад, бариад л, орон сууц бариад л улам л шавна уу, түгжирнэ үү гэхээс хөдөөгийн сэргэлт төвлөрлийг сааруулахгүйгээр энэ буурахгүй. Энэ нэгдсэн бодлого байхгүй. Ингээд орж ирээд л улсыг өрөнд баригдуулаад л.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир, Сайнбуянгийн Амарсайхан нарын урилгаар нийслэлийн Багануур дүүргийн иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл

ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе. Энэ дүүргийн иргэд чинь хот болъё гээд байна шүү дээ. Ингэж байж асуудлаа жоохон. Одоо зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй нэг санал байгаа. өрөөд Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай Улсын Их Хурлын тогтоолын талаар талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал. 1.Тогтоолын төслийн 1 дүгээр заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор нийслэл Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл арга хэмжээ нь Өрийн удирдлагын тухай хуулийн 28<sup>1</sup> дүгээр зүйлийн 28<sup>1</sup>.1, 28<sup>1</sup>.3-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд тус төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зориулалтаар гаргах нийслэлийн гадаад үнэт цааст зориулж 2024 оны төсвийн жилд ЗГ-ын өрийн баталгаа гаргахыг Монгол Улсын Засгийн газар /Оюун-Эрдэнэ/-т зөвшөөрсүгэй. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт 64,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Өрийн удирдлагын тухай хуульд, зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Тэгэхдээ эцэслэн батлах санал хураалт дээр ярина, 39-өөр батална. Одоо ингээд байх юм бол ер нь заавал улсаа өрөнд оруулж тэгж орон сууц барих, хувийн хэвшил хийнэ биз.

Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна. Өнөөдөр эцсийн батлахгүй байж бас болно шүү дээ.

**Гурав. ““Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааны талаар авах арга хэмжээний тухай”**

Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалд оръё. Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр танилцуулна. Индэрт урьж байна.

**Б.Баттөмөр:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын Их Хуралд нэн яаралтай горимоор мэдүүлсэн Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 1 сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Тус Байнгын хороо 2024 оны 1 сарын 17-ны өдрийн хуралдаанаараа тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай асуудлыг хэлэлцээд, чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж олонхын дэмжлэг авсан саналуудыг тогтоолын төсөлд нэмж тусгана, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг,

дэс дараалал, хууль зүйн техникийн шинжтэй засваруудыг хийсэн төслийн эцсийн хувилбарыг та бүхэнд хүргүүлсэн болно. Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар, Бат-Эрдэнэ, Ганибал, Ундром нар ЭТГ ХК-ийн ноогдол хаашааг ашиг тараах эсэх, Улсын Их Хурлын 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 39 дүгээр тогтоолыг хүчингүй болгосноор гарах үр дагаврын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед тогтоолын төслийн 2 дахь заалтыг хасах саналын томъёоллыг хуралдаан даргалагч Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42.2.1-д заасныг үндэслэн санал хураалт явуулахгүйгээр гүйцээн боловсруулах чиглэл өгсөн. Ажлын хэсгээс тус саналын томъёоллыг гүйцээн боловсруулж, Байнгын хорооны хуралдаанд танилцуулан санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн. Тогтоолын төслийн эцсийн хувилбарын төсөл болон Байнгын хорооны хуралдаанаар дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол, тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүгдээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж

асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Бөхчулууны Пүрэвдорж, Наянтайн Ганибал, Цогт-Очирын Анандбазараар тасаллаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Кнопоо дар, кнопоо дар, байгаа чинь надад сонин биш. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүнийг нэмж орууллаа. Жамбын Батсуурь, Мөнхөөгийн Оюунчимэг гишүүнээр тасаллаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууя.

Б.Пүрэвдорж: Яг сарын өмнө 12 сарын 16-ны, 14-ний өдөр Байнгын хорооны хурал дээр би яг энэ асуудлаар ярьж байсан. Өөрөөр хэлбэл Монгол Улсын нийт 3 сая 500 мянган иргэнд ЭТТ-н 2023 оны нийт ашгаас 2 их наядыг нь хуваарилж өгөөд, нийтдээ нэг хүнд 580 мянган төгрөгийг өг гэдэг ийм шаардлагыг хэлж байсан. Энэний дагуу энэ тогтоолын төсөл орж ирж байгаад их баяртай байна. Яагаад гэвэл яг намайг хэлж байх үед бол 2 сая 500 мянган иргэн энэ ЭТТ-н хувьцааг энгийн хувьцааг эзэмшдэг байсан. Ингээд хүмүүсээ ялгаварлаж үлдээхгүйгээр үлдсэн 12 оноос хойш төрсөн бүх хүүхдүүдийг бүгдийг нь хувьцаа эзэмшигчээр бүртгүүлж байгаад зөв гэж би үзэж байна.

Тэгээд энэ тогтоолын төслийн дагуу цагаан сарын өмнө уул нь тэр 580 мянган төгрөгийг өгчих ёстой юм байгаа юм. Гэвч сонгууль дөхүүлж байж өгөх нь МАН-д сонгуулийн оноо авахад хэрэгтэй юм шиг байна л даа. Тэгээд 580 мянга өгөхгүй юм шиг байна лээ. Миний ойлгосноор бол 430 орчим мянган төгрөг өгөх юм шиг байна. Тэгээд цаад талын 150000-ыг нь заавал өгөөрэй та нар. Энэ ЭТТ-г хувааж идэх болохоороо тийм ээ 500 доллар 1 тонн коксожсон нүүрс 500 доллар, 450 доллар, 3 жилийн хугацаанд 350 долларын дундажтай байж байхад аман дээрээс нь та нар 60 доллароор зараад, тэр их зөрүү мөнгийг хаана хулгайлж идсэн бэ гэхээр бүгдээрээ л гэрээний зуучлал, тээврийн янз янзын асуудлууд ингээд бүх хулгайн дээр

бүгдээрэнг нь хулгайлаад идэж дуусгасан шүү дээ.

Дээрээс нь том дарга нар нь бол оффтейк гэрээгээр хусаад дуусгасан. Янз янзын мухар зам тавьж байгаад л тэндээсээ тэр мухар замаа хэдэн давхар энэ хэд дахин өндөр үнээр тавив та нар. Тэгээд өөрсдөө хувааж идэх болохоороо замбараагүй идчихээд, тэгээд ард түмэндээ өгөх болохлоороо л аль болох багыг өгье л гэдэг ингэж дайрдаг ийм төр засаг байж ерөөсөө болохгүй шүү дээ. Тэгээд энэ цагаан сарын өмнө 580 мянга өгөхгүй, 120 мянгыг өгөөд цагаан сарын дараа 300 мянга орчим өгөөд ингээд л 420 мянган төгрөг л өгөх гээд байх шиг байна. Тэгээд үлдсэн 160 мянган төгрөг хаачив гэдэг асуудлыг би та нараас нэхэж шаардах болно шүү. Энэ хүмүүс чинь амьдрал хэцүү байна. Та нарын амьдрал сайн байгаа байх. Цагаан сараа яаж хийе гэж ярьж байна шүү дээ. Цагаан сараа хийж чадахгүй наадах чинь зөндөө өрнөөс өрний хооронд хүмүүс нь ядуураад нийт зээлийн чинь 75 хувь нь хувь хүний зээл байна шүү дээ. Гэтэл дэлхий дээр 75 хувь нь арилжааны зээл, 25 хувь нь иргэдийн зээл байдаг байхгүй юу. Гэтэл манайд 75 хувь нь иргэдийн зээл болчихсон. Энэ юу илэрч байна гэвэл хүмүүс цалингаа, цалиндаа цалин нь ерөөсөө амьдралд нь хүрэхгүй байна, тэгээд үлдсэн мөнгөө тэгээд ерөөсөө байнга зээлээс зээлийн хооронд амьдарч байна гэсэн ийм л дүр тооцоолол гарч байна шүү дээ. Тийм учраас энэ хурдан энэ тогтоолоо хурдан батлаад тэгээд энэ тогтоолынхоо дагуу ЗГ.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяагийн урилгаар Иргэн та баялаг сангийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал сайн сайхныг хүсэн ерөөе. Асуултад хариулна. Ажлын хэсгийг танилцуулъя. Шаравын Мөнхцэрэн ЗГХЭГ-ын Салбарын бодлого

зохицуулалтын газрын дарга, ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын дарга Чулуунбаатарын Дондогмаа, Эрдэнэс Монгол ХК-ийн гүйцэтгэх захирал Санжаагийн Наранцогт, ЗГ-ын Онцгой бүрэн эрхт төлөөлөгч Жигжидийн Ганбат, СЗХ-ны Үнэт цаасны газрын дарга Баттулгын Дөлгөөн, СЗХ-ны Хуулийн хэлтсийн дарга Жаргалсайханы Мөнх-Оргил, ЭТТ ХК-ийн Хууль, эрх зүйн газрын дарга Эрдэнийн Түвшинжаргал, Эрдэнэс Монгол ХК-ийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер Балжиннямдын Гэрэлээ, Хүүгийн Мөнхжаргал ЭТТ ХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга, Дамбын Нямдэлгэр ЗГХЭГ-ын Салбарын бодлого зохицуулалтын газрын ЗГ-ын референт. Пүрэвдорж гишүүн суу ингээд. Наянтайн Ганибал гишүүн.

**Н.Ганибал:** ЭТТ-н энэ хувьцааны асуудал бол өнөөдөр Монголын ард түмний баялгаа, баялагтаа эзэн байгаагийн илрэл л болно. Өнөөдөр зүгээр энэ тогтоолын төслийг бол дэмжиж байгаа. Тогтоолын төслийн мөн чанар бол мэдээж иргэдийн хувьцааг бол энгийн болгож, эргэлтэд орох ийм боломжоор нээж өгч байгаа. Энэний цаана бол жил болгон ноогдол ашгаа авах ийм боломжоор нээгдэнэ гэсэн үг. Ер нь өнгөрсөн цаг хугацаанд ЭТТ компани бол ард иргэддээ бол хувьцааны ноогдол ашгийг өгөх асуудал дээр бол үнэхээр хойрго ажилласан. Энэийг нээж өгч байгаад баяр хүргэе. Гол нь зөвхөн сонгуулийн жилд нэг хэдэн төгрөг өгчхөөд, дараа нь энэ тогтоолынхоо төслийг өөрчилчхөв. Ер нь жил болгон энэ ноогдол ашгаа өгдөг байх хэрэгтэй. Ноогдол ашиг авч байгаа иргэд бол энэ өөрийнхөө хөрөнгөд, өөрийнхөө энэ хувьцаа эзэмшиж байгаа компанийн үйл ажиллагаанд бол хяналтаа тавих чадамжтай болно. Түүнийхээ төлөө бас ажиллах болно.

Ер нь өнгөрсөн цаг хугацаанд ЭТТ компани ашигтай ажиллах боломжууд байсан уу гэвэл байсан. Харамсалтай нь олон оффтейк гэрээ хийгдсэн, 17 их

наядын оффтейк гэрээ хийгдсэн байгаа. Дээрээс нь ковидын үеийн тэр бөмбөлөг тээврээр маш олон их хэмжээний хулгай хийгдсэн байгаа. Тэр үед мөн төмөр замаар маш их хэмжээний хулгай хийгдэж, дундаас нь албан тушаалтнууд бол авлигал авч хулгай хийсэн нь бол Монголын ард түмэн бүгдээрээ мэддэг болсон. Жирийн нэг мэргэжилтний гэрээс л хэдэн тэрбум төгрөг гарч ирж байсныг бид бүхэн мартаагүй байгаа шүү. Ийм учраас ард түмэндээ өгөх тэр хувьцааны ноогдол ашгийг үнэн бодитоор нь гаргаж ирээд, тэр хулгай хийх боломжуудыг хаах энэ боломжоо нэн яаралтай ЗГ бас шийдэх хэрэгтэй байна.

Түрүүн бас Эрдэнэс Монгол компанийн захирал сэтгүүлчдэд өгч байгаа ярилцлагадаа бас нэг алдаатай юм яриад байна лээ шүү. Хэрвээ ноогдол ашгийг хуваарилчих юм бол энэ компани дампуурчихна гээд. Яагаад тухайн үед тэр олон оффтейк гэрээнүүд, нууц гэрээнүүд хийгдэж байхад энэ үгийг Монголын төр хэлээгүй юм бэ? Ард түмэндээ өгөх болохоор дампуурал яриад байдаг, өөрсдөө хулгай хийх болохоороо нууцаар хийгээд байдаг энэ асуудлаа болих хэрэгтэй гэж хэлбэ.

**Г.Занданиатар:** Үг хэллээ тийм ээ. Цогт-Очирын Анандбазар гишүүн.

**Ц.Анандбазар:** Баярлалаа. Яг бүтэн жилийн өмнө Монгол Улсын Их Хуралд 2023 оны 1 сарын 4-нд нэр бүхий 7 гишүүн энэ хуулийн төслийг өргөн барьсан Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар, Баттөмөр, Раднаасэд, Сэргэлэн, Адъяасүрэн, Бат-Эрдэнэ, миний бие ингээд 7 гишүүнтэй өргөн барьсан хуулийн төслийг өнөөдөр тогтоолын төсөл болгож барьж байгаад баярлаж байна. Үнэнд гүйцэгдэнэ гэдэг энэ асуудал болжээ. Яг нэг жилийн өмнө хэлж байсан үгээ би санаж байна. Энэ хувьцааг тараахгүй юм бол эдийн засаг хүндэрнэ, цаашид явах боломжгүй гээд хэлж байсан. Тэгээд одоо үнэнд гүйцэгдээд хувьцаа

тараах болохоор бас дутуу шийдвэр гаргаж байх шиг харагдаж байна. Бидний өргөн барьсан хуулийн төсөл бол 40 хүртэл хувийг Монголын ард түмэнд эзэмшүүлэхээр өргөн барьсан байгаа. Тэгээд ажлын хэсгийн дарга Баттөмөр гишүүнээс зориуд асуухыг хүсэж байна. Энэ 7 гишүүний өргөн барьсан хуулийг нэгтгэж, энэ тогтоолын төсөлд оруулсан биз? Энэ чинь өмнө нь өргөн барьчихсан шийдвэрлэгдээгүй байсан хуулийн төсөл шүү дээ.

2 дугаарт ажлын хэсгийн дарга, Ганбат бүрэн эрхт төлөөлөгчөөс асуумаар байна. Нэгж хувьцаанд оногдож байгаа ногдол ашгийн хэмжээг яаж тооцсон бэ? Хувьцааг нэг жил олгохоор ийм агуулгатай тогтоолын төсөл орж ирж байна. Энийг жил болгон олгоно гэсэн баталгаа юу байна вэ? Эрдэнэс Монгол компанийн захирал хэлсэн байна лээ. Хувьцаагаа ард түмэнд тараах юм бол компани дампуурна гэж. Хувьцаат компани ногдол ашиг тараагаад дампуурсан тийм түүх байхгүй. Тэгэхээр цаашидаа бид эдийн засгийн нэг нэгдмэл ойлголттой болохгүй бол болохгүй байна. Хэрвээ ХК юм бол жил болгон ногдол ашгаа өгдөг болмоор байна. Тэгээд энэ чинь эргээд юу гэж хардагдаж байна гэхээр жилийн өмнө өргөн барьсан хуулийг шийдэхгүй байсаар байгаад яг сонгууль дөхөхөөр хэлэлцэхээр сонгуульд зориулсан ийм шийдвэр болж харагдаж байгаа юм. Энийг 2024 онд өгнө гэсэн ТУЗ-ийн тогтоол, компанийн удирдлагын шийд юу байна вэ? Энийг асуумаар байна. Хэрвээ гаргаагүй бол энийг гаргах ямар тогтоолын заалт, зүйлийг энэ тогтоол дээр оруулж ирсэн бэ? Сонгууль дуусангуут энэ мөнгө өөр юманд яваад өгөх ийм баталгаа болох юм биш биз дээ. Өмнө өргөн барьсан хуулийн төслөөс аль, аль заалтыг нь энэ тогтоолын төсөлд оруулсан бэ? Ажлын хэсэг хэн дарга Баттөмөр гишүүнээс асуумаар байна. Өөрөө хамт өргөн барьж байсан гишүүн.

Тэнд амин чухал их чухал асуудлууд байсан шүү дээ. 1 дүгээрт 40

хүртэл хувь гэдэг бол цаашидад Таван толгойд хулгай гарахгүй байх нөхцөл байгаа юм. Хяналтын контролны пакет байгаа. Дандаа 34 хувиас доогуур хувь хувьцаанд ноогдол ашиг өгөөд, цаад талд дийлэнх олонх буюу компанийн удирдлагыг ганц эзэнтэй буюу шийдвэрлэх багцалж байгаа хувьцаа эзэмшигч гаргаж байгаагаас болоод шаардлагад хангахуйц ийм ноогдол ашгийг өгөхгүй байна гэж харагдаж байгаа. Тэгэхээр хяналтын багц дээр Ганбат дарга маань юу гэж бодож байна вэ? Ер нь ХК хяналтын багц ард түмний гарт байх юм бол хулгай дахиж гарахгүй шүү дээ. Энэ чинь хамгийн түрүүнд нүүрсэнд хулгайд хардагдсан гишүүний нэг. Харин нэг жилийн дотор үнэн тодорч, нүүрсний хулгай гэдэг юм хулгайчид нь илэрснээс нэрээ цэвэрлэж авсан баярлаж байгаа. Гэхдээ энэ нэг өнгөрсөн нэг жилийн хугацаанд эдийн засаг юу болж байна гэхээр.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Баагаагийн Баттөмөр гишүүн ажлын хэсгийн ахлагч.

**Б.Баттөмөр:** Анандбазар гишүүний асуултад хариулъя. Анандбазар нарын 5-аас тийм 6 гишүүн энэ Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 40 хүртэл хувийг ард иргэдэд эзэмшүүлье гэсэн ийм саналыг, хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн барьсан байгаа. Тэгээд энэ эхний ээлжид болбол яах вэ энэ тогтоолын төсөлд болбол энэ хуулийн үзэл санаа бол ингээд ороод явж байгаа, хуулийн төслийн үзэл санаа. Эхний ээлжид болбол юу гэхээр энэ 2012 оны 4 сарын 1-нээс хойш төрсөн 1 сая 5 мянган хүүхэд 1072 хувьцаа эзэмших эрхтэй болж байгаа. Ингэснээрээ Монголын 3,5 сая хүн энэ компанийн хувьцааг эзэмших эрхтэй бүгд тэгш эрхтэй болж байгаа юм. Ингэснээрээ болбол манай гишүүдийн өргөн барьсан тэр хууль яг жинхэнэ утгаараа тэр Баялгийн сан дээрээ сайн тусаж орж ирэх ийм нөхцөл бүрдэж байгаа 1 дүгээрт.

2 дугаарт болбол юу гэхээр ноогдол ашиг тараах асуудал энд байхгүй, энэ тогтоолд бол байхгүй. Яагаад гэхээр ноогдол ашиг тараах эрхийг болбол тэр Үндсэн хуулийн 6.2-т заасны дагуу хууль гаргаж Баялгийн сангаараа дамжуулж ноогдол ашгийг өгнө гэсэн ийм хуулийн юу Үндсэн хуулийн заалттай. Тийм учраас болбол юу гэхээр энэ ээлжит бус чуулган ойрын хугацаанд хийгээд энэ тогтоол дээрээ үндэслээд ЭТТ-н урьдчилсан балансыг үзээд мэдээж аудитаар баталгаажигдана. Тэрийг хүлээхгүйгээр урьдчилсан балансаас үндэслээд ард иргэдэд ноогдол ашиг тараах ийм боломж болбол энэ бүрдэнэ. Энэ боломжийг бүрдэхэд энэ тогтоол их онцгой ач холбогдолтой 1 дүгээрт.

2 дугаарт бол юу вэ гэхээр нөгөө энэ компаниас цаашид жил бүр тогтмол ноогдол ашиг авахын тулд бол юу вэ гэхээр компанийнхаа тэр засаглалыг сайжруулах, тэр өр авлагыг барагдуулах, шинэчлэл хийх энэ ажлыг ерөөсөө орхиж болохгүй. Энэ утгаар болбол тэр энэ тогтоолын 3 дахь заалт ингээж орж ингээж явж байгаа юм.

Тэгээд нэгэнт Ганибал гишүүн энэ тэр сая асуулаа, Анандбазар гишүүн ч бас асууж байна. Энэ тогтоолын төсөл болбол ЗГ-ын оруулж ирсэн төсөл дээр суурилж үндсэндээ болбол энэ гол шинэчлэлүүдийг хийсэн. Ингэснээр болбол энэ тогтоол батлагдсанаар болбол хувьцаа бол бүртгэлтэй болж байгаа, Хөрөнгийн биржид бас бүртгэлтэй болно. Компани дээрээ бүртгэлтэй болж байгаа. Иргэд болбол энэ өөрийнхөө хувьцааг захиран зарцуулах эрх нээгдэж байгаа. Ашигтай ажилласан тохиолдолд бол жил бүр ноогдол ашиг авах ийм эрх нээгдэж байгаа. Энэ тогтоолыг гаргахад Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар энэ дээр болбол маш их анхаарал хандуулж, бидэнтэй байнга уулзаж, ярьж, зөвлөж, бидэнд тодорхой үүрэг даалгаврыг өгч ингээж ажилласны

үр дүнд энэ тогтоол ингээж гарч байгааг би бас өнөөдөр хэлэхийг хүсээж байна.

**Г.Занданшатар:** 80 Санжаагийн Наранцогт ЭТТ ХК-ийн гүйцэтгэх захирал.

**С.Наранцогт:** Анандбазар гишүүний асуулттай холбоотой бас Ганибал гишүүн 2 нөгөө жоохон хэвлэлээр мушгиад явчихсан буруу мэдээлэл дээр байх шиг байна. Ер нь миний хариултыг бүрэн сонссон бол би иргэдийн ноогдол ашгийн талаар нэг ч зүйл яриагүй. Энэ тогтоолын 3 дугаар заалтад байгаа ТӨК-удад ЭТТ-гоос санхүүжилт хийгээд, энэ үүссэн авлага өрийн асуудлыг зохицуулалт хийх эрхийг Их Хурлаас ЗГ-т авахын тулд энэ дээр тайлбар хийсэн. 2023 оны цэвэр ашиг 3 тэрбум орчим төгрөгөөр гарна. Энийг ингээд хувь эзэмшилдээ хуваах юм бол төрийн эзэмшлийн ноогдох ноогдол ашиг 2,2 их наяд болох юм. Иргэдийнх 870 хэдэн тэрбум. Тэгэхээр иргэдийнхийгээ бол өгөх бололцоо байна. 2,2 их наядыг төрд, төрийн эзэмшлийн ноогдол ашигт ингээд бэлэн мөнгөөр төвлөрүүлэх бололцоо энэ компанид бол байхгүй, энэ компани төлбөрийн чадваргүй болно гэдэг энэ талаар ярьсан. Энийг бол энэ утгаар нь зөв ойлгох ёстой.

Сэтгүүлчдийн асуултад хариулах үед бол тоонууд яригдсан байгаа. Бас өчигдөр ингээд 2 өөр зүйлүүд асуугаад, тэрийг нь нийлүүлж ингээд нэг юм ярьсан юм шигээр бас гуйвуулаад явуулаад байна лээ. 2023 оны хувьд бол саяын хэлсэн ингээд яг иргэдийн ноогдол ашгийн хэмжээг зүгээр бүх цэвэр ашгаа хуваана гээд л тооцоход болбол 233 мянга орчим төгрөгийн ноогдол ашиг хуваарилагдахаар тооцоо зүгээр гарч байгаа. Мэдээж энэ ноогдол ашиг хуваарилах шийдвэрийг бол яг Компанийн тухай хуульд заасан эрх бүхий этгээд гаргана. Их Хурал дээр бол энэ шийдвэр гарахгүй энэ тогтоол дээр. 2022 оны ноогдол ашгийн тухай яригдах үед бол компанийн зүгээс бол бид нар нэгэнт хувьцаа эзэмшигч бол ноогдол ашгаа бас



хуваарилах нь зүйтэй гэдэг байр суурийг ноднин жил хуулийн хугацааны үед яригдсан. Одоо ч тэр байр суурь хэвээрээ байгаа. Гэхдээ тухайн үед бол компани онцгой бүрэн эрхт төлөөлөгч тавигдаад, онцгой дэглэмд ажиллаж байгаа учраас энэ асуудлыг яг Компанийн тухай хуулиар ингээд шийдээд явах энэ хууль, эрх зүйн асуудал байна гээд хэлэлцэлгүй, шийдвэр гаргалгүй ингээд хойшлуулсан. Энэ талаар бол ТУЗ-ийн дарга Бямбасүрэн дарга ярьсан байна лээ. Тэгэхээр иймэрхүү ингээд дандаа ялгаатай асуудлууд тус тусдаа асуудлууд, тус тусдаа тоонууд ингэж ярьж байгаа. Энийг ингээд бүгдийг нь иргэдийн ноогдол ашиг юм шигээр ойлгож ингэж бас ингэж тайлбарла, мушгиад тайлбарлаад байгаа юмнууд бол бас гадуур яваад байгаа.

Тэгэхээр энэ дээр болбол ийм зүйлийг хэлнэ. Энэ компанийн шинэчлэлийн, засаглалын шинэчлэлийн хүрээнд бол нэлээдгүй ажил хийж байгаа. Энэний хүрээнд бол ЭТТ компанийн хараат бус гишүүд бол 49 хувь байгаа. 34 хяналтын багцаас ч их болсон. Өмнө нь бол 11 гишүүнтэй байсан. Тэрний 3 гишүүн нь хараат бус иргэдийн төлөөлөл гэж үздэг байсан бол одоо 9 гишүүний 4 нь хараат бус гишүүн байгаа. Хараат бус гишүүдийг бид олон нийтээс нээлттэй сонгон шалгаруулалт явуулж байгаа. Хувьцаа эзэмшигчийн хурал дээр бас энэ талаар бол иргэдийн төлөөлөгч маш тодорхой ярьсан. Энэ хараат бус гишүүний сонгон шалгаруулалтад бол хэн ч оролцох бололцоотой. Гол нь болбол энэ иргэдийн эрх ашгийг хамгаалж хамгаалах тийм туршлага, нэр хүнд, нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүс байх нь илүүтэй гэж үзэж энэ жил ноднингийн хувьцаа эзэмшигчийн хурлаар томилогдсон ТУЗ-ийн хараат бус гишүүд бол харьцангуй нийгэмд нэр хүндтэй бизнесийн академик туршлагатай ийм хүмүүс сонгогдон ажиллаж байгаа юм. Тэгэхээр энэ засаглалын хувьд болбол нэлээд сайжирсан. Цаашидаа бол бид энэ ноогдол ашгийг бол компани ашигтай л

ажилласан бол ноогдол ашгийг хуваарилдаг байх энэ зарчим болбол мөрдөгдөөд ажиллаад.../минут дуусав/

### **Г.Занданишатар:**

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Би 2 зүйл асуугаад орхиё. Ер нь бол яах вэ энэ оруулж ирж байгаа Улсын Их Хурлын тогтоолын төслийг бол дэмжиж байгаа. Ганцхан нэг тодруулах гээд байгаа юм болбол энэ Таван толгой гэж дэлхийн хэмжээний том баялаг байна. Энэ бол үнэхээр зовлон үзсэн гэж хэлж болно. Олон хүмүүс их сайхан зүйлүүд ярьдаг. Яг бодит байдал дээр бол энэ Таван толгойн ордыг чинь өрмийг нь аваад хувийн компанидаа өгчихсөн шүү дээ. Тэндээс одоо эхэлсэн. Та бүхэн мэдэж байгаа Ухаа худаг Энержи ресурс гэдэг компанид Эм Си Эс компанид өгчихсөнийг та бид бүгдээрээ мэдэж байгаа. Ингээд л энэ цагаас хойш энэ Таван толгой компани байгуулсан. Энэ Таван толгой компани байгуулагдсан цагаасаа энэ бүх захирлууд нь дандаа хулгай худал асуудлуудад орсон. Энийг бол энэ 30 жилийн хугацаанд зарим үед хамтарч, зарим үед дангаараа Засгийн эрх барьж байсан Ардын нам, АН хоёр 2 бие рүүгээ түлхээд бол хэрэггүй. Би ийм байр суурийг би олон удаа илэрхийлж хэлж байгаа шүү.

Тухайлбал 2012-оос 2016 онд АН Шударга Ёс эвсэл Засгийн эрхийг барьж байх үедээ энэ Таван толгойн ордыг Хятадын компанид 100 жилээр өгөхөөр ийм Их Хурлын шийдвэр тогтоолын төслийг оруулж ирсэн шүү дээ. Тэгээд энийг чинь бүр үхтлээ эсэргүүцэж байж цөөхөн хэдэн юмнууд. Харин заяатай нь бол энэ Их Хурлын даргаар Зандаахүүгийн Энхболд сууж байсан, бид бас тууштай нэг байр суурин дээр байж байж энийг нэг авч үлдсэн. Дараагаар нь мөн эгзэгтэй ийм үед хоёрхон хүний саналаар энэ Таван толгойн ордыг авч үлдсэн. Ингээд Оюун-Эрдэнийн ЗГ энэ нүүрсний хулгай нүүрс дагасан энэ далд эдийн засгийг ил болгохтой холбоотой ЗГ

дээр бол мөн л хэцүүхэн хүнд нөхцөл байдалд л шийдвэр гаргаад, өнөөдөр бид нар энэ ЭТТ компани 3 орчим их наяд төгрөгийн ашигтай гарахаар төлөвтэй. Эндээсээ иргэддээ өгөөжийг нь хүртээе гээд яриад сууж байна шүү дээ. Тэгэхээр болбол цаашидаа энэ дахин хулгай худал ийм булай юманд нэрвэгдэхээргүй засаглалыг нь сайжруулаад, түрүүний ярьж байгаа шиг тэр ТУЗ элдвийн юм нь бүр бодитойгоор нэг эх орныхоо төлөө нэг чин сэтгэл зүрхээ гаргаад нэг ажиллах ийм хүмүүс байдаггүй юм уу гэж би удаа дараа асууж байгаа шүү дээ. Ингээд энийгээ нэг ажиллуулаад явах хэрэгтэй байгаа юм.

Энд ЗГ шийдвэр гаргаад, бүрэн эрхт төлөөлөгч томилоод, тэгээд энэ хүн болбол томилогдсон энэ Ганбат бол төрд бэлтгэгдсэн ийм хүн учраас ямар нэгэн илүү, дутуу хөдөлгөөн хийсэнгүй. Энийг үр ашигтай ажиллуулахын төлөө бүх өөрийнхөө хуримтлуулсан туршилага, мэдлэг, чадвар, хүч хөдөлмөрийг зориулж ажиллалаа гэж би бол ингээж энэ багт нь бол сайшааж баяр хүргэж байгаа юм. Дахиад би баяр хүргэе. Цаашидаа бол яг энэ зарчмаар л энэ компанийг удирдаж явах хэрэгтэй юм л даа. Ер нь болбол энэ Монгол орны энэ байгалийн баялагтай холбоотой юм тун хүнд. Сая яригдаж байгаа Хөрөнгө оруулалтын гэрээний цаад талд чухам юу нуугдаж байна вэ? Нөгөө Хармагтай ордоос өгсүүлээд нэг томоохон орд газруудыг хулгай хийх гээд ингээд сууж байгаа юм биш биз гэсэн ийм хардлага байгаа. Би яагаад энийг хэлж байгаа вэ гэхээр зэрэг тэр Оюутолгойн ордод гэрээ хийх тухай асуудал яригдахад чинь 2005, 2006 оноос бүр Сингапурт очиж сууж байгаад энэ Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулаад, Монголын тал энэ байгалийн баялагтаа үнэ төлбөргүй ямар нэгэн мөнгө хөрөнгө төлөхгүйгээр хувьцаа эзэмших тийм эрхийг нь үгүй хийчихсэн хуулийн төслийг оруулж ирж байгаад тэгээд Ivanhoe Mines Friedland гэдэг луйварчинд өгсөн шүү дээ. Тэгээд тэр нь дамжаад Риотинто-д өгөөд, өнөөдөр ямархуу байдалтай явж байгаа

лээ. Энэ зөвхөн хуулийн үг, үсгийн зассанаар л тэр 34 хувьд ноогдох өр гэхэд бид нар чинь 2,4 тэрбум долларын өрөнд уначхаад ингээд байж байсан юмыг бид нар энэ Их Хурал нэг юм засаж залруулаад тэрийг нь тэг болгож чадлаа шүү дээ. Ирээдүйд үүсгэх 22 тэрбум долларын өрнөөс сэргийлж чадлаа. Иймэрхүү л нөхцөл байдалтай юмнууд байдаг учраас энэ дээр онцгой анхаарах хэрэгтэй.

Нөгөө нэг юм нь болбол нөхдүүд минь би та бүхэнд байнга хэлж байгаа юм. Энэ улс орны газар, газар шороотой холбоотой юман дээр туйлын анхаарал болгоомжтой аливаа шийдвэр юмыг гаргах хэрэгтэй. Монголчууд чинь ярьдаг шүү дээ өөрийнхөө орон гэрээр тоглож болохгүй шүү гэж. Энэ шийдвэр гаргах түвшинд.../минут дуусав/

### **Г.Занданиатар:**

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн гүйцээчих.

**Б.Бат-Эрдэнэ:** Тэгээд яах вэ би нэг минутдаа хэлж байгаа шүү дээ тийм. Тэгээд энийгээ сайн анхаар. Би түрүүн нэг цаг багтахгүй бас асуугаагүй байна. Зүгээр Ганбат дарга хариулаад өгвөл энэ чинь ингээд нөгөө Таван толгойн тэр орд газрын ашиглахтай холбоотой асуудалд алдаа гарчихсан. Тухайлбал маш их нүүрсний овоолго бий болсон. Тэр нь зүгээр ингээд шатаад байж байдаг тухай асуудал гарсан. Энэ орд газрыг зүгээр ингээд сорчлоод ашиглаад байгаа асуудал яригддаг шүү дээ. Тэгэхээр энэ дээр ямар төлөвлөгөө энэ урд нь гарсан алдаатай байдлуудыг засаж залруулж чадсан уу, үгүй юу? Энэ чинь олон жилийн хугацаанд энэ Монголын ард түмэн, Монгол Улсын хөгжилд чинь гол хэрэг болох л том орд шүү дээ. Тэгээд эндээс хариулт өгч болох уу? Тогтоолын төслийг бол дэмжиж байгаа юм.

### **Г.Занданиатар:**

Жигжидийн Ганбат 82 Онц бөгөөд бүрэн эрхт төлөөлөгч.

**Ж.Ганбат:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Яах вэ Эрдэнэс Тавантолгойн ингээд бүлэг орд гээд энэ Өмнөговийн Цогтцэций сумд ингээд байрлаж байгаа. Энэ дээр Эрдэнэс Тавантолгой компани, Энержи ресурс, Таван толгой гээд энэ компаниуд үйл ажиллагаа явуулж байгаа. Яах вэ ЭТТ компани, орон нутгийн Тавантолгой гэж нэрлэгддэг энэ компани хооронд бас ЭТТ компанийн лицензтэй талбай руу олборлолт хийсэн энэ асуудлууд бол үүссэн байсан. Энэ асуудлыг өнгөрсөн оны сүүлээр бол цэгцлээд, 47 тэрбум төгрөгийн өр төлбөрийг бол ЭТТ компанид орон нутгийн жижиг Таван толгой төлж барагдуулаад, энэ нэг мөргөцөг зөвшөөрөлгүй авсан асуудал бол дууссан байгаа.

ЭТТ компани өөрөө 13 жилийн түүхтэй компани. 13 жилийн хугацаанд ер нь ЭТТ компани дандаа сайн чанарын нүүрснүүдээ сорчилж бол борлуулдаг ийм байсан. Үүн дээр бол бид энэ алдааг бол давтахгүйн тулд ЗГ-аас тогтоосон онцгой дэглэмийн хугацаанд бид ЭТТ компаниас олборлож байгаа ер нь бүхий л чанарын нүүрсийг борлуулах бол зорилт тавьсан. Тэгээд одоо яг энэ дээр бид нар сайн чанарын коксжих нүүрс, сул коксжих нүүрс, эрчим хүчний нүүрс гээд энэ 3 нүүрсийг бол бид өнгөрсөн 22 оны 2 сараас эхлээд биржээр арилжаалаад, ерөнхийдөө бол харьцааг бол бид яах вэ эрчим хүчний нүүрсийг ер нь түлхүү зарах талд нь бол бид онцгой анхаарч, ер нь цаашид ЭТТ компани өөрсдөө олборлож байгаа нүүрсийг сорчлохгүйгээр ингэж зарах нь зүйтэй юм байна гэдэг ийм байдлаар. Сорчлоод зараад эхлэхээр яах вэ ерөнхийдөө эрчим хүчний нүүрсний овоолго их хэмжээгээр үүсдэг. Үүнийг дагасан саяын гишүүний ярьж байгаа ингээд шатах асуудал, хаягдал болж хаягдах, чанар нь муудах ингээд ашиглагдахгүй овоолго үүсэх гэдэг ийм асуудлууд үүсэж байсан учраас энэ асуудал дээр яах вэ онцгой анхаарч, одоо бид бол ЭТТ компани бол сорчлохгүйгээр

олборлож байгаа бүхий л чанарын нүүрсээ зарж борлуулна гэдэг ийм юмыг.

Нөгөө талдаа яг энэ Тавантолгойн бүлэг орд дээр бид одоо үйл ажиллагаа явуулж байгаа Энержи Ресурс, орон нутгийн Тавантолгой дээр бол бид бас харилцан ойлголцож, хэн нэгнийхээ талбай руу цөмөрч олборлолт хийхгүй, ЭТТ компанийн лицензийн талбай дээр ямар нэгэн овоолго үүсгэхгүй энэ асуудлыг бас компаниуд хоорондоо тохиролцож, гэрээ байгуулж зохицуулах ийм арга хэмжээнүүдийг бол авч ажиллаж байгаа.

**Г.Занданшатар:** Жамбын Батсуурь гишүүн асуулт асууя.

**Ж.Батсуурь:** Намрын чуулган өндөрлөх гэж байна. Тэгээд чуулган өндөрлөх энэ цаг өдрүүдэд Улсын Их Хурлын олон тогтоолууд орж ирж байна. Тэгээд бас өмнөх Байнгын хороо чуулганууд дээр зарим тогтоолын ач холбогдол бодит үнэн талаар санал бодлуудаа хэлж байсан. Яг үнэндээ 2016 онд өнөөгийн эрх баригчид маш олон зүйлийг амлаж гарч ирсэн. Долларын ханшийг барина, утаагүй болгоно, түгжрэлгүй болгоно, түгжрэлийг бууруулахад усан тээвэр ортол хэрэглэнэ, дүүжин тээвэр хэрэглэнэ, мөн төрийн өмчийн компаниудыг задална, хувьцаа юмнуудыг өгнө гээд маш олон авлигыг бууруулна, төрийн оролцоог багасгана гээд. Тэгээд энэ бүх үйлдэл нэг л мэдэхэд 8 жил болоод өнгөрсөн байна. 8 жилийн өнөөдрийн байдлаас харахад бүх зүйл урвуугаараа эргэсэн. Долларын ханиш 2, 3 дахин, түгжрэл бүүр тэг зогсож байгаа, утаанд төөрөхөөр болсон, юмны үнэ тэнгэрт хадсан, амьдрал ядуурал буурсан, зээл нь нэг хүнд оногдох нь 34, 5 сая 2 дахин илүү болсон гээд. Тэгээд энэ хаврын чуулган хавар болоод дөхөөд ирэнгүүт энэ олон тогтоолуудаар ард түмнийг бас л шилний цаанаас чихэр долоолгох гэж байна л даа.

Ер нь бол бид хэлээд байдаг. Төрийн өмчийг задлах, ХК-удыг бий болгох, олон нийтийн хяналтад оруулах энэ дэлхий нийтийн дэг жаягийг дагах л ёстой л доо. Дэлхий нийт. Тэгэнгүүт өнөөдрийн эрх баригчид өнгөрсөн 8 жил бол бүгдийг төвлөрүүлэн татсан, бүгдийг төрийн өмч болгосон. Тэнд хаана төрийн өмч хаана вэ тэнд авлигал байж байдаг. Тэгээд авлигал авсан 40 их наяд хүртэл юм яригдаж байдаг. Тэгээд тэрэндээ хариуцлага тооцохгүй. Тэгээд өнөөдрийн энэ тогтоолоор орж ирж байгаа би юун дээрээс 2 зүйл асууя гэж бодож байгаа юм. ЭТТ ер нь байгуулагдсан цагаасаа хойш яг хэдэн их наядын орлого олсон юм бэ? 1 дүгээр асуудал.

2 дугаарт ЭТТ байгуулагдсан цагаасаа өнөөдрийг хүртэл хэдэн их наядын ашигтай ажилласан юм бэ? 2 дугаар асуудал.

3 дугаар асуудал нь ЭТТ жилийн дундаж ашиг хэд байдаг юм бэ гэсэн асуултуудыг авах гэж байгаа юм. Тэгэхээр асуудлууд гараад ирнэ л дээ. Үүнээс хувьцаанд 1072 гэж ярьдаг. Энэ хувьцаанд Монгол Улсын нийт иргэдэд хэдийг хуваарилсан байдаг юм гэсэн бас 4 дүгээр асуулт байна. Тэгээд би Их Хурал, ЗГ-тай холбоотой асуудал дээр бол хэдийгээр энэ тогтоол орж ирж ард түмэнд 5, 3 төгрөг очих мөн энэ компани олон нийтийн хяналтад орох боломж бүрдэж байгаа ч гэсэн яагаад 24 оны хавар гэж? Би 20 оны хаврыг санаж байна. Ямаа бэлчээртээ явж байхад нь ноолуурынх нь мөнгийг өгч байсан. Ямааны ноолуур 60, 70 мянгаар тогтож байхад үгүй ээ бид нар 100 мянгаар авчихъя гэж байсан. Үр дүн нь юу байсан. Та хэд 60 хүний суудалтай байсан 65 суудал авч байсан. Өнөөдөр 126 Их Хурлын гишүүнээс ЭТТ-н хувьцааг тарааж өгчхөөд, ахиад жаахан худлаа яриад орчихвол, 126 суудлаас бас ихэнхийг нь авчих болов уу гэж ингэж улс төрийн шийдвэрүүд гаргаад байгаад л харамсаад байгаа юм. Тэгэхдээ би саяын авсан асуултын 4 асуултын дараа би бас

саналаа хэлье л гэж ингэж бодож байна. Хэдийгээр дэмжиж байна. Гэхдээ яагаад энэ тогтоолууд, иймэрхүү тогтоолууд сонгуулийн өмнө болж байгаа юм бэ л гэсэн ийм асуудал байгаа.

**Г.Занданшатар:** Хэн хариулах юм бэ? Баагаагийн Баттөмөр гишүүн, ажлын хэсэг хариулах уу?

**Б.Баттөмөр:** Ер нь бол бид нар бол мэдэж байгаа шүү дээ энэ ковид гэж айхтар өвчин гарч дэлхий нийтээр хил хаалттай байсан. Тэгээд энд болбол нүүрсний гарч байгаа нүүрсний хэмжээ болбол их багассан. 23 оноос эхлээд үндсэндээ ч хил чөлөөтэй болоод манай урд талын зах зээлд бол нүүрсний эрэлт болбол нэлээн их сайн болсон. Тэгээд Монгол Улсын Их Хурлаас бид нар манай Батсуурь гишүүн бид нар оролцож байна Уул уурхайн биржийн хуулийг бол баталсан. Энэ биржээр нүүрсийг арилжаалдаг болсноор аман дээрээс нь 60 доллароор худалдаж байсан нүүрс 187 доллар болсон. Эрчим хүчний ам дээрээс нэг тонн нүүрс 9 доллар худалдаж байсан болбол 73 доллар болсон. Энэ компанийн үр ашиг болбол энэ 23 онд болбол их үр ашигтай гарч байгаа юм. Тэгээд ер нь бол нөгөө шилний цаанаас чихэр долоолгоно гэж 12 оноос хойш л 1072 хувьцаатай, 2 сая 500 хүн байж байдаг. Гэтэл тэрнээс хойш төрсөн хүүхэд нь хувьцаа авч чаддаггүй.

Тэгээд энэ тогтоолын бол үндсэн гол зорилго болбол Монгол Улсын 2 сая, 3 сая 500 мянган хүнийг жигд хувьцаатай болгож байгаа юм. Ингэснээрээ энэ цаашидаа энэ ХК-аас хувьцааныхаа өгөөжийг авах асуудал яригдах юм. Энэ төсөлд болбол өгөөж тэр хувьцааны ашиг өгнө гэсэн ийм нэг ч үг, үсэг байхгүй байгаа юм. Баялгийн сангаа байгуулж байгаад, тэр Баялгийн сан дээрээ Үндсэн хуулийн 6.2-т заасны дагуу ард иргэдэд тэр хувьцааны ноогдол ашигийг өгөх ийм боломж болбол бүрдэнэ. Тэр Баялгийн сан ярих үед л ингээд ярих ёстой гэж ингэж бодож байна 1 дүгээрт.

2 дугаарт хэрвээ ноогдол ашигаа энэ компаниас тараах юм болбол үр ашигтай, үр ашиг нь одоо гарч ирж байгаа учраас 22 онд ийм үр ашиг байгаагүй байсан. 23 онд үндсэндээ урьдчилж тооцоноор бол 3 их наяд орчим төгрөгийн үр ашиг гарах байх гэж. Тэгэхдээ баланс нь гараагүй байна л даа. Ийм цаг үе нь ингээж тохирч байгаа юм Батсуурь гишүүнээ. Энэ тэрийг манай Эрдэнэс Тавантолгой, Тавантолгой компанийн улсууд хариулъя. Ганбат гишүүнээр.

**Г.Занданишатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын Батиугар, Пүрэв-Очирын Анужин, Ням-Осорын Учрал нарын урилгаар СХД-ийн иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс та бүхэнд сайн сайхныг хүсэн ерөөе. 82 Жигжидийн Ганбат Онц бөгөөд бүрэн эрхт төлөөлөгч.

**Ж.Ганбат:** Батсуурь гишүүний асуултад хариулъя. ЭТТ Компани 2011 оноос яг экспортоо эхэлж үйл ажиллагаа нь эхэлсэн байдаг юм. 2011 онд 5,2 тэрбумын ашигтай, 2012 онд 14 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж байгаад, 12, 14, 15, 16 онуудад дандаа алдагдалтай ажиллаж байсан. Ингээд 17 онд 461 тэрбумын ашигтай, 18 онд 807,6 тэрбумын ашигтай, 19 онд 1 их наяд 35,6 тэрбум төгрөгийн ашигтай гээд хамгийн өндөр үе нь 19 ковидын өмнөх жил байсан. Ковидын үед 20 онд 149 тэрбум, 21 онд 110,8 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж байсан. 22 оны жилийн эцсийн байдлаар 1,3 их наядын ашигтай ажилласан. 2023 оны юуны 3 дугаар улирлын байдлаар 2,7 их наяд, хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр бид 3,1, 3 их наядын ашигтай ажиллахаар ингээж байгаа.

Тэгээд нийт энэ хугацаанд яах вэ ингээд үзэхээр бид ЭТТ компани нийт 6,6 их наядын ашигтай ажилласнаас зөвхөн 23 оны ашгийг нь бид 23 онд 3 их наяд

төгрөгийн ашигтай, 22 онд бид нар 1,3 их наядын ашигтай ингээж бол ажилласан байгаа. Ер нь цаашид ЭТТ компанийн үйл ажиллагааг тогтворжуулаад, бид хамгийн оргил үед нь энэ ЭТТ компанийн ер нь яг хүчин чадал нь ямар юм бэ гэдгийг л би тогтоох гэж үзсэн 22, 23 онд ялангуяа. Тэгэхэд ЭТТ компани жилд бол 30 сая тонн нүүрс борлуулах бол бүрэн хүчин чадалтай, шинээр бол бид яг энэ үйл ажиллагааг тогтворжуулаад, цаашаа ажиллаад байх юм бол бид жилд бол 2-оос 3 их наядын ашигтай тогтвортой ажиллаад байхад бүрэн боломж байна гэдгийг нь л сая энэ ЗГ-аас онцгой дэглэм тогтоосон 22 оны сүүлийн сар, 23 оны жилийн хугацаанд бол бид ингээж бол энийг нотолж харуулсан юм.

**Г.Занданишатар:** Жамбын Батсуурь гишүүн тодруулж асууна. Бат-Эрдэнэ гишүүнээ.

**Ж.Батсуурь:** Тэгэхээр хамгийн гол нь бид нар энэ авлигал хээл хахууль янз бүрийн юмнаас салахын тулд бол энэ төрийн өмчийн компаниудыг л хурдан олон нийтийн хяналтад оруулж ингээж хувьцааг нь арилжих л ёстой л гэж л би боддог л доо. 92 онд анх Хөрөнгийн биржийн анхны дилер хийж байлаа. Тэр үед л маш хурдан хугацаанд Монголын бүх ААН-үүдийг олон нийтэд дээр гаргачихна гэсэн. Үндсэндээ 32 жил болчхоод байхад яг тэр үг одоо л бас яригдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр өнөөдөр цаашидаа тогтвортойгоор 3 их наяд орчмын ашигтай ажиллаад байхад зөвхөн л бид нар ЭТТ-гоосоо жилд 1 хүнд бараг сая орчмын ойролцоогоор дивидент оногдох нь байна шүү дээ. Тийм учраас энэ шиг бусад уур уурхай ТӨК-удаа задалж, олон нийтийн хяналтад оруулах л ийм тогтоолууд, хуулийн төслүүдийг л оруулж ирмээр байна л даа.

**Г.Занданишатар:** Тогтоол дээр ер нь тодруулга байхгүй, таныг гэж бодоод л тодруулж байна. Баттөмөр гишүүн, Баагаагийн Баттөмөр гишүүн.

**Б.Баттөмөр:** Тэр 3 их наяд төгрөгийг болбол ингээд сая төгрөгөөр тараачихаар тэр компанид юу ч үлдэхгүй болчихож байгаа юм. Компания шинэчлэх хэрэгтэй байна, техник технологийн шинэчлэл хийх хэрэгтэй байна 1 дүгээрт. 2 дугаарт болбол 3,9 их наяд төгрөгийн өртэй байгаа энэ компани тийм ээ. Тийм учраас өрнийхөө нэг хэсгийг бас төлөх шаардлагатай. Тийм учраас болбол тэр яг Баялгийн сангийн хууль дээр одоо яг хувьцаа тараах үедээ хэдүүлээ их маш сайн ярих ёстой юм тийм, маш сайн ярьж байж шийдэх ёстой гэж тийм. Ер нь бол урьдчилсан тооцоогоор сая бас яригдаж л байна. Ер нь 500 орчим төгрөг нэг хүнд 500 орчим төгрөг нэг 1072 хувьцаанд 500 орчим төгрөг оногдоно гэх юм бол 1,8 их наяд төгрөг л гарах юм байна лээ. Тийм учраас бол өнөөдөр болоогүй байхад нэг их мөнгө төгрөг яриад байх нь бас учир дутагдалтай.

**Г.Занданшатар:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн. Дараа нь санал хураалттай, гишүүд чуулгандаа цуглая.

**М.Оюунчимэг:** Энэ манай Улсын Их Хурал ер нь энэ Хяналт шалгалтын түр хороо байгуулж, асуудалд олон нийтэд нээлттэй мэдээлэл өгдөг болсон нь үнэхээр их чухал гэдгийг олон үйл явдал харуулж байгаагийн нэг нь энэ ЭТТ-той холбоотой асуудал. Энэ нүүрсний экспорт, импорт, тээвэрлэлт гээд л олон асуудал харуулж байна л даа. Өнөөдөр сая хэлж байна гишүүд. Яагаад 20 оноос хойш энэ ашгаа өгөөд байж болдоггүй юм бэ гээд тийм ээ. Мэдээж ковид нөхцөл байдал бол маш чухал, маш том нөлөө үзүүлсэн, сөрөг нөлөө үзүүлсэн бол 21 оноос хойш гээд харахад энэ нүүрсний хулгай ямар байсныг бид өчигдөр орой л гэхэд чуулган дээр нээлттэй сонссоноор хүмүүс харж байгаа л даа. Уг нь энэ хулгайн замаар ороогүй байсан бол Үндэсний баялгийн сан, Хуримтлалын сандаа хуримтлагдаад, өнөөдөр гишүүдийн яриад байгаа шиг бас тодорхой хэмжээний тоогоор иргэддээ

хүртээмжтэй, байгалийн баялгийг хүртээх бололцоо байсан.

Бид нар Үндсэн хуулийнхаа б дугаар зүйлд маш тодорхой зааж өгсөн шүү дээ. Монгол Улсын газар, түүний хэвлий, ой сав, байгалийн баялаг бол гагцхүү ард түмний өмч. Монгол төрийн хамгаалалтад байна гэхихсэн. Гэтэл энийгээ бид өнөөдөр яаж замхарсныг зарим нэг тоо баримтаар бол тодорхой хэлж байгаа. Тэгэхээр 22 оноос хойш жишээлбэл тэнд бүрэн эрхт төлөөлөгч томилоод, ЭТТ төр хуулийнхаа дагуу Үндсэн хуульд зааснаараа хяналт тавьсны үр дүнд жишээлбэл 22 онд 1 их наяд, 23 онд 3 их наядын ашигтай ажиллаа гэж байна. Тэгэхээр энэ бас буруу замаар ороогүй байсан бол хэчнээн ч их наядын ашигтай ажиллаад, өнөөдөр бид ингэж янз янзын тоо хэлээд л иргэдийнхээ хүртэх ёстой юмыг нь хүртээх чадахгүй байх хэмжээнд хүрэхгүй байх байсан л даа. Ямар ч байсан бид хяналтдаа авлаа, 22 оны сүүлээс эхлээд энэ бүрэн эрхт төлөөлөгч томилогдсоноос хойш ЭТТ компани нь ашигтай ажиллаж байна. Тэгэхдээ олсон ашиг болгоноо бид нар ингээд тараагаад цагцхих тухай асуудал огт яриагүй. Энэ чинь бас улс орны урт хугацааны хөгжлийн бодлого, ирээдүйд иргэддээ энэ байгалийн баялгийг тэгш хүртээмжтэй хүртээх асуудлыг Үндэсний баялгийн сантайгаа хамтатгаад энийг шийдье гээд.

Сая бас Улсын Их Хурлын ээлжит бус чуулган хийх тухай бид өнөөдөр ярьж байна. Энэ бол маш чухал, маш зөв. Бид ээлжит бус чуулган хийгээд, энэ иргэдийнхээ хүртэх ёстой юмыг нь ямар хэлбэрээр гэдгээ ярьцаагаад, хүртээх ёстой гэдэг байр сууриа би 21 оноос хойш илэрхийлж байгаа. Ковидын дараа иргэдийн маань амьдрал ахуй амаргүй байгаа. Бид боломжоороо тэтгэвэр, цалин нэмж байгаа ч гэсэн үнэ ханшийн өсөлтийг энд давж чадахгүй байгаа. Хэцүү байгаа. Тиймээс л бүгдээрээ одоо энэ ядахдаа цагаан сар бол Монголчуудын хувьд ёстой бэлгэ тэмдэг

болсон энэ үндэстнийхээ энэ баярын өмнө болж өгвөл энэ байгалийн баялгийнхаа хишигийг ашигтай ажилласан учраас яг энэ тооцоо судалгаагаар сайн хийгээд, хүртээх учиртай. Тиймээс л өнөөдөр Улсын Их Хурал энэ асуудлыг бүүр ингээд онцгойлон оруулж асуудал хэлэлцэж байна. Өнөө өглөө Эдийн засгийн байнгын хороо хуралдсан, өчигдөр орой хэд хэд ч хуралдав. Тэгээд энийг шийдчих нь зүйтэй гэсэн шийдвэрийг ч бас Улсын Их Хурлын даргын зүгээс ингээд Даргын дэргэдэх хурлаас шийдсэн.

Тиймээс бид нар энэ асуудлаа ингээд шийдээд явчих нь зүйтэй байгаа. Энэ тогтоол гарах нь бол өөрөө маш чухал байгаа. Яагаад гэвэл энэ тогтоол гарснаар Монгол Улсын 2012 оны 4 сарын 12-ноос 23 оны 12 сарын 31-ний хооронд төрсөн 1 сая 5 мянган хүүхэд маань бас энэ хувьцааныхаа ашиг ишмийг хүртэх эрх зүйн орчин бүрдэж байна. Тэгэхээр 3 сая гаруй иргэндээ бид ижил тэгшээр энэ хувьцааны ноогдол ашгийг хүртээх, цаашдаа энэ байгалийн баялгийн хувьцаа эзэмшигч болоод явах эрх зүйн орчныг өнөөдөр бид ингээд нээж өгч байгаагаараа энэ бол бас түүхэн ач холбогдолтой тогтоол. Тиймээс энэ тогтоолоо бид батлаад явна. Харин ноогдол ашгаа хуваарилах энэ асуудлаа манай ЭТТ-н ТУЗ Наранцогт дарга маань нөгөө санхүүгийн жилд 50 хоногийн дотор энэ асуудлаа шийдэх учиртай. Тэгэхээр 2 сарын 10-ны дотор ч юм уу, 15-ны дотор та бүхэн маань энэ санхүүгийн хурлаа тайлангаа хийгээд, иргэддээ энэ хүртээх асуудлаа бас нэг тооцоо судалгаа зөв хийгээрэй. Өнөөдөр ингээд янз янзын тоо хэлээд л, зарим нь ч амандаа орсноо яриад л, зарим нь дэндүү доогуур тоо хэлээд л ингээд байна. Тэгэх шаардлага байхгүй. Тооцоо судалгаагаар хийгээд, хүртээх ёстой юмаа хүртээгээд яваасай гэж бодож байна. Ингэх ч байх гэдэг итгэлтэй байгаа шүү. Нийгэм бас энийг харж байна гэдгийг хэлье.

**Г.Занданшатар:** Үг хэллээ Оюунчимэг гишүүн. Гишүүд асуулт

асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй нэг санал байгаа. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Яг хэвээр нь л оруулаад ирсэн юм байна л даа. 1.Тогтоолын төслийн 2 дахь заалтыг хасах. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Тэр 39 дүгээр тогтоолын 2 дахь заалт дээр 20 эхний ээлжид 20 хувь гэснийг тэр хэсгийг нь хасвал болох юм байна гэсэн, тэрнийгээ бол та нарыг хэлэлцэж байхад анх анзаарсан л даа. Тэгээд Эдийн засгийн байнгын хороон дээр бас яригдсан зүйлүүдийг Байнгын хороон дээр бас тэмдэглээгүй. Ганибал гишүүнээ, Батсуурь гишүүнээ тэр, Ганибал гишүүн ч яриад байсан. Ер нь Тавантолгой компани чинь нээлттэй компани болж байж ард түмэнд нээлттэй ил тод байдал, тэр нүүрсний хулгай луйвар гарахгүй байх, гэрээ хэлэлцээрүүд ил тод байх ийм public компани болох эх суурь дэвсгэрийг тавьж байж энэ компани эрүүлжинэ шүү. Ард түмний хяналтад орж байж. Тэгж байж ард түмний компани, хувьцаат компани байж чадна.

2 зөрөөтэй юм яриад байгаа. Энэ дээр ингээд дандаа албан ёсны бичиг баримт хувьцаат компани гэж яваад байгаа юм. Тэгсэн энэ ажлын хэсгийнхэн хязгаарлагдмал хариуцлагатай компани гэж яриад, нэгдэл дотроо мэдээж тэр хязгаарлагдмал хариуцлагатай компаниуд орж байгаа байх. Энэ мэт компанийн зөрчилтэй, корпорацын засаглал, компанийн засаглалыг сайжруулах, тэгээд ил, нээлттэй ил тод байдал бий болгож байж, ингээд олон улсын стандартын дагуу public компани, энэ компанийн удирдлагыг хэрэгжүүлж байж эндээс чинь хулгай луйвар гарах юм эзэнтэй болно. Энийгээ бол Эрдэнэс Тавантолгой төдийгүй Эрдэнэс Монгол компанийн захирал Наранцогт дарга бол

компанийн засаглалыг сайжруулахыг Үндэсний баялгийн сангийн хуульдаа маш сайн тусгаж байгаа юм билээ. Тэгээд Үндэсний баялгийн сангийн хуулиа оруулж ирж байж энэ бүх юмаа бодитоор хэрэгжинэ шүү.

Ингээд Эдийн засгийн байнгын хорооны санал хураалт саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. 69,8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Энэхүү тогтоолыг батлах санал хураалт явуулна. Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 69,8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа. Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа. Цаашидаа энэ тогтоолын төслийг бодитой хэрэгжүүлэх нь бол нэг удаа ноогдол ашиг өгөх асуудал яах вэ. Цаашидаа энэ ЭТТ компанийн засаглалыг сайжруулаад нээлттэй хувьцаат компани болоод ард түмний хяналтад ороод энэ байгалийн баялаг ард түмний мэдэлд байх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрэгжүүлж байж энэ цаашидаа бодитой хэрэгжинэ. Тийм учраас Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг яаралтай оруулж ирэхийг үүрэг чиглэл болгож байна.

15.47 цаг

**Дөрөв. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Төсвийн байнгын хороо боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/**

Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Индэрт урьж байна.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 94.5 дахь хэсгийг үндэслэн Төсвийн байнгын хороо 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа ЗГ-т чиглэл өгөх тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан хэлэлцлээ.

Тогтоолын төсөлд төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний төлбөр хураамжийн ногдуулалт, түүний зарцуулалтын талаарх судалгааг хийж, нэгдсэн санал, дүгнэлтээ 2024 оны 3 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд танилцуулах, төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний төлбөр, хураамж болон тэдгээрийн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх, тэдгээрт нийцээгүй төлбөр хураамжийг хүчингүй болгох арга хэмжээг авах зэрэг асуудлуудыг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын ЗГ-т даалгахаар тусгалаа. Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, санал гараагүй болно. Засгийн газарт чиглэл өгөх тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, танилцуулга, Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн байгаа болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Засгийн газарт чиглэл өгөх тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хороо санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна. Зочид танилцуулъя. МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 2017 оны магистрын хөтөлбөрийн төгсөгчдийн төлөөлөл



Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт магиструуд та бүхэнд хууль зүйн салбартаа их амжилт гаргахыг хүсэн ерөөе Улсын Их Хурлын гишүүдийн нэрийг өмнөөс. Тамгын газрынхан бас байж байна.

Байнгын хороо Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд суудалдаа сууя. Санал хураалт. Болдын Жавхлан сайд суудалдаа сууя, сайн явж ирсэн үү? Цэдэвийн Сэргэлэн гишүүн санал хураалт явуулах гээд байна. Санал хураалт. Анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хурааа. Энэ Чинзориг гишүүнд арга хэмжээ авмаар байдаг, тэгээд нэг тойрог болчихсон чинь загнаж болдоггүй аягүй хэцүү болчихоод байна. 62,3 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. 56,6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа. Аубакир гишүүний нэр буруу бичигдсэн байсан. Сүүлд зассан тийм ээ.

15.51 цаг

**Тав. “Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.01.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Ингээд дараагийн асуудалд орёе. Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулна. Төслийг эцсийн хэлэлцүүлэгт

бэлтгэсэн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл танилцуулна. Индэрт урьж байна.

**Д.Сарангэрэл:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүлсэн билээ.

ТББХ 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа. Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган, төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ТББХ-ны хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух улсын их, асуулт асууж, үг

хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу?  
Алга байна.

Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд суудалдаа сууна уу. Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 57,7 хувийн саналаар санал хураалт, тогтоолын төсөл батлагдлаа. Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

15.54 цаг

**Зургаа. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Дараагийн асуудалд орно. Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Төслийн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Амгалангийн Адъяасүрэн танилцуулна.

**А.Адъяасүрэн:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал нарын 24 гишүүнээс 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр нийтийн тээврийн парк шинэчлэлийн хүрээнд 2023 онд хийсэн автобус худалдан авах ажиллагааг төрийн болон албаны нууцад хамааруулан гэрээ хийсэн, шууд байгуулсан үндэслэл, шалтгаан нөхцөлийг шалгахаар хянан шалгах түр хороо байгуулах тухай санал ирүүлснийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу ТББХ 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдвийг нийслэлийн нийтийн тээврийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, парк шинэчлэх шаардлагын дагуу 2023 онд худалдан авсан автобусны худалдан авах

ажиллагаанд хяналт шалгалт хийхээр тусгай шалгалтын хүрээ хязгаарт 1 дүгээрт худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулсан үндэслэл шалтгаан, 2 дугаарт Төрийн нууцад хамааруулсан шалтгаан, төрийн болон албаны нууцаас гаргах шаардлагатай байсан эсэх, 3 дугаарт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлд заасан гэрээ шууд байгуулах аргаар хийсэн нь үндэслэлтэй эсэх, 4 дүгээрт нээлттэй сонсгол зохион байгуулж, иргэд, олон нийтийг үнэн зөв мэдээллээр хангах асуудлыг тус тус тусгахаар, мөн Түр хорооны бүрэлдэхүүнд олонхыг төлөөлөн Улсын Их Хурлын гишүүн Анужин, Батлут, Ж.Бат-Эрдэнэ, Х.Ганхуяг, Ц.Даваасүрэн, Г.Тэмүүлэн, цөөнхийг төлөөлөн Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Н.Ганибал, С.Одонтуяа, Т.Доржханд нар байхаар боловсруулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг өмнөх жилүүдэд хийгдэж байсан нийтийн тээврийн автобус нийлүүлэх төсөл, арга хэмжээнд хяналт шалгалт хийх хүсэлтэй байгаа талаар санал хэлсэн болно.

Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданишатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд

байна уу? Адъяаа гишүүнээр тасаллаа. Наянтайн Ганибал гишүүн асуулт асууна.

**Н.Ганибал:** Их Хурлын даргад болон ТББХ-ны дарга нарт бас баярлалаа. Ямар ч байсан улс төрийн хувьд бол эр зориг гаргаж, энэ удаа яг өнөөдөр МАН-ын эрх барьж байх үед нийслэл, түүнийг хариуцсан албан тушаалтнуудтай холбоотой энэ ногоон автобусны хэрэг дээр дангаар нь энэ асуудлыг бас Түр хороо байгуулан олон нийтэд мэдээллээр хангах ийм боломжоор хангасанд маш их баярлалаа. Ер нь өмнөх цаг хугацаанд Түр хорооны үйл ажиллагаанууд дээр анзаарагдсан нэг юм бол тэр хамгийн муу л бол хойд талын бор овоохой гэдэг манайхны хэллэг байдаг. Тэрэн шиг АН-ыг л ямар нэгэн байдлаар тэр асуудал руу татаж оруулж ирээд, муу муухай болгож харуулах гэж оролддог энэ оролдлого оролдлогууд бас хэрээс хэтэрсэн л дээ. Энэ удаагийн асуудал бол зөвхөн яг энэ цаг хугацаанд өнгөрсөн 8 жилийн хугацаа дотор хийгдсэн ажлууд дотор дангаараа өнөөдөр эрх баригч нарын асуудлыг оруулж ирж байгаа ийм асуудал байгаа. Энэ дээр ер нь Түр хороо байгуулах асуудал дээр бол улс төрийн маш олон ээдрээтэй, адармаатай давааг давж байж өнөөдөр бас энэ Түр хороо маань байгуулагдаж байна.

Энэ дээр бас манай эрх баригч нар дотроос бас үнэний төлөө зогсдог, шударга үнэнийг олон нийтэд мэдүүлэхийг хүсдэг гишүүд байдагт бас баярлалаа. Нийт 11 гишүүн МАН-ын Их Хурлын бүлгийн гишүүд маань бас энэ Түр хороо байгуулах дээр дэмжиж гарын үсэг зурсанд бас баярлалаа гэдгээ хэлье. Тэгээд олон нийтэд энэ мэдээллийг ил тод болгож, өнөөдөр худалдан авах Тендерийн тухай хуулийг яг ковидын үед хэрхэн гуйвуулж, хэрхэн хулгай хийж байсныг бол энэ ногоон автобусаар бол ил болно. Ер нь 2022 онд бол нийтдээ 2,2 их наядын шууд худалдан авалт тендергүйгээр бараа бүтээгдэхүүн худалдаж авсан ийм асуудлууд хүртэл

байгаа. Энийг ч гэсэн бид бүхэн бас ковидын үеийн тэр сонсголыг дараа нь бас бид бүхэн бас олон нийтэд хийх ёстой юм. Ямар ч байсан Түр хороо байгуулагдана гэдэг бол энэ хаврын чуулганаар бол энэ ногоон автобусны энэ цавчаа ногооны асуудлаар бол сонсгол хийгдэнэ байгаа гэдэгт бол найдаж байна. Та бүхэндээ баярлалаа.

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Жамбын Батсуурь гишүүн.

**Ж.Батсуурь:** Олон хууль, тогтоолууд батлагдаж байсан. Тэгээд энэ Түр хороог батлах тогтоолын төсөл орж ирж байгаад чин сэтгэлээсээ бас талархаж байгаагаа илэрхийлж байна. Өчигдөр бас Байнгын хороон дээр энэ тэр олон талаас нь ярилцсан. Нийгэмд бугшаад байгаа олон л зүйлүүд байдаг. Тэгээд тэрийг мэдээж бас ард нийтэд бодитоор нь хүргүүлэх ажиллагаа бол аль, аль талдаа бас дутагдалтай явж ирсэн, үр дүн нь сайн харагдахгүй, тэрнээс болж нийгмийн бухимдал нэмэгддэг энэ тэр юмнууд бол байдаг байх. Ард иргэний, ард иргэдийн итгэлийг олно гэдэг бол аливаа зүйлийг бодит үнэнийг нь л ойлгуулчих гээд ард иргэд өөрсдөө ухамсраараа итгэл нь сэргээж байдаг, улс төрчдөд итгэх итгэл нь тэр хэмжээгээрээ нэмэгдэж байдаг. Улс төрчдөд итгэх итгэл нь нэмэгдчихвэл төрийн байгууллагуудаас гаргасан шийдвэр өөрөө хүчирхэг болж ингэж болдог. Ингээд төр нь төвшин, түмэн олон нь бас тайван амьдрах ийм нөхцөлүүд бол үе шаттай явдаг байх л гэж ингэж бодож байгаа юм.

Тэгэхээр энэ тогтоол батлагдсанаар ер нь цаашид буруу бусармаг зүйл гарахгүй байх ийм хаалт болох боломжтой. Яагаад вэ гэхээр тухайн төсөв барьж байгаа хүн тухайн төрийн байгууллагыг удирдаж байгаа хүмүүс бид нар чинь хамаагүй зүйл хийх юм бол янз бүрийн бичгийг үндэслэж юм хийх юм бол Их Хурал дээр очиж Их Хурлын хяналт мөн бусад АТГ, цагдаа, шүүхийн байгууллагаар орж, ял зэм

хүртдэг юм байна. Янз бүрийн хүмүүсийн үгэнд орохгүй, зөвхөн тангараг өргөсөн ажлаа хийх ёстой юм байна гэсэн ийм үр дүнгүүд цааш цаашид гарах учраас бол би энийг сайшааж байгаа юм. Ингээд бас Төрийн байгууллагын байнгын хороонд ажилласан хүмүүс болон Их Хурлын дарга бас энэ асуудлыг энэ чуулганд оруулж ингэж асуудлыг ил тод болгож, ард түмэнд үр өгөөжтэй мэдээлэл өгөх гэж байгаад талархаж байна. Ингээд энэ тогтоолыг дэмжиж өгөхийг бүх хүмүүс, гишүүддээ уриалж байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Баярлалаа.  
Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

**Ш.Адьяа:** Өнөөдөр Монгол Улсын Их Хурал хяналт шалгалтын тухай хууль баталснаас хойшлох 3 дахь Түр хороог байгуулж ажиллах ийм хууль, эрх зүйн тогтоолыг боловсруулж, Улсын Их Хурлаар хэлэлцэж байна. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд хууль тогтоомж зөрчсөн, улс орны хэмжээнд бас шийдэх ёстой хуулийг гажуудуулсан, өмч хөрөнгө ашигласан, завхсан, бусдад давуу байдал олгосон, ард түмний баялгийг хулгайлсан ийм ноцтой асуудлууд дээр Улсын Их Хурал шалгаж, нийтийн сонсгол хийж, ард түмэнд мэдээллийг хүргэх, энэ хуулийн хүрээнд энэ Түр хороо ажлаа явуулна гэж найдаж байна. Урдах 2 Түр хороо энэ хуулийн хүрээнд шийдэгдэх тухай асуудал дээр шийдэх ёстой асуудлаас хазайсан, том, том асуудлуудыг дарсан, бусад хүмүүсийг нэр төрийг гутаах, харлуулах, өрсөлдөгчөө дарах ийм зорилготой үйл ажиллагаа явуулсан нь болбол тодорхой байгаа. Тодорхой байгаа.

Энэ Түр хороо энэ тендерийн тухай асуудал, ард түмний мэдэх эрхийн хүрээнд улсын өмч хөрөнгө, төрийн өмч хөрөнгийг хууль бусаар олж авсан, завхсан ийм асуудал дээр тодорхой мэдээллийн хүрээнд шалгаж, жинхэнэ Хяналт шалгалтын хууль тогтоомжийн

хүрээнд асуудлыг шийдэх ёстой гэж бодож байгаа. Ингэх байх гэж бодож байна. Тэгэхдээ энэ Нүүрсний сонсголын түр хороо, Хөгжлийн банкны түр хороо шиг том, том асуудлуудыг дарах тийм бодлого битгий явуулаасай гэж бодож байна. Бусдын нэр төрийг гутаадаг, өрсөлдөгчөө дардаг, өөрийн намынхаа өрсөлдөгчийг ч гэсэн дарахыг оролддог ийм улс төрийн захиалгат асуудлыг битгий явуулаасай гэж бодож байна. Энэ болбол энэ Монголын парламентын бас түүхэнд шийдэгдэх ёстой асуудал шүү. Энэ парламент болбол шүүх эрх мэдлийн үүргийг гүйцэтгэж болохгүй. Энэ парламент болбол тийм онц бүрэн эрхт онцгой комисс шиг ийм ааш аранишин гаргадаг ийм Түр хорооны дарга бас байж болохгүй. Энэ болбол бид нарын парламентын хөгжлийн асуудал, парламентын ёс зүйн асуудал, ард түмний төрд итгэх итгэлийн асуудал. Энд болбол хэн нэгэн гэмт хэрэг үйлдсэн асуудлыг бид хаацайлах ёсгүй, гэмт хэрэг үйлдсэн, эрх мэдлээ, албан тушаалаа ашигласан, улсыг хохироосон бүх хүмүүсийг хууль, шүүхийн хүрээнд шийдэх ёстой. Энэтэй санал нэг байгаа.

Гэхдээ аливаа том асуудлуудыг дардаг, хаацайлдаг, жижижсэн асуудлаар халхавч хийж ийм одоо парламентыг болбол шүүхийн мөрдөнгийн ийм байдалтай харагдуулах ийм зохисгүй асуудал дахиж битгий гараасай гэж бодож байна. Дахиж ийм үйлдэл энэ Түр хороо битгий хийгээсэй гэж бодож байгаа. Ийм учраас энд энэ Түр хорооны дараа бас энэ Хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд, энэ парламентын хөгжлийн хүрээнд, энэ хууль тогтоомжийн хүрээнд, энэ даргалагчийн хүрээнд аливаа асуудал дээр бас шийдэл олох ийм ярилцах ийм цаг хугацаа болсон байх гэж бодож байна. Ингээд энэ Түр хороо байгуулахыг дэмжиж, Түр хорооны үйл ажиллагаа хуулийн хүрээнд шударга, зарчимтай ажиллах байх гэж найдаж байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Аубакир гишүүн яагаад муухай хараад байна, та 3 юу яриад байна вэ? Суудалдаа сууцгаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооны саналаар Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 66,7 хувийн саналаар тогтоолын төсөл батлагдлаа. Байнгын хорооны саналаар Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдлаа.

16.07 цаг

**Долоо.Олон нийтийн радио,  
телевизийн Үндэсний зөвлөлийн  
гишүүнээр томилох, гишүүнээс  
чөлөөлөх асуудал**

Дараагийн асуудалд орно. МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх, гишүүнээр томилох тухай асуудлыг хэлэлцэнэ. МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх, гишүүнээр томилох тухай асуудлын талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл танилцуулна. Индэрт урьж байна.

**Д.Сарангэрэл:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.8 дахь хэсэгт заасны дагуу Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох асуудлыг ТББХ 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс нэр дэвшүүлсэн Ноовойн Нанзаддорж нь ТББХ-ны 22 оны 15 дугаар тогтоолоор баталсан нэр дэвших тухай хүсэлтийн загварын дагуу материалаа бүрдүүлж, Байнгын хороонд

ирүүлсэн. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийсэн сонсголыг Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6, Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулахаар түүх, уламжлал, ёс заншил, соёл, урлаг, утга зохиол, шинжлэх ухааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Монгол Улсын Ерөнхийлөгчид санал болгоно. 21.7.Энэ хуулийн 21.5-д заасан байгууллага, албан тушаалтан, төрийн бус байгууллагуудын саналаас сонголт хийн, Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасны дагуу нэр дэвшигчийн сонсголыг зохион явууллаа.

2024 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт заасны дагуу Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр нэр дэвшигчтэй хийх сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай Байнгын хорооны тогтоолыг баталж, 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар тов тогтоож, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэлийг томилсон. 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 13 цаг 30 минутад Нийтийн сонсголын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэгт Улсын Их Хурлаас зохион байгуулах нэр дэвшигчийн сонсголд тухайн асуудал эрхэлсэн Байнгын хорооны гишүүдийн 1/3-ээс доошгүй нь оролцох гэж заасны дагуу ТББХ-ны гишүүдийн 1/3-ээс доошгүй нь буюу Улсын Их Хурлын гишүүн Амарсайхан, Батсуурь, Мөнхцэцэг, Мөнх-Оргил, Оюунчимэг, Тогтохсүрэн, Сарангэрэл,

Жаргалмаа, Энхболд нарын гишүүд Байнгын хорооны сонголд ирж, ирц бүрдэн нэр дэвшигчийн сонголыг зохион байгуулсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 127 дугаар зүйлд сонголд оролцсон гишүүд сонголд явуулснаас хойш ажлын 2 өдрийн дотор хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонголын тайлан гаргана. Тайланд сонголын дүнд үндэслэн тухайн нэр дэвшигч нь албан тушаалд шаардлага хангасан эсэх дүгнэлт, түүнийг түүний үндэслэлийг тусгана. Тухайн тайланг ажлын 5 өдрийн дотор нэр дэвшигч, түүний санал болгосон этгээдэд хүргүүлж, Улсын Их Хурлын цахим хуудаст байриуулна гэж заасны дагуу 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр сонголын тайланг дэмжсэнийг Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэлийг танилцуулсан.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс нэр дэвшүүлсэн Ноовойн Нанзаддоржийг Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилуулах саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Нэр дэвшигчдийн танилцуулга, Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн. Мөн чөлөөлөх хүсэлтээ гаргасан Дуламрагчаагийн Жавзандоржийг Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх асуудлыг хэлэлцсэн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг

хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

### **Г.Занданшатар:**

Даваажанцангийн Сарангэрэл гишүүнд баярлалаа. Чуулганы нэгдсэн хуралдааны танхимд нэр дэвшигч Ноовойн Нанзаддорж хүрэлцэн ирсэн байна. Байнгын хорооны санал, дүгнэлт, эрх бүхий албан тушаалтны санал болгосон нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна. Адьшаа гишүүн, Сарангэрэл гишүүнээр тасаллаа. Жамбын Батсуурь гишүүн.

**Ж.Батсуурь:** Нэр дэвшигчийг бол дэмжиж байгаа. Тэгэхдээ та батлагдаад очиход жаахан халуухан юман дээр л очих байх. Ер нь бол өмнө нь Үндэсний олон нийтийн радио, телевиз бусад энэ үндэсний зөвлөлүүдэд олон л хүнийг нэр дэвшүүлж, очуулж байсан. Дэвшиж байх үедээ явцдаа бол их л гэгээн сайхан зүйлүүдийг ярьдаг. Тэгээд очсон хүмүүс маань тэнд очоод Монголын ард түмний татварын мөнгөөр ажилладаг олон нийтийн үзэл санааг илэрхийлж байгаа телевизийн эзэн болчихсон. Тэнд өөрийн ноёрхлоо тогтоох гэсэн ийм зүйлүүд байна. Өчигдөр Байнгын хорооноос ажлын хэсэг байгуулж, биднийг очуулсан. Үндэсний радио, Олон нийтийн радио, телевиз бол нэг Үндэсний зөвлөл нь 15 хүнтэй байдаг юм байна. Тэгээд 2/3-роо хуралддаг юм байна. Тэгээд олонхоороо шийдвэрлэдэг юм байна. Ингээд Үндэсний зөвлөл нь 1 сарын өмнө шийдвэрээ гаргачхаад байхад гүйцэтгэх удирдлага нь одоо хүртэл тамга тэмдгээ өгөхгүй, цалингаа тавихгүй, 600 гаруй хүн байдаг юм байна. Тэрний 500-гаад нь мөрөөрөө ажлаа хийж байгаа, 100 орчмыг нь 2 талцуулаад гадаад, дотоодод аваачаад мөнгө санхүү нийлээд янз бүрийн утас үзэл санаагаараа ингээд хуваагдуулаад? ингээд төөрөгдөлд оруулдаг л ийм л зүйл байдаг юм байна.

Тэгээд энэ нөхцөл байдлыг засах гэж Байнгын хорооноос очсон ажлын

хэсгийг бол үл тоож байна. Ер нь үүнээс юу харж байна вэ гэхээр бол янз бүрийн цүнх баригч нарыг бол энд тэнд тавих нь бол илүүц юм байна. Үнэхээр том байна. Асуудлыг зүгээр зарчмын дагуу ярилцъя гэхэд бол тийм зүйл байхгүй, надад хууль үйлчлэхгүй гэсэн байдлаар л асуудал хандаж байна. Энэ чинь Ерөнхийлөгчөөс оролцоотой, Их Хурлаас оролцоотой, ЗГ-аас оролцоотой энэ хүмүүс, энэ хүмүүс тэнд учир начраа олоод асуудлыг аятайхан шийдчих боломжууд бол байгаа юм, байгаа юм. Тэгээд ард түмний татварын мөнгөөр бодит үнэнийг чухам үнэнийг хэлж байх, ярьж байх ёстой Үндэсний телевиз нь ерөөсөө хэзээ ч хүний хүсээгүй худал мэдээлэл явуулдаг. Дөнгөж сая бид нар энэний өмнө ногоон автобусны талаар тогтоол баталлаа. Талбай дээр ногоон автобусыг авчрахад бүх хүн үзээд гараар бариад, нүдээр үзээд хуучин байна гэж байхад Монголын Үндэсний радио, телевиз шинэ байна л гэж гаргаж байгаа байхгүй юу. Үгүй ээ юу гэсэн үг вэ, цоо шинэ байна гээд байгаа шүү дээ. Бүүр ичих нүүрээ элгэндээ наачихсан. Ийм ажлыг хийж байгаа хүмүүсийг Үндэсний зөвлөл нь хуралдаад та бол арай л болохгүй байна. Ингэж хүмүүсийн гар, хөл болж байгаа учраас, тэр зөндөө дотоод юмнууд бол, тэр дотоод хэрүүл нь тэр цагдаа, шүүхээрээ явдаг л юм байгаа биз. Ийм учраас ажлаа өг гээд шийдвэр гарчихсан. Ингээд цалин мөнгөө тавихгүй, би өгөхгүй, би өгөхгүй гэж. Тэнд бол асуудлыг ярьж шийдэх бүрэн боломж бол байж байсан.

Өнөөдөр Үндэсний олон нийтийн радио, телевизийг орой үздэг хүн үзэгчгүй болчихлоо шүү дээ. Үзэгчгүй болчихлоо. Төсвөөс хэдэн 10 тэрбум төгрөгийг авдаг шүү дээ. Тэгээд дээр нь айл бүрийн өрхөөс татвар хураамж авдаг. Ингээд бидний хүүхэд байхаас хэдэн 10 жилийн түүхтэй, тэр хүмүүсийн мэдээллээр Монгол Улс тэжээгдэж байсан ийм цаг үе сая, саяхан шүү дээ. Гэтэл нөхцөл байдлыг ийм байдалд хүргэчихсэн ийм газар та очиж байгаа. Тийм учраас очоод өмнөх

Үндэсний зөвлөлийн гишүүд шиг ингэж талцал хуваагдалд оролгүйгээр, бодит үнэнийг тогтоох, Монголын ард түмний төлөө чин сэтгэлээсээ зүтгэх ийм л хатуу даалгавар танд оногдож байгаа гэж ингэж үзэж байгаа юм.

**Г.Занданишатар:** Хэн хариулах юм, үг хэлсэн үү? Үг болгож байна. Дуусаагүй байгаад яагаад. Бадарчийн Жаргалмаа гишүүн.

**Б.Жаргалмаа:** Та бүхнийхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Өнөөдөр бас МҮОНРТ-д Улсын Их Хурлын ТББХ-ноос ажлын хэсэг томилогдон, Оюунчимэг гишүүнээр ахлан ажиллаж байгаа. Өнөөдөр бас ажлын хэсгийн гишүүд маань очиж ажилласан гэдэг ийм мэдээлэлтэй байгаа. Яагаад Их Хурал, Байнгын хорооноос ийнхүү Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн үйл ажиллагаатай танилцаж ажиллах шаардлагатай болсон бэ гэвэл яг л саяын Батсуурь гишүүний хэлсэнчлэн Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл( тэр дундаа магадгүй өнөөдөр тус Олон нийтийн радио, телевизийг удирдаж байгаа удирдлагын зүгээс үйл ажиллагаагаа явуулах чадамжгүй болсон энэ нөхцөл байдалтай холбогдуулан Их Хурлаас ийнхүү арга хэмжээг авч байгаа. Магадгүй өнөөдөр Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлд ажиллаж байгаа Их Хурлаас, Ерөнхийлөгчийн Тамгын газраас, ЗГ-аас томилогдон ажиллаж байгаа эрх бүхий хүмүүс Үндэсний олон нийтийн радио, телевизийнхээ Үндэсний зөвлөлийг ажиллуулж чадахгүй байгаагаас шалтгаалан энэ нөхцөл байдал үүссэн.

Тухайн телевиз, радиод ажиллаж байгаа 700, мянга гаруй ажилтан, албан хаагчид, уран бүтээлчид өнөөдөр ажиллах боломжгүй байгаа. Магадгүй түүгээр дамжуулан өнөөдөр тус телевизийг үздэг, тус телевизээс олон зүйлийг хүлээж байгаа үзэгч, олон нийт тэдгээрийн эрх ашиг хохирч байгаа гэдгийг бас хэлэх нь зүйтэй байх гэж

бодож байна. Яагаад өнөөдөр үндэсний гэдэг тодотголтой олон нийтийн радио, телевиз ийнхүү ажиллах чадамжгүй болсон бэ гэвэл хууль, эрх зүйн орчинд бид нар өөрчлөлт оруулах ёстой, зайлиггүй шаардлагатай байгаа юм байна гэдэг зүйл. Өнөөдөр би Ерөнхийлөгчийн Тамгын газраас томилогдсон, би Их Хурлаас томилогдсон, би Засгийн газраас томилогдсон гэдэг байр сууринаас хандан ажилдаа сэтгэлгүй ханддаг, тэдгээр уран бүтээлчдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх чадамжгүй болсон энэ олон нийтийн радио, Үндэсний зөвлөлийг бас татан буулгах ёстой гэдэг юм уу, бид хууль, эрх зүйн орчинд өөрчлөх зайлиггүй шаардлага үүссэн байгаа юм. Энэ асуудал яг ужгирсан. Зөвхөн өнгөрсөн жил гэдэг юм уу, өнөөдөр ажиллаж байгаа удирдлагуудын хэмжээнд яригдаж байгаа асуудал биш гэдгийг онцгойлон хэлэхийг хүсэж байна. Тийм ч учраас Их Хурлаас ийнхүү ажлын хэсэг гарган ажиллаж байгаа. Хууль, эрх зүйг өөрчлөх зайлиггүй шаардлага үүсэж байгаа.

Би өнөөдөр Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлд нэр дэвшиж орж ирж байгаа Нанзаддорж гуайд бас юуг хүсэж байгаа гэвэл үнэхээр энэ хүний тухайн Үндэсний зөвлөлд хийх үүрэг болбол Монгол өв уламжлал, үндэсний хэл бичиг, өв соёлыг уламжлан үлдээх, тус телевизийн уран бүтээлийн бодлогод энэ чиглэлээр үзэл бодлоо илэрхийлэх, оруулах, үр хүүхдүүд, ирээдүй хойч залуучууддаа телевизээрээ дамжуулан, уран бүтээлээрээ дамжуулан үүнийг уламжлуулан үлдээх зайлиггүй шаардлага үүсэж байгаа. 2025 оноос Монгол Улс төрийн үйл ажиллагаагаа хос бичгээр явуулна. Өнөөдөр үзэж байгаа шалгалтаар болбол төрийн албан хаагчдын маань Монгол хэл бичгийн шалгалт хангалттай бус байгаа, 25 хувьд хүрэхгүй хэмжээнд байгаа энэ цаг мөчид бид яг энэ чиглэлээр ажиллах зайлиггүй шаардлага байгаа шүү гэдгийг бас хэлэх нь зүйтэй байх. Даяаршиж байгаа энэ нийгэмд Монгол

Улсын дархлааг авч үлдэх ганц зүйл бол.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

**М.Оюунчимэг:** Сая Батсуурь гишүүн маань хэлж байна. Яг үнэнийг хэлэхэд МҮОНРТ-ийн Ерөнхий захирал дээр очих гэсэн хүсэл мөрөөдөл үнэхээр их байдаг. Тэгээд л тэрнээс болоод л янз бүрийн маргаан зөрчил өмнө гарч л байсан л даа. Би хүртэл тэнд ажилладаг байхад л гарч байсан. Гэхдээ арай ч өнөөдрийнх шиг засаглалын хямрал нь эцэстээ хурчихсэн байна. Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл гээд Улсын Их Хурлын бидний томилж явуулдаг энэ Үндэсний зөвлөл ажиллах ямар ч чадамжгүй болчихож. Улсын Их Хурлын, Ерөнхийлөгчөөс, ЗГ-аас, төрийн бус байгууллагуудаас гээд төлөөлөл томилдог. Энэ төлөөлөл, томилсон хүмүүс маань өнөөдөр бүр зугтаж байна. Сая хэлж байна л даа. Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга Монсор нь өчигдөрхөн Улсын Их Хурлын ТББХ-ноос үүрэг даалгавар өгсөн. Өглөө гэхэд хүмүүсээ цуглуулаад хуралдана гэсэн чинь хөдөө яваад машин эвдэрсэн гээд утсаа салгаад аваад явсан. Энэ хүнийг хаана нэгтэйгээс зугт гэсэн чиглэл өгсөн гэж байна.

Дээрээс нь Хяналтын зөвлөлийн дарга Оюун-Эрдэнэ өчигдөрхөн ажиллаад ингэж байсан бол нөгөө хууль бус шийдвэр гарсан гэсэн чинь өнөөдөр бас хөдөө явлаа, албан боломжгүй болчихлоо гээд зугтаад явчихсан. Энэ Үндэсний зөвлөлийн шийдвэрийн дагуу тэр гүйцэтгэх захирал Бүрэнбаатар нь мөнгө санхүүтэй холбоотой ажлаа гүйцэтгэх боломжгүй гээд нэг Үндэсний зөвлөлийн 18-ны өдрийн шийдвэр нь гарсан юм байна. Тэгээд Үндэсний зөвлөлийн шийдвэр нь Хяналтын зөвлөл нь хууль зүйн хувьд энэ бол үндэслэлтэй юм байна гэж үзээд орны хүнийг нь Гомбожав гээд хүн томилсон юм байна. Гэсэн тэр Гомбожавыг нь дахиад зугт



гээд хэлчхэж. Тэгээд очсон чинь бүгд зугтчихаж. Сая ингээд Улсын Их Хурлын ТББХ-ноос миний бие ажлын хэсгийг нь ахлаад, Батсуурь гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Баттөмөр зөвшилцөнө гээд ингээд ажлын хэсэг очсон чинь шаардлагатай хүмүүс нь зугтаад алга болчихсон. Энд бидний томилсон хүмүүс шүү Үндэсний зөвлөлийн зөвлөлийн, энэ бидний томилсон хүмүүс шүү. Үндэсний зөвлөлийн.

Тэгээд тэнд 9 хүн байж байна. Тэгэхдээ шийдвэр нь бол хуулийн дагуу бас гаргаад явчих шийдвэр юм байна. Үндэсний зөвлөлийн өмнө гаргасан шийдвэр нь бас үнэхээр хуулийн дагуу юм уу, биш юм уу гэдгийг нь бид нар бас шалгаж үзсэн. Үндэсний, Улсын Их Хурлын хяналт шалгалтын үнэлгээний газар, аудитын газруудаар шалгуулж байж бас хууль тогтоох байгууллага юм чинь хууль сахиулахаар очсон. Үнэхээр бас 2/3-роо буюу хууль зүйн хувьд үндэслэлтэй шийдвэрүүд бол гаргасан юм байна. Дээрээс нь АТГ-аас бичгүүд нь ирчхэж, 3, 4 бичгүүд ирсэн байна. Тэгээд Үндэсний зөвлөлийн дарга Монсор нь байгууллагын дотоод үйл ажиллагааг үймүүлээд бараг л эфир таслахад хүрэх вий. Энд бол үнэхээр ноцтой байдал үүслээ. Тэгээд энэ хүнийг ийм ажлаа хийх хууль акт нь гарчихсан учраас оруулахгүй байна уу гээд бичгийг нөгөө хамгаалалтын алба, дотоодын цэрэгт өгчихсөн. Энэ асуудлууд нь ингээд задгай байгаа. Тэнд эзэн ч гэж алга. Тэр гүйцэтгэх захирал нь ч гэсэн өөрөө бүүр үнэхээр хүнд байдалтай. Өөрөө бас ямар ч итгэл үнэмшилгүй болчихсон. Тэгээд цалин хөлс гэсэн чинь төсвөөс авдгаа ч зарим нь мэдэхгүй байна л даа. Бид өөрсдөө мөнгөө олж байгаа шүү дээ гэж зарим нэг хүн нь бүр ярьж байна л даа.

Гэтэл бид төсөвт Үндэсний олон нийтийн радио, телевизийнхээ тэнд өдөр, шөнөгүй, цаг наргүй ажилладаг уран бүтээлчдийнхээ эрх ашгийг хамгаалах гэж, бас олон нийтийн телевиз гэдэг бол энэ онцгой объект. Энэ

объект тэнд бол олон тоног төхөөрөмжөөс өгсүүлээд онцгой объект. Архивын материал нь хүртэл яачих вий, тэр тамга тэмдэг, бичиг нь юу болох вэ гээд асуудал үүсэж байгаа. Гэтэл хоорондоо 2 хуваагдаад бүүр нөгөө нэг зүгээр 300, 400-гаад ажилчид нь ажлаа хийж байна. Одоо ингээд л энэ телевизийнхээ ажил хийгээд л, хөөрхий амьтад босож цай, кофе уух цай цаг наргүй ажилладаг хүмүүс нь өнөөдөр ажиллаад байж байтал тэнд турхирсан 3, 4-хөн хүмүүс хоорондоо бүүр зодолдоод сая байж байна шүү дээ. Өөр өөрсдөө хүмүүс гаргачихсан. Тэгээд сүүлдээ нөгөө толгой нь буюу удирдаж явж байгаа Үндэсний зөвлөл нь, гүйцэтгэх захирал нь ийм байхад тэнд доор байгаа ажилчид нь аргагүй л дээ, бүүр сүүлдээ ингээд 2, 3, 4 хэсэг болчихсон ингэж байна. Нэг хэсэг хүмүүс шүү. Тэрнээс яг уран бүтээлчид, ажилчид нь, техникийн хүмүүс нь, сэтгүүлчид тэнд хүмүүс зүгээр ажлаа хийгээд. Гэхдээ тэдний маань цалин нь цагтаа буухгүй, эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалын шимтгэл нь 7 сар төлөгдөөгүй. Өнөөдөрхөн эрүүл мэндийн шалтгаанаар эмчид үзүүлэхээр таны эрүүл мэндийн.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Оюунчимээ гишүүн үг хэллээ. Үнэхээр арга хэмжээ авахгүй бол болохгүй болсон юм байна. Тилеуханы Аубакир гишүүн.

**Т.Аубакир:** Баярлалаа. Олон нийтийн үндэсний радио, телевизийн Зөвлөлийн гишүүн орж ирж байгаа. Би Нанзаддорж гавжийг болбол дэмжиж байгаа. Би өчигдрийн сонсгол дээр бас байр сууриа илэрхийлсэн. Монголын Үндэсний радио, телевиз гэдэг болбол төв телевиз. Зөвхөн Монгол Улсад төдийгүй дэлхийд Монгол Улсыг зөвөөр харагдуулах, мэдээллийг тэнцвэртэй, үнэн бодитой мэдээллийг дамжуулах ийм телевиз. Монгол телевизийн радио, телевизийн хамт олон болбол ярих түүхтэй, хийсэн ажилтай хамт олон. Энэ дээр томилогдож очиж байгаа Зөвлөлийн гишүүдээс асуудал үүсээд байх

ишг надад бол харагдаад байдаг юм. Энэ Радио, телевизийнхээ тухай хууль дээр болохоор Зөвлөлийн гишүүдээ санал болгосон томилсон байгууллага нь тэр Зөвлөлийн гишүүдээ эргэж татах ийм эрх зүйн зохицуулалт байхгүй яваад байгаа юм.

Яг өнөөдрийн байдлаар яах вэ ингээд судлаад үзэх нь очсон Зөвлөлийн гишүүд нь тэрэн дотроо улс төрийн нөхцөл байдал бий болгодог, улс төрийн өнцгөөс аливаа асуудалд ханддаг. Гэтэл Монголын үндэсний радио, телевиз гэдэг зүйл болбол энэ олон энэ либералчлагдсан шар хэвлэл хөгжсөн энэ үед хамгийн тэнцвэртэй мэдээллийг, хамгийн үнэн бодит мэдээллийг ард иргэдэд хүргэх, ард иргэд төдийгүй дэлхийд Монгол Улсыг таниулах ийм зорилготой хэвлэл мэдээллийн хэрэгсэл. Тийм учраас Нанзаддорж гавжийг би томилогдож очиж байгаад бас баярлаж байгаа юм. Шашин номын хүн. Энэ нийгэмд үүсээд байгаа энэ уур амьсгал, энэ хүүхэд залуучуудын хүмүүжил, энэ нийгмийн явж байгаа чиг хандлага, энэ олон шар хэвлэлийн дундаас үнэн бодитой мэдээллийг авах ийм боломжгүй болсон энэ үед Монгол телевиз энэний үнэний талд зогсох ёстой ийм байгууллага. Би өчигдөр бас хэлсэн. Цонх онгойлгоход ялаа ч ордог, агаар ч ордог гэсэн гэж үг бий. Монгол телевизийн цонхоор зөвхөн цэвэр агаар орж байх ёстой.

Энэ нь эргээд үндэсний аюулгүй байдал, энэ Олон нийтийн радио, телевизийн тухай хууль дээр заасан үндэстэн ястан хоорондын эв нэгдлийг хангах, арьс өнгө, нас хүйс энэ зүйлээр ялгаварлан гадуурхахгүй байх, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн ажиллана гэсэн энэ хуулийн манаанд Зөвлөлийн гишүүд зогсох ёстой. Зөвлөлийн гишүүдийн үндсэн үүрэг болбол Олон нийтийн радио, телевизийн хуулийн хэрэгжилтийг хангах, түүнийг хянаад, зохицуулаад байж байх ёстой ийм субъектүүд. Тийм учраас миний хэлэх гэж байгаа 1 дүгээр зүйл болбол энэ санал болгосон Үндэсний зөвлөлийн

гишүүдийг санал болгосон, томилсон байгууллага нь эргэн татаж болдог энэ эрх зүйн зохицуулалтыг оруулахгүй болбол энэ том хэрэгслээр энэ үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн асуудал явж байгаа.

Би өчигдрийн сонсгол дээр болбол хэлсэн. Хэдэн жилийн өмнө Баян-Өлгий аймагт амьдарч байгаа казах иргэдийг Монгол хэлээ мэддэггүй, эд нар ер нь ямар бодол санаатай ийм ард түмэн юм бэ гэдэг зүйлийг Монголын телевиз явуулсан. Монголын төв телевиз ийм юм явуулж болдог юм уу? Ард иргэдийгээ эв нэгдэлд соён гэгээрүүлэхэд, хүмүүжүүлэхэд, боловсроход уриалан дуудах ёстой ийм телевиз ийм турхирлын шинж чанартай ийм зүйлийг явуулж болохгүй. Тийм учраас өнөөдөр орж ирж байгаа Нанзаддорж гавжийн хувьд болбол шашин номын хүн. Энэ талаас нь би бол олзуурхаж дэмжиж байгаа. Тийм учраас таны амжилт хүсье.

2 дугаар миний хэлж байгаа санал болбол энэ санал болгосон, томилсон энэ субъект нь эргээд энэ Зөвлөлийн гишүүнээ татаж болдог энэ эрх зүйн зохицуулалтыг бид нар яаралтай оруулж ирэхгүй болбол энэ төв телевиз маань болохоо байжээ. Тэнд ажиллаж байгаа түүхтэй, ярих юмтай, хийсэн олон жилийн туршилагатай Монгол телевизийн хамт олон тэр редакц, сурвалжлагч, оператор энэ хамт олонд бол буруу байхгүй. Улс төрийн шинж чанартай томилогдож очиж байгаа Зөвлөлийн гишүүдэд байгаа гэж би үзэж байгаа. Тийм учраас Нанзаддорж гавжид амжилт хүсье. Та энэ хуулийн хэрэгжилтэд.../минут дуусае/

**Г.Занданшатар:** Амжилт хүслээ, үг хэллээ. Даваажанцангийн Сарангэрэл гишүүн.

**Д.Сарангэрэл:** Баярлалаа. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл 15 гишүүнтэй. Үүний 7-г нь Улсын Их Хурал, 4-ийг нь Засгийн газар, 4-ийг нь

Монгол Улсын Ерөнхийлөгч санал болгож, Улсын Их Хуралд оруулж ирдэг. Таны өмнө Жавзандорж Радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаад өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн. Олон нийтийн радио, телевизийн хамт олон Жавзандорж гуайд бол ам сайтай байдаг юм билээ. Таныг ч гэсэн одоо бас уран бүтээлчдийн итгэлийг хүлээнэ гэдэгт би бол эргэлзэхгүй байна. Гол нь танд хэлэх гээд байгаа зүйл та очингуутаа хамгийн гол нь уран бүтээлчидтэйгээ уулзаарай. Олуулаа нийлж худлаа ярина гэж ерөөсөө байхгүй. Тэгээд би Аубакир гишүүнтэй санал нэг байна. Асуудал би Үндэсний зөвлөлд байна л гэж бодож байгаа.

Энэ гал тогоонд байсан хүний хувьд би мэднэ. Радио, телевизийн уран бүтээлчид бол цаг наргүй ажилладаг, амралтын өдөр гэж байдаггүй юм шүү дээ. Та бүхэн бямба, ням гарагт амралтын өдөр гээд телевиз, радио ажиллахгүй байхыг үзээгүй биз дээ. Баяр ёслолын үеэр ерөөсөө бүтэн ажиллана, бүүр улам бүүр завгүй болдог. Тэгээд маш бага цалингаар ажилладаг. Гэтэл энэ радио, телевизийн хамт олон маань 7 сар нийгмийн болон эрүүл мэндийн шимтгэлээ төлүүлээгүй, төлөөгүй байгууллага нь. Үүнээс болоод уран бүтээлч эмэгтэй эмнэлгийн тусламж үйлчилгээг 100 хувь хувийн төлбөрөөр авах ийм нөхцөл байдал үүссэн. Тийм болохоор бол таны хувьд тэнд очиж бас нэг хамгийн түрүүнд уран бүтээлчдийнхээ эрх ашгийн төлөө, олон нийтийн эрх ашгийн төлөө ажиллах ёстой ийм том үүрэг хариуцлага ирж байгаа гэдгийг би таныг бас гүнээ ойлгож хүлээж авна гэдэгт эргэлзэхгүй байна.

Тэгэхээр ер нь бол цаашдаа Улсын Их Хурлын дарга маань өөрөө ТББХ-ны гишүүн байдаг юм. Тэгээд Байнгын хороон дээр, Байнгын хорооны дарга болон Байнгын хорооны гишүүддээ үүрэг чиглэл өгсөн байгаа. Олон нийтийн радио, телевиз дээр ажлын хэсэг

байгуулж ажиллах, улмаар Олон нийтийн радио, телевизийн хууль өнөөгийн нөхцөл нөхцөлд шаардлага хангаж байна уу, хуультай холбоотойгоор асуудал тэнд үүсээд байна уу, үгүй бол хүнтэй холбоотой асуудал үүсэж байна уу, үүний учрыг олох ийм үүрэг чиглэл өгсөн байгаа. Би энэ чуулганы завсарлагаагаар ажлын хэсэг бол ажиллана гэж ингэж бодож байгаа. Тийм учраас бол үүнийг хүлээхгүйгээр тэнд асуудлууд нь тулгамдаад байгаа учраас таныг очиж тэр 15 хүний дундаа онцгойрон ажиллаж уран бүтээлчдийнхээ төлөө ажиллаасай гэж хэлэх гэсэн юм. Амжилт хүсье танд.

**Г.Занданшатар:** Үг хэллээ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна. Байнгын хорооны саналаар эхлээд чөлөөлөх санал хураалт явуулах ёстой. Байнгын хорооны саналаар эхлээд чөлөөлөх санал хураалт явуулна. Байнгын хорооны саналаар эхлээд чөлөөлөх санал хураалт явуулна. Дуламрагчаагийн Жавзандоржийг Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулна. Санал хураалт. 55,8 хувийн саналаар санал хураалт дэмжигдлээ.

Томилох санал, томилох санал хураалт явуулна. Ноовийн Нанзаддоржийг Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн, олон нийт Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх, гишүүнээр томилох саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай Улсын Их

Хурлын тогтоол баталсанд тооцлоо. Тогтоолыг уншиж танилцуулъя. Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Нанзаддорж гавжид ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе. Сая гишүүдийн хэлээд байгаа асуудлуудыг бас онцгой анхаарч ажиллахыг хүсье.

16.26 цаг

**Найм.Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнийг томилох, гишүүнээс чөлөөлөх асуудал**

Ингээд Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнийг томилох, гишүүнээс чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ. Нэр дэвшигчийн талаар гаргасан ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна. Индэрт урьж байна.

**Ц.Мөнхцэцэг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн албаны тухай хуулийн 68 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн хэсэгт заасны дагуу ТАЗ-ийн гишүүнийг томилох, чөлөөлөх асуудлыг ТББХ 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Улсын Их Хурлын Тамгын газраас нэр дэвшүүлсэн Баярын Пүрэвдагва, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас нэр дэвшүүлсэн Лхагвын Цэдэвсүрэн нар нь ТББХ-ны 2022 оны 15 дугаар тогтоолоор баталсан нэр дэвших тухай хүсэлтийн загварын дагуу материалаа бүрдүүлэн, Байнгын хороонд ирүүлсэн болно. ТАЗ-д гишүүнд нэр дэвшигч 2 нартай хийсэн нэр дэвшигчийн сонсголыг Төрийн албаны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэгт Зөвлөл нь хамтын удирдлагын зарчмаар ажиллах бөгөөд орон тооны 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Мөн

зүйлийн 68.2-т Зөвлөлийн гишүүнд Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тус бүр нэг хүнээ нэр дэвшүүлэх бөгөөд нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албан тушаалд 15-аас доошгүй жил ажилласан, төрийн удирдлага, эдийн засаг, эрх зүй, боловсролын чиглэлээр мэргэшсэн, дээд боловсролтой, ял шийтгүүлж байгаагүй 45 нас хүрсэн Монгол Улсын иргэн байна. 68.3-д Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийсний үндсэн дээр Зөвлөлийн гишүүнийг 6 жилийн хугацаагаар томилно гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн нэр дэвшигчийн сонсголын үе шатыг баримтлан дараах ажлаа хийлээ.

ТББХ-ны 2024 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт заасны дагуу ТАЗ-ийн гишүүн нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг сонгох тухай ТББХ-ны 2024 оны 2 дугаар тогтоолоор нэр дэвшигчийн сонсголыг 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулахаар, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг томилсон. 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 10 цагт Нийтийн сонсголын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэгт Улсын Их Хурлаас зохион байгуулах нэр дэвшигчийн сонсголд тухайн асуудал эрхэлсэн Байнгын хорооны гишүүдийн 1/3-ээс доошгүй нь оролцох гэж заасны дагуу ТББХ-ны гишүүдийн 1/3-ээс доошгүй нь буюу Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Ж.Батсуурь, Б.Жаргалмаа, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, М.Оюунчимэг, Д.Сарангэрэл, Д.Тогтохсүрэн, Энхболд нар Байнгын хорооны сонсголд хүрэлцэн ирж, ирц бүрдэж, нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 127 дугаар зүйлд сонсголд оролцсон гишүүд сонсгол явснаас хойш ажлын 2 өдрийн дотор хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайлан гаргана. Тайланд сонсголын дүнд үндэслэн тухайн нэр дэвшигч албан тушаалын шаардлага хангасан эсэх дүгнэлт, түүний үндэслэлийг тусгана. Тухайн тайланг ажлын 5 өдрийн дотор нэр дэвшигч, түүний санал болгосон этгээдэд хүргүүлж, Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулна гэж заасны дагуу 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэйгээр сонсголын тайланг дэмжсэнийг Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг танилцуулсан.

ТАЗ-ийн гишүүнд нэр дэвшигч Баярын Пүрэвдагва, Лхагвын Цэдэвсүрэн нар нь Төрийн албаны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.6 дахь хэсэгт Улсын Их Хурлын ТББХ зөвлөлийн гишүүн нэр дэвшигч энэ хуулийн 68.2, 68.4, 68.5-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар дүгнэлт гаргана гэж заасны дагуу уг хуульд заасан нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албан тушаалд 15-аас доошгүй жил ажилласан, төрийн удирдлага, эдийн засаг, эрх зүй, боловсролын чиглэлээр мэргэшсэн дээд боловсролтой, ял шийтгүүлж байгаагүй, 45 нас хүрсэн Монгол Улсын иргэн байх шаардлага мөн дараах Зөвлөлийн гишүүнд улс төрийн намын удирдах, гүйцэтгэх албан тушаалтан болон сүүлийн нэг жилийн хугацаанд эдгээр албан тушаалд ажиллаж байсан хүнийг нэр дэвшүүлэхгүй. Зөвлөлийн гишүүд нэг нутгийн болон нэг анги хамт төгссөн эсвэл хамаарал бүхий этгээд байж болохгүй гэсэн шаардлагуудыг хангаж байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил нэр дэвшигчдийг дэмжиж байгаагаа

илэрхийлж, ТАЗ-ийн үйл ажиллагааг шинэ шатанд гаргах бодит шаардлага байгаа талаар, төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор сургалтуудыг тогтмол үр дүнтэй зохион байгуулахад анхаарч ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд төрийн албан хаагчийг улс төрөөс ангид байх боломжийг бүрдүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүй, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх, Ёс зүйн болон ёс зүйн дэд хороог байгуулах, үйл ажиллагааг жигдрүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй гэсэн талаар, Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтэд анхаарах. Уг хуульд заасан гадуур сонгон шалгаруулалт явагддаггүй байх. Чадахуйн зарчим буюу иргэнийг төрийн албаны сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх асуудлыг шийдвэрлэхдээ хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлаж сонгон шалгаруулалт нь хууль ёсны байхад онцгой анхаарч ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж ТАЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдэд тавих шаардлага хангасан нэр дэвшигчийг нэр дэвшүүлж байгаа талаар саналаа илэрхийлсэн болно.

Улсын Их Хурлын Тамгын газраас нэр дэвшүүлсэн Баярын Пүрэвдагва, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас нэр дэвшүүлсэн Лхагвын Цэдэвсүрэн нарыг Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнээр томилуулах саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжиж, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Нэр дэвшигчийн танилцуулга, Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно. Мөн Балдангийн Баатарзориг, Самдангийн Цэдэндамба нарын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон тул ТАЗ-ийн орон тооны гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөхийг

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, ТАЗ-ийн гишүүнд томилох, чөлөөлөх асуудлыг хэлэлцсэн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Зочид эхлээд танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэнгийн урилгаар Архангай аймгийн Тариат сумын Мөрөн багийн бага сургуулийн багш, ажилтнуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сурлагын, ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе. Байнгын хорооны санал, дүгнэлт болон нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Одонтуяа гишүүнээр тасаллаа. Чуулганы нэгдсэн хуралдааны танхимд нэр дэвшигч Баярын Пүрэвдагва, Лхагвын Цэдэвсүрэн нар хүрэлцэн ирсэн байна. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Ш.Адьшаа:** Өнөөдөр ТАЗ зөвлөлийн жинхэнэ гишүүнд нэр дэвших 2 нэр дэвшигчийн асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэж байна. ТАЗ гэдэг энэ байгууллага бол Монгол Улсын төрийн өмнө төрийн жинхэнэ албан хаагчид төрийн ёс зүйтэй албан хаагчид, төрийн тогтолцооны жишиг болсон энэ төрийн алба хаших энэ хүмүүст тавих шаардлага өнөөдөр нэлээн хурцаар тавигдаж байгаа энэ үед энэ нэр дэвшигчид орж ирж байна гэж үзэж байгаа. Монгол Улсын ТАЗ энэ парламентын хугацаанд олон удаа бас энэ Их Хурал дээр үйл ажиллагааныхаа тайлан бусад зүйлээр мэдээлэл хийж, ТАЗ-ийн ажиллах нөхцөлийг хууль, эрх зүйн хүрээнд тодорхой Улсын Их Хурал дэмжиж ажилласан. ТАЗ-ийн даргаар ажиллаж байсан Баатарсүрэн бол бас ноён нуруутай, төрийн албыг хашихад бас нэлээн тийм сайн ажилласан ийм хүн

гэж би үздэг юм. Өнөөдөр энэ төрийн албан хаагчдын сахилга хариуцлагын асуудал, ёс зүйн асуудал, төрийн албаны сонгон шалгаруулалтын асуудал шинэ шатад гаргах ёстой, шинэ шатад гаргах ёстой.

ТАЗ дотор жинхэнэ гишүүд дотор бас олон асуудалтай хүмүүс байж болзошгүй байгаа юм. Тухайлбал Баатарсүрэн гээд нэг нөхөр байгаа. Баатарсайхан ч билүү. Их Хурлын даргын нэрийг бариад явж байдаг, Баянхонгорын гээд. Ийм хүмүүс өнөөдөр ёс зүйтэй энэ асуудал энэ дахиад ийм энэ ТАЗ-д битгий гараасай. Энэ болбол яг бодит үнэн шүү. Тэгээд энэ байдлаар цаашидаа асуудал битгий гаргаж байгаасай. Энэ төрийн жинхэнэ албан хаагчдыг сонгох, энэ сахилга хариуцлагыг дээшлүүлэх ийм цаг үед ийм хүмүүс ТАЗ гэдэг энэ хариуцлагатай албан тушаалд 5, 6-хан хүн байгаа шүү дээ. Энэ болбол өнөөдөр маш олон шүүлтүүрээр, маш олон шалгуураар энд томилогдох, сонгогдох ёстой гэж ойлгодог. Хэн нэгэн улс төрчийн харьяаллын, хэн нэгэн намын, хэн нэгэн хүний захиалгаар энэ төрийн энэ хариуцлагатай албыг цаашид орох энэ боломжийг энэ хууль тогтоомжоор хаах ёстой. Улсын Их Хурал ч энэ дээр дүгнэлт хийх ёстой.

Өнөөдөр энэ нэр дэвшиж байгаа Цэдэвсүрэнгийн тухайд бол бас Төрийн нарийн бичгийн дарга, төрийн сайд хийж байсан тийм төрийн жинхэнэ туршлагатай албан хаагч л гэж ойлгож байгаа. Пүрэвдагва даргын тухайд бол би бас дэмжиж байна. Улсын Их Хурал дээр бид бас энэ Тамгын газар боловсон хүчний асуудал бусад асуудлаар бас сайн ажилладаг ийм төрийн жинхэнэ албан хаагч л гэж би ойлгож байгаа юм. Ер нь тэгээд энэ та бүхэн ингээд томилогдох байх. Цаашид очоод улс төрөөс ангид байх, аливаа асуудалд хууль ёс, зарчмын хүрээнд хандах, хэн нэгэн хүнийг, хэн нэгэн намын том дарга нарын шахалтад орохгүйгээр төрийн хуулийг жинхэнэ хүрээнд нь хэрэгжүүлэх ийм үүрэг хариуцлага та бүгдийн өмнө тулгарч

байгаа шүү. Төрийн сонгон шалгаруулалт, ялангуяа энэ ТНБД нар бусад албан тушаалд болбол тэр сонгон шалгаруулалт болбол их өөр түвшинд явагддаг шүү гэдгийг нь тэмдэглэж хэлье. Ингээд та бүгдэд ажлын амжилт хүсье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Адьшаа гишүүн үг хэллээ. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

**Б.Бат-Эрдэнэ:** Юу байна энэ төрийн албаны шинэчлэл, Төрийн албаны хууль, сүүлд бид хөөцөлдөж байгаад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуультай болсон. Ингээд ТАЗ дээр Ёс зүйн хороо байгуулаад, тэгээд энэ хорооны гишүүдийг хуульд заасны дагуу хараат бусаар сонгон шалгаруулсан, ажилд нь оруулчихсан байгаа. Тэгээд энэ 20 оноос 24 оны Улсын Их Хурал энэ ёс зүйн асуудалд их онцгойлон анхаарч, хуучин ТББХ-ны эрхлэх асуудлын хүрээнд байсан Ёс зүйн дэд хороог өргөжүүлж Ёс зүй сахилга, хариуцлагын байнгын хороо болгож байгуулсан. Ингээд бид нарын тавьсан зорилт бол ерөөсөө шатны гишгүүрийг дээрээс нь шүүрдэнэ. Тийм учраас Улсын Их Хурлын гишүүний Ёс зүйн тухай хуулиа бид нар шинэчилнэ гэж ингэж үзээд эхний ээлжид Ёс зүйн дүрмээ шинэчилсэн найруулгаар хууль болгож баталсан. Тэгээд дараагаар нь миний түрүүний хэлдэг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль.

Ингээд нийт нийгмийн хүрээнд болбол энэ хүмүүнлэг боловсролын чиглэлээр бид бас Хүмүүнлэг боловсролын тухай хууль санаачлаад өргөн бариад, ингээд хэлэлцүүлгийн хэлэлцэх эсэхийг нь шийдчихсэн ингээд явж байгаа. Ер нь ингээд ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой юманд бол ялангуяа энэ дээд түвшинд байж байгаа улсууд нэлээн жоохон хойргодуу тийм л байдаг л зүйл л дээ. Өнөөгийн нийгэмд бий болсон энэ авлигал, хээл хахууль, энэ улс орны хөгжил урагшаа явахгүй байгаа, энэ нийгэмд баян хоосны ялгаа гарсан. Өнөөгийн болохгүй, бүтэхгүй байгаа

юмны уг үндэс болбол ерөөсөө л энэ айл гэрээр байх юм болбол аав, ээж нь үлгэрлэдэгтэй адилхан энэ улс гэрт бол энэ төр, төрийн өндөр дээд ажил албыг хашиж байгаа хүмүүс л бүх талаараа үлгэрлэх ёстой гэсэн ийм хатуу байр суурь дээр би энэ Улсын Их Хуралд 5 удаа сонгогдож ажиллах 20 жилийнхээ хугацаанд ингэж шаардаж шахаж. Үгүй ээ бас өөрийн биеэр энийг үлгэрлэж, зөв зохистой минимал хэрэглээнээс өгсүүлээд энэ төрийн төсвийн хөрөнгө санхүүг яаж гамнах вэ, хэмнэх вэ, элдвийн хууль бус ашиг сонирхлоос ангид байх, хууль бус юманд орооцолдохгүй байх ийм юмыг өөрөөрөө үлгэрлэж бусдад энэ үе үеийн парламентад шахаж шаардаж ингэж явж ирсэн ийм түүхтэй юм байгаа юм.

Тэгээд би юу хэлэх гэж байгаа вэ гэхээр зэрэг арай гэж ингээд энэ чинь дээд талаасаа буруу үлгэртэй байгаа юм чинь ингээд доод талдаа энэ үлгэр нь халдаад байдаг. Төрийн нэг ажил алба хийж байгаа, төрийн өмчит компанийн нэг ажилтны гэр байрнаас л хэдэн тэрбум төгрөг нэгжлэг хийгээд л гарч ирлээ гэж. Үгүй ээ ингэж энэ авлигал хулгай, ийм ёс зүйгүй юманд автана гэдэг бол үнэхээр харамсалтай байхгүй юу. Тэгээд төрийн албыг нэг жаахан цэгц журамд нь оруулах гээд байдаг. Та нөхдүүд маань очоод нөгөө улс төрөөс ангид байх, мерит зарчмаар байх энэ хуулийг ягштал барьж ажиллах тэр зарчмаасаа ухраад л нэг өөр алхам хийх л юм болбол хэцүү шүү дээ. Цэдэвсүрэн даргыг болбол насаараа энэ төрийн албанд мэргэшсэн ийм хүн гэж байгаа, бодож байгаа, итгэж байгаа. Гэтэл болбол ингээд нэг Монголчууд чинь нийтээрээ нэг тийм дарга шүтэх үзэлтэй, ялангуяа энэ дээд, дунд түвшинээс дээш нөхдүүд бол тэгээд л дарга, дарга гээд л ингээд л дагаад л явчихдаг. Тэгээд энэ дарга гэсэн байр сууриас, даргыг дагаж намирахаасаа илүү энэ батлагдсан хууль, энэ хуулийг орой дээрээ залж, энэ хуулийг үг үсгээр ягштал баримталж, ингэж ажиллаасай гэж би ингэж ийм зүйлийг л хэлэх гээд

байгаа юм. Энэ залуу хүн болбол.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Гонгорын Дамдинням гишүүн.

**Г.Дамдинням:** ТАЗ-ийн шинэ гишүүд нэр дэвшээд ороод ирж байна. Хоёуланттай нь бас боловсролын салбарт цуг ажиллаж байсан, салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүс явж байна. Дэмжиж байна. Тэгээд 1 зүйлийг л захъя даа. Манай Төрийн албаны хууль, тэгээд төрийн албан дээр энэ ёс зүй, сахилга хариуцлагыг цэгцтэй байлгая гээд Улсын Их Хурал дээр Байнгын хороо хүртэл байгуулаад ингээд ажиллаад явж байгаа. Мерит зарчмаар буюу хүлээн зөвшөөрөгдсөн тэр байдлаараа өрсөлдөөд ингээд томилогддог гэдэг ийм байдал руу бид нар энэ хуулийг хийсэн байгаа. Хуулиа мөрдөөд явахаар нэг ийм бэрхшээлтэй асуудал үүсээд байна. Төрийн бүтээмж, үр дүн дээр. Олон жил гай ч үгүй, гавьяа ч үгүй ажилласан нь мерит зарчмын голлох үзүүлэлт болж хувираад, ямар ч шийдэлгүй, ямар ч гавьяагүй, ямар ч үр дүн гаргадаггүй, алдаа ч байхгүй ийм байдалтай олон жил өнгөрөөгөөд дарга болоод ингээд, тэгээд болсныхоо дараа тухайн орон нутагтаа өөрөөс нь өөр хүн байхгүйг мэдэж байгаа учраас элдэв ааш авир гаргаж, болох болохгүй шантааж дарамтыг дээшээ ч, доошоо ч үзүүлдэг ийм байдал руу орж байгааг асар олон иргэд илэрхийлж байгаа.

Тухайн салбаруудад ажиллаж байгаа хүмүүс ч их илэрхийлдэг. Их Хурлын гишүүн бид нарыг очиход. Үгүй ээ та нар тэгээд өргөдлөө бичээд асуудал яриач гэхээр үгүй ээ яах юм бэ шүүхдээд наад хүнийг чинь халлаа болилоо гэхэд шүүхдээд л буцаад ажлаа аваад бид нарыг дарамтлаад орно. Ийм л байдал руу орчихсон байгаа байхгүй юу. Өчигдөрхөн л бас нэг үл ойлголцол болоод л Энх-Амгалан сайд бид 2 баахан л асуудал боллоо. Ажил дээр наана, цаана болох юм байдаг. Тэгтэл ТАЗ-ийн Ёс зүйн журам гэдэг юм нь гараагүй байгаагаас

л асуудал үүсчхэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ мерит зарчим дээр төрийн албаны ёс зүйн энэ дүрэм журмыг маш сайн суулгаж өгмөөр байна. Олон жил суугаад дарга болгосноосоо гадна, энэ ард иргэдэд үйлчлэхдээ, хамт ажиллаж байгаа хүмүүстэй харьцахдаа, удирдаж байгаа, удирдагдаж байгаа хүмүүстэй харьцахдаа ёс зүй, сахилга хариуцлагыг хатуу чанд барьдаг, чадахгүй болбол шууд хариуцлага тооцдог энэ журмыг та нар боловсруулж оруулж ирж батал. Ингэхгүй болбол та 2-той ч гэсэн би өмнө нь зөндөө л ярилцаж байсан. Ямар асуудал байгааг болбол та нар өөрсдөө бүрэн мэдэж байгаа.

Сүүлдээ одоо бүүр ингээд хууль зөрчиж бараг эрүүгийн хариуцлага хүлээх хэмжээний шахалт дарамтуудыг үзүүлдэг болж байна шүү дээ энэ зарим төрийн албан хаагчид. Мянга мянган ажлаа хийгээд, амьдралаа залгуулаад, ард иргэдтэйгээ нүүр тулаад, зовлон жаргалаа эдлээд ингээд зүтгэж яваа төрийн албан хаагчдынхаа ардуур орчихдог, яг өөрсдийнх нь асуудлыг ярихаар. Тэгэхээр энэ нэг цөөхөн идээ бээр шиг, хувийн ашиг сонирхлоо урдаа тавьсан,ы харилцааны соёл гэх юм ер нь авах юм байхгүй, өөрт нь үйлчилж л байвал бусад нь болоо гэдэг ийм л зарчмаар ажиллаж байгаа хүмүүсийг арилгах журмыг оруулж ирээрэй. Мерит зарчим гэдэг болбол зөвхөн олон жил ажилласнаар үнэлэгдэхгүй шүү. Одоо бол харамсалтай нь Хөдөлмөрийн хууль дээр ч тэр, бүх юман дээр яг энэ зарчмаар яваад байгаа. Энийг анхаараарай л гэж 2 нэр дэвшигчдэдээ хүсье. Тэгээд цаашидаа томилогдоод явсны чинь дараа энэ асуудлыг нэхсээр байх болно шүү гэдгээ дахин хэлье. Тэгээд бас бичгээр зарим асуудлуудыг хүргүүлнэ. Тэгээд амжилт хүсье та хоёрт.

**Г.Занданшатар:** Цэндийн Сандаг-Очир гишүүн.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. ТАЗ-ийн гишүүн 2 гишүүний бүрэн эрхийн



хугацаа албан ёсоор дуусаж, орны 2 хүн орж ирж байгаа юм байна. Баатарзориг дарга, Цэдэндамба дарга 2 бас ТАЗ дээр бас их боломжийн сайн ажилласан гэж би хувьдаа үздэг. Энэ төрийн албаны энэ мерит байх, төрийн албыг тогтвортой байлгах, улс төрөөс хараат бус байх тал дээр нэлээд анхаарч ажилласан. Төрийн албаны сонгон шалгаруулалтыг ил тод байлгахад маш сайн анхаарч ажилласан. Тийм учраас энэ Баатарзориг дарга бас одоо Цэдэндамба 2 гишүүнд бас талархал илэрхийлье гэж ингэж бодож байгаа юм.

Та 2 маань хэрвээ бас дэмжигдээд ТАЗ-ийн гишүүнээр сонгогдвол бас энэ эхлүүлсэн ажлуудыг үргэлжлүүлж ажиллуулах хэрэгцээ шаардлага байна. Нөгөө талаар Цэдэвсүрэн нэр дэвшигчээс асууя. Одоо энэ яамнууд дээр, орон нутгууд дээр энэ нэг үүрэг гүйцэтгэгч гэж энэ нэг орон тоонууд байна. Энэ үүрэг гүйцэтгэгч нар хариуцлага хүлээх үү? Хариуцлага хүлээх эрх бүхий субъект мөн үү? Үгүй ээ, яамд, яамдын Төрийн нарийнаас авхуулаад газар, хэлтсийн дарга нар, мэргэжилтнүүд тэр чигээрээ л үүрэг гүйцэтгэгч нар, үүрэг гүйцэтгэгч нар. Үүрэг гүйцэтгэгчээр дүүрсэн байна шүү дээ. Тэгээд энэ олон улсууд хариуцлага хүлээх субъект мөн үү? Ажилдаа чин шударгаар ингэж ажиллаж чадах уу энэ үүрэг гүйцэтгэгч нар, Төрийн албаны хуульд үүрэг гүйцэтгэгч гэдэг энэ ангиллын орон тоо байгаа юу? Энэ харилцаа байгаа юу төрийн үүрэг гүйцэтгэгч гэдэг. Тэгээд энэ нэг ингээд нэг ийм хуулийн цоорхой ашиглаад ингээд нэг ингээд байлгаад байдаг. Нөгөө Засаг солигдохоор, нөгөө сайд солигдохоор л ингээд л нэг төрийн алба тогтворгүй байдаг байдал ерөөсөө хэвээр л байна шүү дээ. Сайд дагасан төрийн албан хаагч нарын тогтворгүй байдал хэвээр л байна. Яаж энэ төрийн албыг тогтвортой байлгах юм бэ?

Бид мянга энд хууль батлаад, энэ баталсан хуулийн чинь дунд болоод анхан шатанд хэрэгжүүлдэг төрийн албан

хаагч нар чинь ур чадваргүй, төрийн албан хаагч нар чинь дарга дагасан халаасны улсууд очоод байвал энэ мянга баталсан хууль чинь хэрэгжихгүй. Тийм учраас энэ анхан шатанд төр чадварлаг байя, төр бат бэх сайн ур чадвартай байя гэвэл энэ чинь анхан шатын энэ төрийн албан хаагч нараа л чадавхжуулах, тогтвортой байлгах асуудал шүү дээ. Энийг та ер нь цаашидаа хэрвээ ТАЗ-ийн гишүүнээр сонгодог бол энэ тогтвортой байх тал дээр нь хэрхэн яаж анхаарч ажиллах вэ гэдгийг асууя.

Нөгөө талаар Пүрэвдагвыг бас сайн танина. Яалт ч үгүй л энэ төрийн албанд мерит зарчмаар ажиллаж байгаа боловсон хүчнүүдийн нэг. Мөн адилхан энэ ТАЗ-өөр сонгогдож ажиллавал бас энэ хараат бус байх энэ тал дээрээ хэрхэн, яаж ажиллах вэ? Төрийн албыг улс төрөөс хараат байх бид нар яриад байдаг хэр нь амьдрал дээр энэ байдал чинь үргэлжилсэн хэвээр байгаа шүү. Тэгээд хэн нэг даргын дохиогоор гэдэг юм уу, хэн нэг даргын үүргээр ингээд ажиллаад байвал энэ төрийн алба чинь цэвэршиж чадахгүй. Харин ч энэ Баатарзориг дарга өнгөрсөн хугацаанд энэ Ардчилсан нам ч эрх барьж байхад, Ардын нам ч эрх барьж байх үед бол нэлээн хатуу ажилласан гэж ингэж ойлгож байгаа. Төрийн албыг улс төрөөс хараат байлгах дарга нараас хараат байлгах хараат бус байлгах гэж нэлээд оролдож ажилласан. Гэхдээ бүрэн гүйцэд чадаагүй. Энэ тал дээр Пүрэвдагва гишүүн яаж анхаарал хандуулж ажиллах вэ? Хараат бусаар яаж ажиллах, ажиллая гэж бодож байна вэ? Нөгөө талаас өнөөдөр төрийн албан хаагч нар хүний нөөцийн дутагдалд орчихсон, анхан шатан дээр ажиллах хүн олдохгүй байна. Сонгон шалгаруулалтад орсон хүн олдохгүй байна. Тэр та нарын шалгалт.../минут дуусах/

**Г.Занданшатар:** Балжиннямын Баярсайхан гишүүн асуулт. Асуулт 85, нэр дэвшигч Цэдэвсүрэн.

**Л.Цэдэвсүрэн:** Эрхэм хүндэт Улсын Их Хурлын гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Төрийн албанд бүх шатны, тэгэхдээ ерөнхийдөө дийлэнхдээ төрийн захиргааны албан тушаалд энэ түр орлон гүйцэтгэгч гэдэг албан тушаалтнууд бол нэлээдгүй байгааг бол бид нар бас судалгаагаар гаргаж ирсэн. Төрийн албаны тухай хуульд хэрвээ сул орон тоо гараад сонгон шалгаруулалт хийгдээгүй тохиолдолд ижил түвшний албан тушаалтан эсвэл тухайн нэгжийн хамгийн ойр чиг үүргийг нь гүйцэтгэдэг албан тушаалтан тухайн албан тушаалыг түр орлон гүйцэтгэж болно гэсэн ийм заалт байдаг. Таны асууж байгаагаар юу гэдэг юм яамдын ТНБД, газрын дарга нарын хувьд бол Яамны эрх зүйн байдлын хууль, Агентлагийн эрх зүйн байдлын хуулиудад бас сонгон шалгаруулалт болох хүртэлх хугацаанд түр орлон гүйцэтгэгчийг томилж болох ийм зохицуулалтууд нь өнөөдрийг хүртэл бол байгаа. Тэгээд энэ хүмүүс бол хуулиараа ямар үүрэг хариуцлага хүлээх вэ гэдэг нь хууль болон ЗГ-аас баталсан журам дээр байгаа. Тэр хүн түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалынхаа бүх хариуцлагыг хүлээнэ. Чиг үүргийг нь хэрэгжүүлнэ, хариуцлагыг нь хүлээнэ. Давхар өөрийнхөө үйл ажиллагааг бас явуулдаг ийм зохицуулалттай.

ТАЗ-ийн гишүүнээр ингээд хэрвээ томилогдоод ажиллах тохиолдолд энэ төрийн албан хаагчдын бүх шатны түвшний сонгон шалгаруулалтыг тухайн хүний яг ур чадварыг нь бий болгож гаргаж ирж чадах хэмжээнд нь хүртэл аваачъя гэж бас бодож байгаа. ТАЗ-өөс бүх сонгон шалгаруулалтуудыг цахим болгосон нь хэдийгээр маш сайн дэвшилттэй, хараат бус болгосон нь сайн боловч нөгөө талаасаа яг сонгон шалгаруулалтад орж байгаа хүн маань хүний маань ур чадвар бүрэн гүйцэд гарч ирж чадаж байна уу, үгүй юу гэдэг дээр бас нэлээн шүүмжлэл байгаа. Тэгээд энэ дээр бол анхаарч ажиллана.

Төрийн албан хаагчдыг тухайн ажлын байранд нь чадварлаг хүмүүсийг тогтвортой ажиллуулах тал дээр бас нэлээн анхаарч ажиллана. Тэгэхдээ мэдээж тогтвортой гэдэг нь түрүүний Дамдинням гишүүний хэлж байгаагаар олон жил гэдэг агуулгаар нь биш, тэр хүний ажлын гүйцэтгэл, ур чадвар, бүх зүйл, сэтгэлгээ нь, хандлага, ёс зүй нь хэрвээ сайн байх юм бол тухайн албан тушаал дээр нь тогтвортой ажиллуулах, ямарваа нэгэн улс төрийн нөлөөлөл оруулахгүй байх тал дээр бол би нэлээн санаачилгатай бол ажиллана гэж бодож байгаа.

**Г.Занданишатар:** 84 Пүрэвдагва.

**Б.Пүрэвдагва:** Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 8 дугаар заалтад Зөвлөлийн үйл ажиллагаанд ямарваа нэгэн албан тушаалтан нөлөөлөхийг, хөндлөнгөөс оролцохыг хориглоно гэсэн заалт байгаа. Ийм учраас би хэрвээ ТАЗ-ийн гишүүнээр сонгогдох юм бол хуулиа хэрэгжүүлж, хараат бус бие даасан байдлыг, ямар нэгэн улс төрийн нөлөөнд орохгүй нөлөөлөлд орохгүйгээр ажиллана гэдгийг бол илэрхийлж байна. Баярлалаа.

**Г.Занданишатар:** Балжиннямын Баярсайхан гишүүн.

**Б.Баярсайхан:** Ялангуяа энэ өнгөрч байгаа 4 жилийн хугацаанд төрийн албыг ёс зүйжүүлэх, мэргэжлийн түвшинд ажиллуулах, зан чанарын хүмүүжилтэй, хүмүүсийг ялгаварладаггүй яг тэр үйлчилгээ төрийн албан хаагч тэр public servant гэдэг үгэндээ яг тэр тохирсон үйлчилгээг ард түмэнд үзүүлдэг ийм ёс зүйтэй, ашиг сонирхол хардаггүй, ёс суртахуунтай ийм төрийн албыг төлөвшүүлэх гэж Улсын Их Хурал, ЗГ маш олон чухал шийдвэрүүдийг гаргасан.

Хамгийн сүүлд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг бас санаачлан өргөн барьсан гишүүний хувьд

ТАЗ дээр Ёс зүйн хороогоо 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, ингээд Ёс зүйн хороотой жинхэнэ мэргэжлийн ийм төрийн албыг Монгол Улсын хэмжээнд төлөвшүүлэн ажиллах ийм зорилго тавиад явж байгаа. Миний байнга хэлдэг нэг асуудал байгаа. Өнөөдөр төрийн Монголын төрийн албанд 2 маш жигшмээр нэг ийм асуудал байдаг. 1 дүгээрт нь хариуцлага алдсан, ёс зүйн хариуцлага алдсан, ямар нэгэн байдлаар ашиг сонирхол авлигад өртсөн ийм хүмүүс төрийн албанаас бүүр насаараа явах ёстой. Гэтэл дараа дараагийнхаа шатанд дарга цэрэг хийгээд ингээд салбар салбараас шимэгч хорхой шиг ингээд идээд явж байгаа ийм хүмүүс нийт ажиллаж байгаа нэр төртэй, хэдэн үеэрээ төрийн албанд зүтгэж байгаа энэ хүмүүсийн нэр хүндийг унагаасан, төрдөө итгэх ард түмний итгэлийг үгүй хийсэн ийм үйлдлүүдийг удаа дараа гаргасаар байгаа. Энэ асуудалтай болбол 2 нэр дэвшигч маань ажлаа жинхэлж аваад тэмцэнэ гэдэгт бол итгэж байна. Энэ тал дээр бас та бүхнээс шаардаж ажиллах болно.

2 дугаарт энэ сайд, улс төрч, нутаг усныхны нэрийг барьсан энэ төрийн албан, албанд ирж байгаа энэ бардам, энэ авлига, ёс зүйн хувьд үнэхээр бүүр бодит ийм үйлдлүүдийг гаргадаг энэ дунд шатны энэ төрийн албан хаагчдыг хэзээ бид нар цэвэрлэх вэ? Тэгээд хариуцлага тооцох гэхээр улс төрчдийн нэрийг бариад ингээд суучихдаг. Энэ асуудал ерөөсөө цэгцрэхгүй байна шүү дээ. Нэг сайд томилогдоход ерөөсөө тэр сайдын нутаг усныхан энэ яамнуудаар дүүрч байна. Би БСШУСЯ-ны ТНБД-аар ажиллаж байхдаа 5 сайд сайдын нүүр үзэж ажиллаж байсан. Энийг бол төрийн албанд бүүр бодит байдаг юм байна гэдгийг бол бараг ном зохиол бичих түвшинд ингээд туулсан хүний хувьд энэ чадваргүй, тэгсэн мөртөө баг бүрдүүлэх нэрээр яам тамгын газрыг дүүргэж байгаа энэ нөгөө олон жил ажилласан төрийн албан хаагчид нь бүүр усны шувууд гээд нэрлэхсэн тийм ээ. Энэ асуудлуудыг цэгцлэх хэрэгтэй байна.

Тэгээд л 4 жил юм уу, 2 жил ингээд л ирж самарч, самарч байгаад л ингээд л нэг баахан идэж ууж байгаад л ингээд явдаг. Энэ асуудлыг цэгцлэх хэрэгтэй байна.

Тийм учраас Цэдэвсүрэн даргын хувьд, Пүрэвдагва даргын хувьд энэ асуудлыг зоригтой, ёс зүйтэй, хэний ч урдаас хараад энэ төрийн албаа хамгаалдаг, цэвэршүүлэхэд өөрсдийнхөө бүхий л хүч чадлыг дайчлан ажиллах ийм нэр дэвшигч нар гэж бодож, итгэж миний хувьд бол дэмжиж байна. Тэгээд энэ 2 асуудлыг маш онцгой анхаарч ажиллаарай. Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны гишүүний хувьд энэ асуудлыг олон удаа дуугарч байгаа, тууштай дуугарч байгаа хүний хувьд та 2-ыг ажлаа авсны дараа бас хамтран ажиллах болно, энэ тал дээр үр дүн гаргахад бас дэмжин ажиллах болно гэж илэрхийлье. Тэгээд амжилт хүсье.

**Г.Занданшатар:** Салдангийн Одонтуяа гишүүн.

**С.Одонтуяа:** Тэгэхээр энэ 2 нэр дэвшигчийг хоёуланг нь бас дэмжиж байна. Хоёулангтай нь бас их нэлээд олон жил бас хамтарч ажиллалаа. Ялангуяа Пүрэвдагвын хувьд бол Улсын Их Хурлын Тамгын газарт бас сүүлийн 3 жил ажиллалаа. Ажилдаа нэлээд хариуцлагатай ийм бас залуу хүн. Тэгээд энэ төрийн албанд ялангуяа энэ манай Улсын Их Хурлын үйл ажиллагаа, боловсролын салбарт бас нэлээд олон жил ажилласан ийм туршлагатай, тэгээд үүрэг даалгавар өгөхөд бас чанартай сайн гүйцэтгэл сайтай биелүүлдэг ийм залуу байгаа. Тийм учир бас би бас энэ ТАЗ-д очоод хариуцлагатай сайн ажиллах болов уу гэж бодож байна. Ер нь залуучууд бол энэ аливаа газар очихдоо нэг ер нь өөрийнхөө хэмжээнд нэг реформ хийчихье гэсэн ийм зорилгоор очиж байх ёстой. Өнөөдөр дэлхий ертөнц бол шал өөр болж байна. Маш хурдтай байна. Цахим ертөнц бол цахим хөгжил бол нэлээд хурдацтай хөгжихийг бол бид нарт боломж олгож байна. Тийм учраас

одоо би энэ байгууллагад шинээр ирснээр энэ байгууллагад ямар дэвшилттэй реформын ийм зүйл хийж чадах вэ гэдгээ бодож, төлөвлөж ажиллаж байх ёстой.

Цэдэвсүрэн даргатай бол бид бас олон жил ажилласан. Тэгээд энэ боловсролын салбар хэд хэдэн судалгаа дээр, ялангуяа энэ сургуулийн хүүхдийн асуудал дээр ажиллаж байхад юманд бас их хариуцлагатай ханддаг. Тэгээд энэ ТАЗ дээр манайхан бас хэлээд байна шүү дээ. Ер нь нэг жоохон шинэлэг маягаар ажиллахгүй бол ер нь энэ манай Монголын төрийн алба бол их хоцрогдсон. Би нэг дарга гэсэн ийм юугаар дандаа ханддаг. Бид бол төрийн албан хаагчид гэдэг чинь татварын мөнгөөр цалинждаг, энэ ард иргэдэд үйлчлэх ёстой гэдэг ийм хандлагаар бол хандах ёстой юм. Тэгээд 2 нэр дэвшигчид амжилт хүсье.

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн.

**Л.Энх-Амгалан:** Нэр дэвшиж байгаа Пүрэвдагва, Цэдэвсүрэн нэр дэвшигч нарт бол амжилт хүсье. Чадварлаг бас ийм хүмүүс нэр дэвшиж орж ирж байна. Тэгээд энэ Сингапурын хөгжлийн нууц яг юундаа байв гэж энэ Сингапурын хөгжлийн эцэг Лин Куан Ю-наас асуусан нэг асуулт байдаг. Тэгэхээр Сингапур хөгжсөний хамгийн нууц нь болбол Сингапурын төр бол хамгийн шилдэг улсуудаа Сингапурын төрд зүтгүүлсэн учраас Сингапур хөгжсөн юм гэсэн ийм хариулт өгсөн байдаг юм. Тэгэхээр өнөөдөр Монгол Улс хөгжсье, дэвшье гэж байгаа болбол Монголын хамгийн шилдэг залуучуудаа Монгол төрийн албанд зүтгүүлдэг, тэрийг нь үнэлдэг ийм үнэлэмжтэй байж Монгол Улс хөгжинө, дэвшинэ гэж ойлгож байгаа. Тэгэхээр Цэдэвсүрэн ТНБД-ын хувьд болбол Боловсролын багц хууль, томоохон багц хуулийг бол ахалж, ажлын хэсэгт нь орж ажиллаж боловсруулсан хүн. Тэгэхээр энэ Боловсролын багц хуулиар болбол боловсролын энэ томилгоог бид нар

жинхэнэ утгаар нь мерит мэргэшсэн зарчмаар явуулах энэ зарчмыг бид нар баталж чадсан.

Өнөөдөр хамгийн шилдэг багш нь сургуулиа удирдах, хамгийн шилдэг сургуулийн захирлууд аймгийнхаа Боловсролын газар, цаашилаад Боловсролын яамандаа ирж ажиллах энэ боломжийг бид нар эрх зүйн үндэснүүдийг нээсэн. Гэтэл харамсалтай нь нөгөө талаараа энэ Төрийн албаны тухай хууль гэдэг энэ хуулиа бид нар эргэж харахгүй болбол энэ цаг үеийнхээ эрэлт хэрэгцээ шаардлагыг хангахаа больсон байна. Энэ бол магадгүй манай хөгжлийн бас нэг чөдөр тушаа болчихсон байгаа нэг ийм хууль байгаад байна. Яг амьдрал дээр. Би ч мэдэж байгаа, та ч мэдэж байгаа. Тийм учраас ТАЗ-д орж энэ зөвлөлд орж ажиллах гэж байгаа хүн анхны ажлаа ер нь энэ салбарынхаа сая эхэлсэн энэ шинэчлэлийг төрийн бүх салбарт хийх энэ шинэчлэлийг бол цаг алдалгүйгээр хийх ийм хүндтэй, бас хариуцлагатай үүрэг танд ноогдож байна гэж бас би хэлэхийг хүсэж байгаа.

Тэгээд та бас сайн мэдэж байгаа. Бид нар ингээд энэ ОУБ-д ажиллаж байсан, олон улсын төсөл, хөтөлбөр дээр ажиллаж байсан энэ залуучуудыг төрийн албанд зүтгүүлэх гэхээр ингээд нөгөө тавьдаг шалгуур нь хүрдэггүй. Тэгээд Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ Олон улсын төсөл, хөтөлбөрт олон жил ажилласан залуучуудтай уулзаж төрийн албанд орооч, ажиллаач гэж хүсэхэд нөгөө энэ шалгуур хангахгүй байна гэдэг нэг ийм зүйлүүдийг ярьдаг. Өнөөдөр АХБ, Дэлхийн банканд салбаруудын бодлогын асуудал хариуцсан залуучууд, шилдэг менежер залуучууд Монголын төрд орж ирэх ийм боломжгүй болчихсон, хаалга нь хаалттай байгаа. Тэгэхээр энэ хаалгыг нээх ёстой. Энэ чөдөр тушааг бид нар тайлах ёстой. Энэ ажил бол таны бараг эхний өдөр энэ ажил авсан өдрөөс эхлэх болов уу гэж 1 дүгээрт бодож байгаа.

2 дугаар асуудал та бас өөрөө мэдэж байгаа. Энэ ТАЗ нь мэргэжил гэдгийг зөвхөн боловсролын бакалаврын түвшинээр авч үздэг. Гэтэл өөрөө төрийн удирдлагын менежмент гэдэг юм уу, бизнесийн менежментээр магистр хийчихсэн хүний мэргэжлийг энд тооцдоггүй. Докторын мэргэжлийг нь энэ мэргэжил гэж тооцдоггүй нэг ийм марзан юм бий болчихоод байгаа байхгүй юу. Танай бакалавр чинь өөрөө бакалавраа төрийн удирдлагаар хийгээгүй байна гэж хэлдэг. Үгүй ээ гэтэл миний магистр төрийн удирдлагаар байна гэхээр энэ хамаарахгүй гэсэн нэг ийм үзэмжээр хандаж байгаа ийм марзан зүйл байгаа. Энэнээс болж манай хэд хэдэн газрын дарга нар үүрэг гүйцэтгэгч байсан нөхдүүд бол бас шүүхийн байгууллагад хандаж, шүүхээс тодорхой шийдвэрүүд гарсан байгаа. Гэтэл энэ шүүхээс шийдвэр гарчхаад байхад ТАЗ нь өөрөө ингээд тайлбар хэлээд, шүүхийн гарсан шийдвэр дээр цагаан дээр хараар бичсэн зүйлүүд дээр тайлбар хэлээд сууж байдаг нэг ийм арчаагүй, хөндлөнгөөс харах юм бол энэ чинь их арчаагүй зүйл шүү дээ. Тэгээд ийм нөхцөл байдал өнөөдөр Монголын төрийн албанд ТАЗ-д байгаа учраас энэ зүйлүүдийг арилгах, энэ манлайлал, энэ эрмэлзэл, энэ мэдлэг, энэ ур чадвар бол би танд байгаа гэж итгэж байгаа. Тэгэхээр энэ ажлуудыг бас манлайлж, ингэж хийж, Монголын төр хамгийн чадварлаг залуучуудад нь орох энэ үүд хаалгыг нээх ёстой шүү л гэж би ойлгож байгаа юм. Тэгэхээр энэ зүйлүүдээ бас нэлээн манлайлал үзүүлж ажиллаарай гэж хэлэхийг хүсэж байна. Ингээд танд ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

**Г.Занданшатар:** Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн.

**Б.Энх-Амгалан:** Нэр дэвшигч Цэдэвсүрэн, Пүрэвдагва нарт ажлын амжилт хүсье. Дэмжиж байгаа. Өмнө нь ТАЗ-ийн даргаар ажиллаж байсан Баатарзориг дарга болбол бас идэвхтэй сайн ажилласан. Тэр хүн болбол бас хууль

зөрчсөн төрийн албан хаагчдыг шалгаж дүгнэлт гаргаж, асуудлыг шийдвэрлэх гэж оролдож байсан юм. Манай ТАЗ тэгээд дээр нь энэ төрийн аудит хоёрт 1 шүдгүй арслан гэдэг шиг чаддаггүй нэг зүйл байна. Хууль зөрчсөн байна гээд дүгнэлтээ гаргаад явуулаад тэр хүнийгээ халж чаддаггүй, сольж чаддаггүй. Энэнээс болоод асуудал үүсдэг. Тэр нөхөр нь тэгээд байж л байдаг. Тэгээд төрийн албан хаагч гэдэг нэг тийм том нэр томъёоныхоо ард ингээд л нуугдаад л байж байдаг. Тэр хуулийнхаа ард ингээд л хамгаалалттай л байж байдаг. Тэгээд 1 зүйл байгаа юм л даа. Төрийн албанд ажиллаж байгаа энэ дунд шатад, доод шатад ажиллаж байгаа энэ нөхдүүд чинь болбол наад сайд, дарга нар чинь явна, би бол байж байна шүү. Тийм учраас за, за гэж хэл, заавал биелүүлэх албагүй гэдэг ийм зарчим барьдаг. Тэгээд сүүлд нь хуулийн харууцлага хүлээх болоод ирэхээр зэрэг дээш нь заачихдаг. Тэр дарга, энэ сайд, тэр ингэж хэлсэн учраас би энийг хийсэн юм гээд. Өөрийнхөө асуудлыг бусад руу чихчихдэг ийм нэг буруу жишиг тогтоож байгаа юм. Тэгэхээр энийг болбол халах зайлигүй шаардлагатай.

Би танд нэг зүйлийг хэлье. Энэ Говь-Алтай аймгийн Засаг дарга 180 гаруй хүн халсан юм билээ. 120 гаруй хүнийг буцааж ав гэдэг үүрэг даалгаврыг ТАЗ-өөс өгсөн, буцааж аваагүй. Тэгээд шүүх, цагдаагаар явдаг, шүүх, цагдаагаар яваад нөгөөх нь буруутай нь тогтоогдоод буцаад ажилдаа очих гэхээр дахиад авдаггүй, аваад маргааш нь халчихдаг. Ийм нөхцөл байдал байгаа учраас энийг цаашидаа болбол онцгой анхаарч ажиллахгүй болбол энэ төрийн албаны чинь чадамж сулраад, төрийн албанд итгэх итгэл буураад, тэгээд хэн дарга байна тэр хүний үед л ажиллаж амьдарч авъя. Тэгээд бусад цаашиаа болбол яах нь өөрөө мэдэг гэсэн ийм байдал руугаа орох юм байна лээ шүү.

Дараа нэг дараагийн нэг асуудал энэ үүрэг гүйцэтгэгч гэж юм авчраад тавьчихдаг. Тэр үүрэг гүйцэтгэгч болбол

хэдэн ч жилээр ингээд үүрэг гүйцэтгээд байгаад байж болдог нэг ийм юм руу орчхоод байна. Тэр шалгуурыг ерөөсөө хангаагүй нөхөр л байж байгаа байхгүй юу. Нэг улс төрчийн халаасны нөхөр эсвэл тэр улс төрчийн намынх нь сонгуульд явсан нөхөр ч байдаг юм уу. Тийм учраас энэ үүрэг гүйцэтгэгч гэдэг энэ орон тоог л алга болгох хэрэгтэй байгаа юм. Тодорхой хугацаанд байх ёстой бол байдаг л юм байгаа биз. Энэ чинь бол ковидын үеийн асуудал шүү дээ үүрэг гүйцэтгэгч гэдэг бол. Одоо ковидын үеийн Ковидын хууль чинь цуцлагдчихсан. Одоо бол үүрэг гүйцэтгэгч байж боломгүй байх юм.

3 дахь асуудал болбол чадалтай боловсон хүчин төрийн албанд ажиллах гэхээр янз янзын байдлаар шахаж дарамтлаад, тэгээд чи шаардлага хангахгүй, ингэхгүй, тэгэхгүй гээд, тэгээд өөрөөсөө тийм чадалгүй хүний дор ажиллах дургүй учраас тэгээд гараад явчхаж байгаа юм. Ингээд төрийн ажил ч чадамжгүй сул, ажлаа мэддэггүй, хүнд сурталтай, дахин, дахин нааш цааш нь явуулдаг ийм нөхцөл байдал руу ордог учраас энийг та бүхэн маань ээ дээ анхаарч ажиллаарай гэдгийг би бас хэлмээр байна. Тэгээд ажилд нь амжилт хүсье.

**Г.Занданшатар:** Баагаагийн Баттөмөр гишүүн. Энэний дараа санал хураалт явуулна, гишүүд чуулганы танхимд цуглая.

**Б.Баттөмөр:** Ингээд ТАЗ-ийн 2 гишүүн шинээр томилогдох юм байна. Урьд нь ажиллаж байсан энэ Баатарзориг дарга болбол их сайн ажилласан шүү. Энийг би хэлэх ёстой. Маш их олон шинэчлэлүүдийг, маш их олон зүйлүүдийг санаачилж хийсэн. Харамсалтай нь ТАЗ-ийн даргын эрх мэдэл хүрдэггүй ийм асуудлууд хуулийг гажуудуулдаг юм болбол маш их гарч байсан. Цэдэндамбаа докторын хувьд ч гэсэн болбол өнгөрсөн хугацаанд бол сайн ажилласан бас эрдэмтэн хүн. Тэгээд энэ 2 хүн ингээд томилогдож очих юм байна.

Тэгэхээр Төрийн албаны зөвлөл дээр болбол Ёс зүйн хороо сая Баярсайхан гишүүн хэлчихлээ. Ёс зүйн хороо байгуулагдаж ажиллаж байгаа. Баатарсайхан гэдэг даргатай. ТАЗ-ийн 5 хүн, дээр нь нэмэх нь орон тооны бус 4, ингээд 9 гишүүнтэй ийм Ёс зүйн хороо ажиллаж байгаа. Хороо байгуулагдаад үндсэндээ сар өнгөрөв үү, юу бүрэлдэхүүн нь бүрэн болоод нэг сар өнгөрөв үү хугацаа болж байна. Энэ дээр бас хэд хэдэн асуудлууд тулгамдсан байгаа. Яагаад энийг ярьж байна вэ гэхээр ТАЗ-ийн бас нэг хийх ёстой ажил энд явж байгаа шүү. Хамгийн 1 дүгээрт нь болбол энэ Ёс зүйн дэд хороод байгуулах ёстой. Монголын төрийн бүх байгууллагуудад ажиллах ёстой. Цаг хугацаа жоохон алдаж байгаа. Би бас сая 2, 3 хоногийн өмнө сануулсан. Энийг тэр Ёс зүйн хороо нь баталж ингэж цаашаагаа бүх газар мөрдүүлэх ёстой.

2 дахь асуудал энэ Төрийн албаны ёс зүйн хуульд заагдсан төрийн албан хаагчийг соён гэгээрүүлэх хөтөлбөр. Энэ дээр болбол бас ажлын хэсэг тэр хорооны орон тооны бас гишүүдээр ахлуулсан ийм ажлын хэсэг гарчихсан ажиллаж байгаа. Энэ ТАЗ дээр зайлшгүй хийгдэх хуульчилсан ийм асуудал шүү гэдгийг би хэлье гэж ингэж бодож байгаа юм. Энэ төрийн албаны, төрийн алба гэдэг болбол Төрийн албаны зөвлөл гэдэг бол манай энэ төрийн албаны маш том зөв, том бүтэц шүү дээ тэгээд байгаа. Тэгээд энэ яагаад ингэж хэлж байна вэ гэхээр энэ өнгөрсөн хугацаанд Монголын хөгжлийн энэ гажуудал, хоцрогдол энэ юутай холбоотой вэ гэхээр 2 хөрш бидэнтэй болбол маш сайхан харилцаатай байгаа. 3 дахь ертөнц бол Монголтой их сайхан харилцаатай, гадаад талдаа их сайхан харилцаатай. Яагаад энэ хөгжлийн хоцрогдол мухардал ингээд гарч байна гэхээр Монгол хүнтэйгээ холбоотой. Монгол улсууд Монгол хүмүүс Монгол улсаа хөгжүүлдэггүй.

Сая тэр Энх-Амгалан сайдын ярьж байгаа тэр Сингапурын Ерөнхийлөгчийн хэлсэн Сингапур яаж хөгжсөн бэ гэхээр хамгийн чадвартай хүмүүсийг л би авч ажиллуулсан гэж тэр Ерөнхий сайд нь хэлсэн байгаа байхгүй юу. Тэгээд Монголын төрд тийм чадвартай хүмүүс нь ажиллахгүй л байгаад байгаа байхгүй юу. Янз бүрийн тийм арын хаалга хийнэ, цүнх баригч нар энд тэнд томилогдсон байдаг. Тэгээд ажлаа хийдэггүй, ёс зүй байдаггүй, манлайлал байхгүй ийм л байдалтай болчихсон. Одоо энэ сайн чадвартай нь болбол гаднын компаниуд, гадагшаа явчхаж байна. Хувийн компаниудад ажиллачхаж байна. Чадвар муутай улсууд нь төрийн албанд ажиллаж байна шүү дээ. Ийм л дүр зурагтай байгаа юм. Тэгээд ер нь бол төрийн албаны, төрийн алба гэдэг маань бол юу вэ гэхээр ахмад, залуу, дунд, ахмад үеийн хослол байх ёстой юм. Дандаа залуучуудыг тавиад улс оронд хөгжинө гэж бол байхгүй. Мэдлэгээс гадна туршилага хэрэгтэй, ёс зүй хэрэгтэй. Тэр төрийнхөө төлөө зүтгэдэг чин хүсэл эрмэлзэл бол манай энэ зарим залуучуудад алга байна шүү дээ. Хэл аманд өртөж байна, авлигал авч байна, хулгай хийж байна. Тэгээд энийг сайн л бодож ажиллах ёстой байгаа юм л даа. ТАЗ-ийнхөнд эрх мэдэл нь хүрдэггүй асуудал байдаг юм шүү. Яагаад гэхээр шууд томилгоо хийдэг. Тэгээд түүн дээр нь дүгнэлт гарахаар тэрийг нь хэрэгжүүлдэггүй. Сүүлийн үед болбол яаж байна вэ гэхээр нэг хэл гол шалгуур гэж байгаа юм. Хэл болбол хүн ашиглах хэрэгтэй. Гол болбол асуудал болбол мэдлэг хэрэгтэй, туршилага хэрэгтэй, чин сэтгэл хэрэгтэй байгаа байхгүй юу. Тэгээд ийм, ийм зүйлүүд дээр.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна. Санал хураалт явуулна, гишүүд чуулганы танхимд цуглая. Байнгын хорооны саналаар эхлээд чөлөөлөх санал хураалт явуулна. Эхлээд Балдангийн Баатарзоригийг Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнээс

чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулна. Дараа нь Самдангийн Цэдэндамбыг Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнээс чөлөөлөх саналыг явуулна. Тэгээд дараа нь томилох санал хураалт явуулна. Пүрэвдорж гишүүн сууж бай.

Балдангийн Баатарзоригийг Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнээр гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Нууц санал хураалт явуулна. 56 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Самдангийн Цэдэндамбыг Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулъя. 58 хувиар санал дэмжигдлээ.

Томилох санал хураалт явуулна. Баярын Пүрэвдагвыг Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 54 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Лхагвын Цэдэвсүрэнг Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт. 58 хувийн саналаар санал дэмжигдлээ. Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнээс чөлөөлөх, томилох саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнийг томилох, гишүүнээс чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо. Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

17.24 цаг

**Ес. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Дараагийн асуудалд орно. Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Төслийн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ТББХ-ны дарга Нямаагийн Энхболд танилцуулна. Нямаагийн Энхболд танилцуулна.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг ТББХ-ноос боловсруулж, 2024 оны 1 сарын 16-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаараа хэлэлцлээ.

ТББХ Улсын Их Хурал дахь намын бүлэг, Байнгын хороо, хууль санаачлагчдын саналыг үндэслэн дараагийн ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын талаарх Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан, боловсруулан нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар батлах зохицуулалтын дагуу Байнгын хороодоос 39, Монгол Улсын Засгийн газраас 50, Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгээс 24, АН-ын бүлгээс 37, давхардсан тоогоор нийт 150 хууль, тогтоолын төслийн санал ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулахдаа Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлж түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 20 оны 2 дугаар тогтоол, Монгол Улсын

хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын 21 оны 12 дугаар тогтоол, Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай Улсын Их Хурлын 21 оны 106 дугаар тогтоол, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 23 оны 44 дүгээр тогтоол, Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоол, мөн Монгол Улсын Засгийн газрын 2000-аас 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр тусгасан хууль тогтоомжийн төслүүд болон батлах хугацааг нь хуульд тусгайлан заасан хууль, тогтоолын төслүүдийг тусгах зарчмыг баримтлан хэлэлцэх асуудлын жагсаалтад 44 хууль, тогтоолын төслийг тусгасан болно.

Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд хэлэлцүүлгийн шатдаа байгаа болон Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлбэл хэлэлцэх асуудлын дараалалд оруулах тухай асуудлыг тухай бүрд нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэхээр, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 20 оны 2 дугаар тогтоол, Монгол Улсын хууль тогтоомжийг 24 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолд тусгагдсан хууль тогтоомжийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлэхийг Монгол Улсын ЗГ-т даалгахаар зохицуулсан болно.



Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Монгол Улсын Их Хурлын Байнгын хороод, Монгол Улсын Их Хурал дахь намын бүлгүүд, Монгол Улсын Засгийн газар Оюун-Эрдэнэ, Монгол Улсын Их Хурлын Тамгын газар Энхбатад тус тус үүрэг болгосон болно. Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй. Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэсэн саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

**Г.Занданишатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу? Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүнээр тасалсан. Даваажанцангийн Сарангэрэл гишүүн.

**Д.Сарангэрэл:** Баярлалаа. Хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын дараалалд хэлэлцэх эсэх нь шийдэгдчихсэн Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл маань ороогүй байна.

**Г.Занданишатар:** Энх-Амгалан гишүүний дараа нь хууль эцэслэн батална.

**Д.Сарангэрэл:** Орохгүй юу тийм ээ? Баярлалаа.

### **Г.Занданишатар:**

Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн. Жигжидсүрэн Чинбүрэн.

**Ж.Чинбүрэн:** Миний асуух гэж байсан зүйл бас нөгөө ажлын хэсгийг нь ахалж байгаа Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих тухай хуулийн төсөл байсан. Сарангэрэл гишүүн сая асуусан учраас тодорхой боллоо.

**Г.Занданишатар:** Тэр хуулиа хэлэлцэх ёстой шүү. Цэндийн Сандаг-Очир гишүүн.

**Ц.Сандаг-Очир:** Харин тийм. Би бас Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль хэзээ хэлэлцэх юм бэ? Улсын Их Хурлын дарга бас өчигдөр, өнөөдөр ингээд л чуулганы танхим дээр бас хэлээд байгаа. Энэ мөрийн хөтөлбөр үйл ажиллагааны хөтөлбөрт орчихсон байгаа. Тэгээд энэ хууль хаврын чуулганаар ганцхан хэлэлцэхгүй бол энэ бүрэн эрхийн хугацаа дуусах гээд байдаг. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг хаврын чуулганы хэлэлцэх асуудалд оруулж өгөхгүй юм уу?

**Г.Занданишатар:** ТББХ-ны дарга Нямаагийн Энхболд гишүүн.

**Н.Энхболд:** Саяынхтай адилхан хариулт бараг өгнө дөө. Энэ урьд нь нөгөө Их Хурлаас гарсан тогтоолууд, ЗГ-ын мөрийн хөтөлбөрт орсон арга хэмжээнүүд чинь хэрэгжүүлэх жагсаалт эд нар дотор багтчихсан байгаа зүйлүүд бол хэлэлцэгдээд л явна л гэсэн үг. Түүн дотор Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн асуудал байж байгаа гэж ойлгож байна.

**Г.Занданишатар:** Шадар сайд Амарсайхан сайд, Түгжрэлийн сайд Борхүүгийн Дэлгэрсайхан сайд нар энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой өргөн барихгүй бол одоо хаврын чуулган, хаврын чуулганаар өргөн бариад хэлэлцүүлэхээр

ер нь ойлголцлоо шүү энэ асуудлыг. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Сууж байгаарай. Тэгэхээр энэ хаврын чуулганаар хэлэлцэх асуудлаа батлахын өмнө бас энэ гадна сэтгүүлч нар маш их асууж байна. Намрын чуулганаар та нар юу хийсэн юм бэ гэдэг юм ярьж байгаа. Тэгэхээр ер нь бол бид нар энэ намрын чуулганаар хийсэн ажлаа бас тодорхой энэ ард түмэндээ хэлэх ёстой гэж би бодож байна. Хаврын чуулганаар баталсан намрын чуулганы хэлэлцэх асуудлыг бүгдийг нь бид нар хэлэлцэж дууссан. Дээрээс нь ЗГ энэ нийгэмд болж байгаа асуудлыг тухай, тухай асуудлаар нийгэмд ингээд л олон хүүхдийн асуудал ч юм уу, янз янзын хулгай зэлгээний асуудал гарахад гарлаа гэхэд Эрүүгийн хуулийг чангалах ч юм уу, хүүхдийн эрхийг илүү сайжруулах талаар ч юм уу, маш их олон асуудлыг энэ нийгэмд болж байгаа асуудалтай холбогдуулан оруулж ирсэн. Тэр болгоныг чинь манай энэ парламент бүгдийг нь баталж өгсөн.

Тэгээд өнөөдөр ингээд бүх хуулиудыг чинь ЗГ-ын оруулж ирж байгаа бүх хуулиудыг чинь бүгдийг нь баталж өгөөд, эрх зүйн орчныг нь хийж өгөөд, тэр Эрүүгийн хуульд, хууль дээр нь тэр албан тушаалтнуудын ялын асуудлыг улам чангаруулаад ийм олон, олон хуулиудыг бид нар баталж өгч байгаа. Тэгээд яг энэ нийгэмд асуудал үүсээд жишээ нь тэр Дорноговийн хүүхдийн асуудал гарангуут л бид нар тэр ялыг нь чангаруулах асуудлыг нь, дээрээс нь юу байдаг юм тэр хүүхдийн эрхийг хамгаалах талаар асуудлыг нь бид нар бүгдийг нь батлаад өгчхөж байгаа. Тэр хооронд нөгөө Их Хурал руу хуулийг нь оруулаад чангалаад өгчихсөн гээд засгийн, ард иргэд тайвширчихна. Тэгээд бид нар хууль баталж өглөө гээд буцаагаад тэрнийх нь дагуу ерөөсөө энэ гүйцэтгэх байгууллагууд чинь ерөөсөө ажил хийхгүй байна шүү дээ. Тэгэнгүүт нийгмийн бухимдал хэвээрээ байгаад байгаа байхгүй юу. Тэгээд яадаг гэхээр нөгөө 76 гэдэг ийм яриа гаргадаг ийм

зүйлүүд чинь байгаад байна. Бид нар энэ нүүрсний хулгай янз янзын асуудлууд гарсан. Түүн дээр чинь бид нар энэ Эрүүгийн хуулиудыг маш их чангаруулж өгсөн.

Гэтэл өнөөдөр тэр энэ Эрүүгийн хуулиар чангаруулсан тэр асуудлаар ямарваа нэгэн тийм хулгайн асуудлыг шийдвэрлэсэн үү, шийдвэрлээгүй. Энэнээс чинь болоод нийгмийн бухимдлууд гараад байгаа байхгүй юу. Тийм учраас энэ парламент бол тодорхой энэ хууль батлах энэ үүргээ хангалттай сайн биелүүлж байгаа. Хамгийн гол нь хэрэгжилт дээр энэ Засгийн газар, яам, агентлаг, аймаг, сумд, түүний удирдлагууд хангалттай сайн ажиллах ёстой шүү л гэдгийг би хэлмээр байна.

**Г.Занданшатар:** Гишүүд үг хэллээ. Энэ гишүүдийн хэлж байгааг бас сайд нар онцгой анхаарч ажиллах шаардлагатай. Энэ хаврын чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад бас энэ татварын реформ хийх асуудал орно. 2023 оны 2 дугаар сард Улсын Их Хурлын даргын 37 дугаар захирамжаар татварын орчинд дүн шинжилгээ хийх, нийгэм, эдийн засагт үүсээд байгаа эргэлзээтэй асуудлыг судалж, санал, дүгнэлт боловсруулах, шаардлагатай бол татварын суурь реформ шинэчлэлт хийх ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хороон дарга Ганзоригийн Тэмүүлэнгээр ахлуулж байгуулсан. 2023 оны 2 сард. Тэгэхэд 9, 10 сард энэ НӨАТ, татварын реформтой асуудал орж ирээгүй. Ийм учраас 2023 оны 10 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын гишүүнээр гишүүн Ганзоригийн Тэмүүлэнгээр ахлуулсан, 7 гишүүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Тэгээд ажлын хэсэг энэ хугацаанд нийтдээ 15 уулзалт мэргэжлийн болон чиглэлийн 12 холбоотой уулзалт хийж, нийт 300 орчим татвар төлөгчийн төлөөлөлтэй уулзаж, хууль эрх зүйн орчин, хөрөнгө оруулалтын орчин, бизнесийн орчны талаар, үүсээд байгаа хүндрэл

бэрхшээлийн талаар асуудлын шалтгаан, цаашид авах арга хэмжээний талаар санал солилцож, одоогийн байдлаар 100 гаруй ажил хэрэгч саналыг хүлээж аваад ингээд төсөл боловсруулж байгаа.

Тэгээд татвар төлөгчдөөс ирүүлсэн саналаас хамгийн их тулгамдаж байгаа асуудал бол энэ татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор гарсан хэм хэмжээний актууд нь татварын хуулиасаа давсан байдаг. Төрийн байгууллагаас тогтоосон өндөр хэмжээний үйлчилгээний зохицуулалтын гэх нэртэй төлбөр хураамжууд үнэ хөлс нь болбол татвараас ялгалгүй татварын ачааллыг, нэн ялангуяа үндэсний үйлдвэрлэгч дээр ноогдуулж байгаад, татварын зардлыг нэмэгдүүлж, бизнесийн орчны хүндрэл чирэгдэл үүсгэж байгаа талаар саналаа илэрхийлсэн. Ийм учраас татварын реформыг 3 үе шаттай хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөж ажиллаж байна. Сая эхний ээлжид Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүд баталсан. Энэ тогтоолоор ААНБ, бизнес эрхлэгчид, иргэдээс, иргэдэд татвараас дутуугүй санхүүгийн ачаалал, хүнд суртал чирэгдэл үүсгэж байгаа энэ төрийн байгууллагуудын шаардлагагүй үйлчилгээний, зохицуулалтын гэх мэтчилэн үнэ хөлс, төлбөр хураамж, түүний зохицуулалтыг татварын хууль тогтоомжид нийцүүлэх, хууль тогтоомжид нийцээгүй 800 гаруй төлбөр хураамж үнэ хөлсийг хүчингүй болгох арга хэмжээ авах талаар Улсын Их Хурлын тогтоолыг сая баталж, Засгийн газарт чиглэл өгсөн. Энэ бол татварын реформын эхний үе шат гэж хэлж ойлгож байна.

Ингээд үндэсний үйлдвэрлэлээ дэмжсэн, ажлын байрыг бий болгосон, бизнесийн, хөрөнгө оруулалтын таатай орчин бий болгох, татварын цогц реформ хийх ажлыг ирэх хаврын чуулганаар хэлэлцэнэ. Ажлын хэсэг

Тэмүүлэн дарга энэ 2, 3 дугаар үе шатдаа сайн хэлэлцүүлэг хийж, сайн бэлтгэл хийх ёстой шүү гэдгийг би бас энэ таширамд онцлон тэмдэглэе. Хөрөнгө оруулалтын орчин, татварын орчин бол эхлээд дотооддоо энэ бизнес эрхлэхэд ээлтэй таатай орчин бүрдүүлэх шаардлагатай байна. Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 65,4 хувийн саналаар санал дэмжигдэж, тогтоолын төсөл батлагдлаа.

17.8 цаг

### **Арав.Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах**

Дараагийн асуудалд орно. Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батална. Ингэж байж Улсын Их Хурлын чуулган завсарлана. Нийт 33 төслийг эцэслэн батална. Чинзориг, Содномын Чинзориг гишүүн горимын санал. Чинзориг гишүүн горимын саналаа хэл, хэл, тийм микрофон чинь өгчихсөн байна, горимын санал. 2 сарын 10 хүртэл чуулган сунгаж хуралдъя гэсэн Чинзориг сайд саналаа хэл. Хэлэлцэх асуудалдаа оръё. Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн, холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүд. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Төмөр замын тээврийн тухай хууль хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төмөр замын тээврийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Иргэний нисэхийн тухай хуульд

өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн, холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төсөл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т заасны дагуу хууль, тогтоол хуулийн төслийг Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хуулийн төсөл эцэслэн батлагдсанд тооцно гэж заасан байгаа. Энэ нийт гишүүний олонх буюу 39 гишүүнээс дээш саналаар хуулийг эцэслэн батална.

Ингээд 1 дүгээрт Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, Хүүхэд хамгааллын тухай хууль батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 82,7 хувиар 43 гишүүн дэмжиж, саналаар эцэслэн батлагдлаа.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулж байна. 43 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. 39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа. Оюунчимэг,

Жавхлан 2 гишүүн хоёулаа эсрэг гарч байна сая.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

8.Хууль зүйн туслалцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Гамшигаас хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хүүхэд хамгааллын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 48 гишүүн дэмжиж, хуулийн төсөл батлагдлаа.

Холбогдуулан боловсруулсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 49 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 47 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. 44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 47 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт

